# ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМНЫ 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ АРГА, ХЭМЖЭЭ | | | | | | | |
| 1.1.САЛБАРЫН ХУУЛЬ ТОГТООМЖ, БОДЛОГО, СТРАТЕГИ, ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛАХАД СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ, БОДЛОГЫН УДИРДАМЖААР ХАНГАХ, САЛБАРЫН САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН БОЛОН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН УРТ, ДУНД ХУГАЦААНЫ БОДЛОГО, ТӨЛӨВЛӨГӨӨ, ХУУЛИЙН ТӨСӨЛ, ТӨСӨВ БОЛОВСРУУЛАХ, БАТЛУУЛАХ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ТӨСВИЙН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ, САЛБАР ХООРОНДЫН УЯЛДАА, БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ, БАТЛАГДСАН ТӨСВИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ ТӨРИЙН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЭРХЛЭХ СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 2.5.6-ИЙН ХҮРЭЭНД: | | | | | | | |
| 1. | 1.1.1.Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн төсөлд ГБХНХЯ-ны саналыг тусгуулж, батлуулна. | үйл ажиллагааны зардал | Батлагдсан төлөвлөгөө /тоо/ | 0 | 1 | Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн төсөлд тус салбарын эрхлэх асуудлын хүрээнд салбарын 3, Төсвийн ерөнхийлөн захирагчийн 7, хөтөлбөрийн 12 хүрэх үр дүн, түүнийг хэмжих үзүүлэлт, хэрэгжүүлэх арга замыг тус тус тодорхойлж Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 01/3208 дугаар албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлэв.<br>Түүнчлэн Монгол Улсын 2026-2030 оны хөрөнгө оруулалт хөтөлбөрийн санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх шаардлагатай төсөл, арга хэмжээний жагсаалтад 2026-2030 онд хэрэгжүүлэх 3 төсөл, арга хэмжээ /нийт 174.0 тэрбум төгрөг/, 2026-2028 онд хэрэгжүүлэх 12 төсөл, арга хэмжээ /нийт 49.0 тэрбум төгрөг/-ний саналыг тусгасан.<br>Эдийн засаг, хөгжлийн яамнаас Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн төслийг салбар бүрээр нэгтгэн 2025 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | оны 10 дугаар сарын 30-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн.<br>Уг төсөлд салбарын 3, Төсвийн ерөнхийлөн захирагчийн 7, хөтөлбөрийн 17 хүрэх үр дүн болон хөрөнгө оруулалтын хөтөлбөрт 1 төсөл, арга хэмжээ /нийт 90.0 тэрбум төгрөг/ тусгагдсан байна.<br>Энэ удаагийн Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн төслийн гол онцлог нь зорилт, арга хэмжээг бус хүрэх үр дүнг Үндэсний, салбарын, төсвийн ерөнхийлөн захирагчийн болон хөтөлбөрийн гэсэн 4 түвшинд хэмжих үзүүлэлт, хэрэгжүүлэх арга замыг хамтад нь тодорхойлсноор салбар хооронд үйл ажиллагааны уялдааг сайжруулах, нөөцөө зөв хуваарилах, хөгжлийн тэргүүлэх чиглэлийг “том зургаар” харах боломжтой болсон юм. УИХ-ын 2025 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн нэгдсэн чуулганаар Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн төслийг баталлаа. | |
| 2. | 1.1.2.Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын 2025-2028 оны стратеги төлөвлөгөөг боловсруулж, батлуулна. | үйл ажиллагааны зардал | Хийгдсэн шинжилгээ /тоо/ | 0 | 2 | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын 2025-2028 оны стратеги төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийг ГБХНХ-ын сайдын 2025 оны 01 дүгээр сарын 13-ны А/06 дугаар тушаалаар байгуулсан. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар баталсан Стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлалын дагуу мандатын, орчны шинжилгээ хийж, стратеги төлөвлөгөөг боловсруулсан.<br>“Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын 2025-2028 оны стратеги төлөвлөгөө”-г Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны А/119 дүгээр тушаалаар батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3. | 1.1.3.Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний төсөлд ГБХНХЯ-ны саналыг тусгуулж, батлуулна. | үйл ажиллагааны зардал | Батлагдсан төлөвлөгөө /тоо/ | 0 | 1 | Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний төсөлд ГБХНХЯ-ны саналыг холбогдох газар, нэгжүүдээс авч нэгтгэн боловсруулж, 2025 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн 01/323 тоот албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн. Эдийн засаг, хөгжлийн сайдын 2022 оны А/167 дугаар тушаалаар батлагдсан “Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ын 4.4.-т заасны дагуу хийсэн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын нөхцөл байдлын дүн шинжилгээг урьдчилан цахимаар, дараа нь Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 03/1255 тоот албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлж, шаардлагатай мэдээлэл, судалгааг тухай бүр гарган өгч ажиллав.<br>Эдийн засаг, хөгжлийн яамнаас нэгтгэн боловсруулсан “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө”-ний төсөлд 2025 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн 01/1224 тоот бичиг, 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 01/1371 тоот бичгээр тус тус санал өгсөн.<br>Монгол Улсын Их хурлын 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн нэгдсэн чуулганаар Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлагдлаа. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4. | 1.1.4.Хөдөлмөрийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулна. | үйл ажиллагааны зардал | Боловсруулсан хуулийн төслийн тоо | 0 | 1 | Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судалгааг Хууль тогтоомжийн хуульд заасны дагуу хийж гүйцэтгэсэн. Судалгаатай холбоотойгоор Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулж Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүйн сайдаар батлууллаа. Батлагдсан үзэл баримтлалын хүрээнд Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан 2025 оны 5 дугаар сард яамдаас санал авч нэгтгэлээ. Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, холбогдох бусад баримт бичгийг Засгийн газрын хэрэглэх газарт 2025 оны 6 дугаар сарын 1-нд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүргүүлсэн. Засгийн газрын 2025 оны 6 дугаар сарын 4-ний өдрийн хуралдаанаар уг хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн барих нь зүйтэй гэж шийдвэрлэлээ.<br>-Хөдөлмөрийн тухай хуулийн зарим зүйл, хэсэг, заалтад нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулан санал ирүүлсэн зарим УИХ-ын гишүүнд хүргүүлэн, уулзалт зохион байгуулж, санал солилцов. | 100 |
| 5. | 1.1.5.УИХ-ын даргын 2024 оны 9 дүгээр сарын 103 дугаар захирамжаар байгуулагдсан “Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж, санал, дүгнэлт гаргах, холбогдох шийдвэрийн | үйл ажиллагааны зардал | Ажлын хэсэгт хүргүүлсэн саналын тоо | 0 | 1 | УИХ-ын даргын 2024 оны 09 дүгээр сарын 103 дугаар захирамжаар байгуулагдсан “Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж, санал, дүгнэлт гаргах, холбогдох шийдвэрийн төсөл боловсруулан танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэг”-т Хөдөлмөрийн тухай хуультай мэдээлэл, холбогдох судалгааг хүргүүлэн ажиллаж байна. Уг ажлын зарим гишүүдэд Хөдөлмөрийн тухай хуультай | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | төсөл боловсруулан танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэг"-тэй хамтрах ажиллаж, шийдвэрийн төсөлд санал хүргүүлнэ. | | | | | холбоотой мэдээлэл, too баримтыг 2025 оны 5 дугаар сард хүргүүллээ. | |
| 6. | 1.1.6.УИХ-ын даргын 2024 оны 9 дүгээр сарын 102 дугаар захирамжаар байгуулагдсан "Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай БНМАУ-ын хуулийг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг" –тэй хамтран ажиллаж, хуулийн төсөлд санал хүргүүлнэ. | үйл ажиллагааны зардал | Ажлын хэсэгт хүргүүлсэн санал /тоо/ | 0 | 1 | УИХ-ын даргын 2024 оны 9 дүгээр сарын 102 дугаар захирамжаар байгуулагдсан "Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай БНМАУ-ын хуулийг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг"-ийн хуралд 2025 онд 2 удаа оролцож мэдээлэл хийж, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас баримталж байгаа байр сууриа илэрхийлж мэдээллээ хүргүүллээ. | 90 |
| 7. | 1.1.7.Төгсөлтийн аргачлал туршилтын хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулах, үндэсний хэмжээнд нутагшуулах чиглэлээр зөвлөмж боловсруулна. | үйл ажиллагааны зардал | Зөвлөмж /тоо/ | 0 | 1 | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Төгсөлтийн аргачлалын туршилтын хөтөлбөрийг Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр Нийслэлийн 3 дүүрэгт туршилтаар 2022-2025 онд хэрэгжүүлсэн. Уг аргачлалыг үндэсний хэмжээнд нутагшуулахаар 2025 оноос журамд өөрчлөлт оруулан Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний нэг төрөл болгон нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай энэ хуулийн 3.1.2-т заасан өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах гэж нэрлэн үйлчилгээг хэрэгжүүлэх арга аргачлалыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 02 дугаар сарын | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 25-ны өдрийн А/53 дугаар тушаалаар батлагдсан журамд тусган хэрэгжүүлж байна.<br><br>Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, зорилтот түшингийн 2 дахь хэсэг, мөн Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд ядуурлын түвшинг 2 дахин бууруулна гэсэн зорилт туссан.<br><br>Мөн Монгол Улсын 2026 оны Төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар батлагдсан төсвийн хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтэд Хүнс, тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагдаж байгаа өрхөөс улсын хэмжээнд нийт 3000 өрхийн амьжиргааг дээшлүүлэх зорилт туссан. Иймд дээрх зорилт арга хэмжээтэй уялдуулан “төгсөлтийн аргачлалын туршилтын хөтөлбөр”-ийн загварыг ашиглаж зорилтот өрх иргэнийг чадавхжуулах ,тэдний амьжиргааг дээшлүүлэх хүрээнд “Төгсөлтийн аргачлал” хөтөлбөрийг 2026-2028 онд улсын хэмжээнд хэрэгжүүлэхээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 01/3923 тоот албан бичгээр Аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, ХХҮЕГ, аймаг дүүргийн ХХҮГ, хэлтэст зөвлөмж чиглэлийг хүргүүлэн хамтран ажиллаж байна. | |
| 8. | 1.1.8.Бага орлоготой өрхийн тогтвортой амьжиргааг дэмжих урт хугацааны хөтөлбөрийг аймаг, дүүрэгт туршилтаар хэрэгжүүлж, төсөлд хамрагдсан өрхийн | үйл ажиллагааны зардал | Амьжиргаа дээшилсэн өрхийн хувь | 71 | 80 | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Төгсөлтийн аргачлалын туршилтын хөтөлбөрийг Азийн хөгжлийн банктай хамтран хэрэгжүүлж буй буй “Цар тахлын үе хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл 2“-ын хүрээнд 2022 оны 7 дугаар сараас 2025 оны 8 дугаар сарыг дуустал буюу 36 сарын хугацаатайгаар хэрэгжүүлж байна. Уг | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | амьжиргааг дээшлүүлэх. | | | | | туршилтын хөтөлбөрийг нийслэлийн Сонгинохайрхан, Баянзүрх, Чингэлтэй дүүргийн хүүхдийн мөнгөн тэтгэмж, хүнсний эрхийн бичгийн хөтөлбөрт хамрагддаг 1,259 зорилтот өрхийн нийгмийн болон санхүүгийн чадавх, оролцоог сайжруулах цогц арга хэмжээнд хамруулан 80-аас багагүй хувийг нь бие даан тогтмол орлоготой болж, тогтвортой амьжиргаанд хүргэхийг зорьж байна.<br><br>Хөтөлбөрийн хүрээнд зорилтот өрхийн гишүүдийн зан үйл, хандлагыг өөрчлөх зөвлөгөө, сэтгэл зүйн засалд хамруулах, хэрэгцээтэй үйлчилгээнд холбон зуучлах, амьдрах ухаан, хөдөлмөрт бэлтгэх сургалтад хамруулах, бие даан амьдрах чадвар, дадлыг хэвшүүлэх зэргээр тухайн өрхийг чадавхжуулах, амьжиргааг дэмжихэд чиглэсэн олон арга хэмжээг авч хэрэгжүүлж, 11 төрлийн тоног төхөөрөмжийг 1256 өрхөд олгосон. Хөтөлбөрт хамрагдаж байгаа 1259 өрхийг улирал бүр үндсэн 10 шалгуур үзүүлэлтээр өрх тус бүрээр үнэлж ирсэн. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хугацаа 2025 дугаар 7 дугаар сарын 2-ны өдөр төгсөлтийн хурлыг зохион байгуулсан бөгөөд хөтөлбөрт хамрагдсан нийт өрхийн 80.6 хувь өрх төгсөх шалгуурыг хангаж амжилттай төгссөн эерэг үр дүн гарсан. Энэхүү төгсөлтийн аргачлалыг 2026-2028 онд улсын хэмжээнд нэвтрүүлэхээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 01/3923 тоот албан бичгээр аймаг, нийслэлийн Засаг даргад чиглэл өгч, ажиллаж байна. | |
| 9. | 1.1.9.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн | ОУ-ын төсөл хөтөлбөр | Шинэчлэн боловсруулсан баримт бичиг /тоо/ | 1 | 1 | Гэр бүл, хөдөлмөр,нийгмийн хамгааллын сайдын 2025 оны А/21 дүгээр тушаалаар Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | найруулгын төслийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ. *|МУЗГҮАХ 2024-2028 2.1.2.11/* | | | | | боловсруулах техникийн ажлын хэсгийг байгуулан хуулийн төслийг боловсруулж, хуулийн төслийн үзэл баримтлалыг 2025 оны 03 дугаар, 07 дугаар, 12 дугаар саруудад тус тус Хууль зүй, дотоод хэргийн сайдтай хамтран баталсан.<br><br>Хуулийн төсөл боловсруулах хүрээнд Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хуулийн хэрэгцээ шаардлагын урьдчилан тандан судалсан судалгаа, хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, хуулийн төслийн үр нөлөөг үнэлсэн үнэлгээ, хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо болон дагалдаж нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг тус бүр боловсруулсан.<br><br>Гэр бүл, хөдөлмөр,нийгмийн хамгааллын сайдын 2025 оны А/88 дугаар тушаалаар хуулийн төслийг эцэслэн боловсруулах, хэлэлцүүлэх үүрэг бүхий өргөтгөсөн ажлын хэсгийг хөдөлмөр, нийгмийн түншлэгч талууд болон холбогдох байгууллагын төлөөллийн бүрэлдэхүүнтэй байгуулан, хуулийн төслийн хэлэлцүүлэг, уулзалтыг зохион байгуулж, саналыг хуулийн төсөлд тусгасан.<br><br>Мөн хуулийн төслийн хэлэлцүүлгийг орон нутгийн ажил олгогч, ажилтны төлөөлөл, төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллүүдэд зохион байгуулж санал солилцон ажилласан.<br><br>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд санал авахаар төрийн захиргааны төв байгууллагууд болох салбарын яамд, холбогдох байгууллагуудад 2025 оны 01/3857 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Хуулийн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төслийг 2025 оны 12 дугаар сард УИХ-д өргөн мэдүүлэхээр төлөвлөөд байна. | |
| 10. | 1.1.10.Олон улсын хөдөлмөрийн байгууллагын “Аж үйлдвэр болон худалдаан дахь хөдөлмөрийн хяналтын тухай” 81, “Хөдөө аж ахуй дахь хөдөлмөрийн хяналтын тухай” 129 дүгээр конвенцод Монгол Улс нэгдэн орох бэлтгэл ажлыг хангана. | үйл ажиллагааны зардал | Конвенцид нэгдэн орох тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төсөл /тоо/ | 0 | 2 | ОУХБ-ын “Аж үйлдвэр, худалдаан дахь хөдөлмөрийн хяналтын тухай” 81 дүгээр конвенц, "Хөдөө аж ахуй дахь хөдөлмөрийн хяналтын тухай” 129 дүгээр конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг Гадаад харилцааны сайд 2025 оны 10 дугаар сард, Хууль зүй, дотоод хэргийн сайд 2025 оны 11 дүгээр сард хамтран баталсан.<br><br>Мөн Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу конвенцод нэгдэн орох хэрэгцээ, шаардлагын урьдчилсан тандан судалгааг, хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ болон зардлын тооцоолол хийсэн. “Аж үйлдвэр, худалдаан дахь хөдөлмөрийн хяналтын тухай” 81 дүгээр конвенц, "Хөдөө аж ахуй дахь хөдөлмөрийн хяналтын тухай” 129 дүгээр конвенцод хийсэн тандан судалгаа болон хуулийн төслийн үзэл баримтлалыг танилцуулах, хэлэлцүүлгийг 2025 оны 08 дугаар сарын 22-ны өдөр зохион байгуулсан | 100 |
| | | | Хэлэлцүүлэг /тоо/ | 0 | 1 | | |
| 11. | 1.1.11.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартад улсын үзлэг зохион байгуулна. | үйл ажиллагааны зардал | Үзлэгт хамрагдах стандартын хувь | 0 | 100 | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартуудад шинжлэх ухаан, техникийн түвшинд улсын үзлэг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүн, ажлын удирдамжийг Гэр бүл, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн А/25 дугаар тушаалаар баталж, улсын үзлэгийг зохион байгуулсан.<br><br>Улсын үзлэгийг стандарт, хэмжил зүйн газраас ирүүлсэн 156 стандартад 2025 оны 02 дугаар сарын 17-ний өдрөөс эхлэн 03 дугаар сарын 12-ний өдрийн хугацаанд зохион байгуулсан. Стандартын улсын үзлэгийн дүнгээр нийт 156 стандартын 47 нь буюу 30.1 хувийг нийтэд нь | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дахин хянах, 57 нь буюу 36.5 хувийг хүчингүй болгох, 46 нь буюу 29.5 хувийг хэвээр мөрдөх, 6 нь буюу 3.8 хувийг холбогдох заалтыг хянах, 22 нь буюу 14.1 хувийг техникийн зохицуулалт болгох нь зүйтэй гэж дүгнэсэн. Энэ ажлын үр дүнд үндэслэн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт, техникийн зохицуулалтын шинэчлэлийн 2025-2027 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан 2025 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн А/97 дугаар тушаалаар батлуулсан.<br><br>Дээрх улсын үзлэгийн тайланг Стандарт, хэмжил зүйн газарт 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 03/989 тоот албан бичгээр санал авахаар хүргүүлсэн.<br><br>Мөн үзлэгийн дүнд үндэслэн Стандарт, хэмжил зүйн газрын хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагааны стандартчиллын техникийн хорооны 2025 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн хурлаар шинэчлэн боловсруулсан 38 стандартын төслийг хэлэлцүүлэн батлуулсан. | |
| 12. | 1.1.12.Асбесттэй харьцах аюулгүй ажлын техникийн зохицуулалтын төслийг боловсруулна. | үйл ажиллагааны зардал | Төсөл /тоо/ | 0 | 1 | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 05 дугаар сарын 26-ний өдрийн А/118 дугаар тушаалаар “Асбесттэй харьцах аюулгүй ажлын техникийн зохицуулалт”-ын төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулан “Асбесттэй харьцах аюулгүй ажлын техникийн зохицуулалт”-ын төслийг боловсруулж Засгийн газрын тогтоолын төсөлд санал авахаар салбарын яам болон холбогдох газарт танилцуулгын хамт 2025 оны 11 дүгээр сарын 27-ний өдрийн 01/3812 дугаар албан бичгээр хүргүүлсэн. | 100 |
| 13. | 1.1.13.Хязгаарлагдмал орчинд ажиллах | | Төсөл /тоо/ | 0 | 1 | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 05 дугаар сарын 26-ний | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | аюулгүй ажиллагааны техникийн зохицуулалтын төслийг боловсруулна. | үйл ажиллагааны зардлаар | | | | өдрийн А/118 дугаар тушаалаар “Хязгаарлагдмал орчинд ажиллах аюулгүй ажиллагааны техникийн зохицуулалт”-ын төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан “Хязгаарлагдмал орчинд ажиллах аюулгүй ажиллагааны техникийн зохицуулалт”-ын төслийг боловсруулж, Засгийн газрын тогтоолын төсөлд санал авахаар салбарын яам болон холбогдох газарт танилцуулгын хамт 2025 оны 11 дүгээр сарын 27-ний өдрийн 01/3812 дугаар албан бичгээр хүргүүлсэн. | 100 |
| 14. | 1.1.14.ҮАМАТ-08-д ангилагдсан ажил мэргэжлээс сонгон ажил мэргэжлийн профайл боловсруулна. | үйл ажиллагааны зардлаар | Боловсруулсан ажил мэргэжлийн профайл /тоо/ | 0 | 120 | Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Цахим хөгжил, харилцаа холбооны яам болон холбогдох мэргэжлийн холбоод, салбарын мэргэжилтнүүдтэй ажил мэргэжлийн профайл боловсруулахад хамтран ажиллалаа. Үүний үр дүнд ГБХНХ-ын сайдын 2025 оны А/79 дугаар тушаалаар 93 ажил мэргэжлийн профайл батлагдсан. Тушаалаар 13 ажил мэргэжил шинээр нэмж, 69 ажил мэргэжлийн нэршилд өөрчлөлт оруулж, 24 ажил мэргэжлийг хүчингүй болгосон. | 100 |
| 15. | 1.1.15.Бүтээмжийн мастер төлөвлөгөөний төслийг боловсруулна. | үйл ажиллагааны зардлаар | Төсөл /тоо/ | 0 | 1 | Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан “Бүтээмжийн хувьсгал” санаачилгыг бүх түвшинд өрнүүлж, ажилгүйдлийн түвшинг тууштай бууруулах бодлого баримталж, Монгол хүний хөдөлмөрийн бүтээмж, цалин хөлсийг жил бүр нэмэгдүүлэх зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам “Үндэсний бүтээмжийн мастер төлөвлөгөө (2026–2035)”-ний төслийг Азийн бүтээмжийн байгууллага, Монголын бүтээмжийн холбоотой хамтран боловсруулсан. “Үндэсний бүтээмжийн мастер төлөвлөгөө”-ний төслийг танилцуулж, санал | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | авах уулзалт, хэлэлцүүлгийг 2025 оны 6 болон 8 дугаар сард холбогдох төрийн байгууллага, мэргэжлийн холбоодын төлөөллүүдийг оролцуулан зохион байгуулсан юм. Эдгээр хэлэлцүүлгээс гарсан санал, зөвлөмжийг “Үндэсний бүтээмжийн мастер төлөвлөгөө”-ний төсөлд тусгасан сүүлийн хувилбарыг 2025 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр Засгийн газар, яам, агентлаг удирдах түвшний 60 гаруй албан хаагчид болон бусад оролцогч талуудад танилцуулсан. Түүнчлэн “Үндэсний бүтээмжийн мастер төлөвлөгөө”-ний төсөлд Засгийн газрын гишүүд, Үндэсний статистикийн хороо, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо зэрэг байгууллагаас санал авахаар ГБХНХСайдын 2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 01/3736 дугаар албан бичгээр хүргүүлж саналыг авч нэгтгэв. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам энэхүү “Үндэсний бүтээмжийн мастер төлөвлөгөө (2026–2035)”-ний төслийг 2026 оны 1 дүгээр улиралд Засгийн газарт танилцуулж, бүтээмжийн өсөлтөд тулгуурлан Монгол Улсын тогтвортой хөгжлийн үндэс, суурийг тавих стратегийн баримт бичиг болгон батлуулна. | |
| 16. | 1.1.16.Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Албадан хөдөлмөрийг хориглох тухай 29 дүгээр протоколд Монгол Улс нэгдэн орох бэлтгэл ажлыг хангана. | үйл ажиллагааны зардлаар 20.0 сая.төг | Протоколд нэгдэн орох тухай хуулийн төслийн үзэл баримтлал /тоо/ | 0 | 1 | 2025 оны 5 дугаар сарын 27-ны өдөр Олон Улсын хөдөлмөрийн байгууллагатай хамтран Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагын албадан хөдөлмөрийн 29 дүгээр протоколд нэгдэн орохтой холбоотой протоколын заалтуудыг үндэсний хууль тогтоомжийн зохицуулалт, бодлого, хөтөлбөр, тэдгээрийн хэрэгжилтийн байдалтай харьцуулсан судалгаа хийлгэж, судалгааны үр дүн, зөвлөмжийн төслийг хэлэлцүүллээ. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ОУХБ-ын ахлах мэргэжилтэн Алайн Пельс, зөвлөх, хууль зүйн ухааны доктор, дэд профессор Б.Одонгэрэл нар уг протоколын агуулга, ач холбогдол, Монгол Улсад хэрхэн хэрэгжиж буй талаар болон цаашид сайжруулах шаардлагатай асуудлуудыг танилцуулж, оролцогч байгууллагуудын төлөөлөл байр суурь, санал, зөвлөмжөө хуваалцлаа. Судалгааны үр дүнд Монгол Улсын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулах олон боломж байгааг оролцогчид онцолж, цаашид протоколд нэгдэн орж, системтэй хэрэгжүүлэх нь чухал гэдэгтэй санал нэгдэв.<br>Монгол Улс албадан хөдөлмөрийг хориглох, устгахтай холбоотой ОУХБ-ын хоёр суурь конвенцод нэгдэн ороод хэрэгжүүлж байна. Эдгээр конвенцын хэрэгжилтийг хангаж, албадан хөдөлмөрийг устгахад үндэсний бодлого, үйл ажиллагааны хөтөлбөр гаргаж хэрэгжүүлэх, хохирогчийг хамгаалах, зөрчигдсөн эрхийг нь сэргээх, албадан хөдөлмөрөөс урьдчилан сэргийлэх, хууль сахиулах болон хамгаалал, үйлчилгээ үзүүлдэг байгууллагын ажилтнуудыг сургаж чадавхжуулах, ажиллах нөхцөл бололцоогоор хангах, олон улсын хамтын ажиллагааны боломжийг ашиглах нь чухал юм. Тиймээс Монгол Улс эдгээр асуудлыг зохицуулсан Албадан хөдөлмөрийн тухай 2014 оны протоколд нэгдэж орох боломжийг судалж байна. Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагын албадан хөдөлмөрийн 29 дүгээр протоколыг соёрхон батлах тухай хуулийн төслийн үзэл баримтлал болон Хууль тогтоомжийн тухай хуульд Үр нөлөөний үнэлгээний төсөл, Тандан судалгааны төсөл, Зардлын тооцоог Олон Улсын Хөдөлмөрийн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгууллагатай техникийн тусламжтайгаар хамтран гүйцэтгэлээ. | |
| 1.2.МОНГОЛ ХҮНИЙ АМЬДРАЛЫН ЧАНАРЫГ ДЭЭШЛҮҮЛЖ, ХҮН АМЫН БҮЛГҮҮДИЙН ХӨГЖИЛ, ОРОЛЦООГ ХАНГАХ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ, НИЙГМИЙН ТААТАЙ ОРЧНЫГ БҮРДҮҮЛЭХЭД ЧИГЛЭСЭН САЛБАР ДУНДЫН ГЭР БҮЛД ЭЭЛТЭЙ ЦОГЦ БОДЛОГО БОЛОВСРУУЛЖ, ХҮН АМЫН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТ, ГЭР БҮЛ, ХҮНИЙ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 2.5.2-ЫН ХҮРЭЭНД: | | | | | | | |
| 1.2.1. | Зорилт 1: Хүн амын тогтвортой өсөлтийг дэмжих, амьдралын чанарыг сайжруулах | Улсын төсөв | Боловсруулсан баримт бичиг /тоо/ | 0 | 2 | I-IV улирал | |
| 17. | 1.2.1.1.Гэр бүлийг дэмжих тухай анхдагч хуулийн төслийг боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ.<br><br>*/ЗГҮАХ 2024-2028-2.1.1.2/* | Улсын төсөв 52.0 сая.төг | Боловсруулсан үзэл баримтлал /тоо/ | 0 | 1 | Гэр бүлийг дэмжих тухай анхдагч хуулийн төслийг боловсруулж Засгийн газрын хуралдаанаар 2025 оны 06 дугаар сарын 04-ний өдөр хэлэлцүүлж, УИХ-д өргөн барихаар тогтсон. Шинэ Засгийн газар байгуулагдсантай холбогдуулан хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг дахин батлуулах шаардлага үүссэний дагуу 2025 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн 01/2619 тоот албан бичгээр Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг ХЗДХСайдтай хамтран батлахаар хүргүүлж, 2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр үзэл баримтлалын төслийг албажуулан ХЗДХЯ-нд хүргүүлсэн. 2025 оны 11 дүгээр сард ХЗДХ-ийн сайд өөрчлөгдсөнтэй холбогдуулан ГБХДТХ-ийн үзэл баримтлалыг ХЗДХ-ын сайдтай 3 дахь удаагаа хамтран батлуулах бичгийг ГБХНХ-ын сайдын 12 дугаар сарын 01-ний өдрийн 01/3877 тоот бичгээр илгээж, 12 дугаар сарын 09-ний өдөр батлуулсан | 90 |
| | | | Хуулийн төсөл /тоо/ | 0 | 1 | Гэр бүлийг дэмжих тухай хуулийн төсөл-1, | |
| | | | Хэлэлцүүлэг /тоо/ | 0 | 3 | Олон нийтээр хэлэлцүүлсэн тоо -15 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Засгийн газрын хуралдааны тэмдэглэл /тоо/ | 0 | 1 | Хуулиар эрх ашиг нь хөндөгдөх бүлгүүд, иргэдийн төлөөлөл, төр, төрийн бус байгууллага, эрдэмтэн судлаагчдын төлөөллөөр хэлэлцүүлсэн 13 хэлэлцүүлгийн тайлан гаргасан. Засгийн газрын хуралдааны тэмдэглэл боловсруулж хүргүүлсэн. Нийт 13 төрлийн бичиг баримтыг боловсруулсан.2025.06.03-ны өдрийн 01/1843 тоот албан бичгээр ЗГ-т хүргүүлсэн. Засгийн газрын 2025.06.04-ний өдрийн 26 дугаар хуралдаанаар хэлэлцэн УИХ-д өргөн мэдүүлэхээр тогтов. Шинэ Засгийн газар байгуулагдсантай холбогдуулан хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг дахин батлуулах шаардлага үүссэний дагуу 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн Засгийн газрын хуралдаанд хуулийн төслийг танилцуулсан. ГБХДТХ-ийн төслийг боловсруулж хэлэлцүүлэхийг даалгасан ЗГ-ын 26-р хуралдааны тэмдэглэл гарсан. Хуулийн үзэл баримтлалыг дахин батлуулахаар ХЗДХЯ-нд хүргүүлсэн. | |
| 18. | 1.2.1.2."Чанартай амьдрал-гэр бүлийн гишүүдийн оролцоо" хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ. */ЗГҮАХ 2024-2028- 2.1.1.2/* | Улсын төсөв | Боловсруулсан хөтөлбөр /тоо/; | 0 | 1 | “Чанартай амьдрал гэр бүлийн гишүүдийн оролцоо” хөтөлбөр боловсруулах “Ажлын хэсэг”-ийг ХГБХХЕГ-ын даргын 6 дугаар сарын 6-ны өдрийн А/75 тушаалаар байгуулсан. Гэвч тус тушаалын хэрэгжилт хангалтгүй явагдсан учир Чанартай амьдрал-гэр бүлийн гишүүдийн оролцоо хөтөлбөрийг боловсруулах Ажлын хэсэг байгуулах тухай ГБХНЯ-ны ТНБД-ын 2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн А/300 тоот тушаалыг батлуулсан. Ажлын хэсгийн болон ТББ-ыг оролцуулсан хуралдааныг 11 дүгээр сарын 20-оос 12 дугаар сарын 05-ны өдрүүдэд 3 удаа хийж, салбар бүрээс хэрэгжүүлэх боломжтой хөтөлбөр, сургалт, үйлчилгээний саналыг нэгтгэн хөтөлбөрийг боловсруулсан. | 50 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.2.2. | Зорилт 2: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийг хангах, оролцоо, хүртээмжийг сайжруулах эрх зүйн орчинг боловсронгуй болгоно. | үйл ажиллагааны зардал | Хуулийн төсөл /тоо/ | 0 | 3 | I-IV улирал | |
| | | | Үүнээс өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /тоо/ | 0 | 2 | | |
| | | | ЗГ-ын хуралдааны хэлэлцүүлэг /тоо/ | 0 | 2 | | |
| 19. | 1.2.2.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулга болон, дагалдан нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ. */Алсын хараа 2050-2.3.3/* | Улсын төсөв | Хуулийн төсөл /тоо/ | 0 | 1 | ГБХНХ-ын сайдын 2025 оны А/22 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталсан. Ажлын хэсгийн хурлыг тайлант хугацаанд 3 удаа зохион байгуулж, хуулийн төслийн холбогдох баримт бичгийн төсөл болох зардлын тооцоо, хэрэгцээ шаардлагын тандалт судалгааг боловсруулсан. Мөн дагалдан гарах 20 гаруй хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан. Хуулийн төслийн үзэл баримтлалыг 2025 оны 12 дугаар сарын 09-ний өдөр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд болон Хууль зүй, дотоод хэргийн сайд хамтран баталсан. | 90 |
| | | | Дагалдан гарах хуулийн төсөл /тоо/ | 0 | 20 | Хуулийн төсөлтэй холбогдуулан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд нэмэлт оруулах тухай, Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Гэр бүлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нийгмийн эрүүл мэндийн тусламж, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үйлчилгээний тухай хуульд нэмэлт оруулах тухай, Биеийн тамир, спортын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Боловсролын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Дээд боловсролын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуульд нэмэлт оруулах тухай, Соёлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуульд нэмэлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол хэлний тухай хуульд нэмэлт оруулах тухай, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай зэрэг 20 хуулийн төслийг боловсруулсан. | |
| | | | Засгийн газрын хуралдааны тэмдэглэл /тоо/ | 0 | 1 | Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төслийг боловсруулсан. | |
| 20. | 1.2.2.2.Саадгүй байдал, хүртээмжийн тухай анхдагч хуулийн болон түүнийг нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, Засгийн | Улсын төсөв | Хуулийн төсөл /тоо/ | 0 | 1 | ГБХНХ-ын сайдын 2025 оны А/22 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар Саадгүй байдал, хүртээмжийн тухай анхдагч хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталсан. Ажлын хэсгийн хурлыг тайлант хугацаанд 2 удаа зохион байгуулж, хуулийн төслийн холбогдох баримт | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ *[Алсын хараа 2050 2.3.3, ЗГҮАХ 2024-2028 -2.5.8/* | | | | | бичгийн төсөл болох зардлын тооцоо, хэрэгцээ шаардлагын тандалт судалгааг боловсруулсан. Мөн дагалдан гарах 20 гаруй хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, УИХ-ын гишүүн О.Саранчулуунд хүргүүлсэн болно. | |
| | | | Дагалдан гарах хуулийн төсөл /тоо/ | 0 | 20 | Энэ хуулийн төсөлтэй уялдуулан барилга байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр Барилгын тухай хууль, Хот байгуулалтын тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, авто зам, замын байгууламж, нийтийн тээврийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр Авто замын тухай хууль, Авто тээврийн тухай хууль, Төмөр замын тээврийн тухай хууль, Иргэний нисэхийн тухай хууль, мэдээллийн технологи, харилцаа холбоо болон үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр Өргөн нэвтрүүлгийн тухай хууль, Харилцаа холбооны тухай хууль, Соёлын тухай хууль, Оюуны өмчийн тухай хууль, Номын сангийн тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хууль, хуулийн хэрэгжилтийг хангах, хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлагыг тодорхой болгох хүрээнд Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Төрийн хяналт, шалгалтын тухай хууль, Эрүүгийн тухай хуульд тус тус нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон холбогдох бусад хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулсан. | |
| | | | Засгийн газрын хуралдааны тэмдэглэл /тоо/ | 0 | 1 | Саадгүй байдал, хүртээмжийн тухай анхдагч хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төслийг боловсруулсан. | |
| 21. | | Улсын төсөв | Хуулийн төсөл /тоо/ | 0 | 1 | ГБХНХ-ын сайдын 2025 оны А/22 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар Дохионы | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1.2.2.3.Дохионы хэлний тухай хуулийн төсөл боловсруулна. | | | | | хэлний тухай анхдагч хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталсан. Ажлын хэсгийн хурлыг тайлант хугацаанд 2 удаа зохион байгуулж, хуулийн төслийг хуралд оролцогчдын саналыг тусган хянан сайжруулж байна. Мөн ажлын хэсэг “Монгол дохионы хэл ба хөгжлийн чиг хандлага” хэлэлцүүлгийг 2025 оны 03 дугаар 28-ны өдөр Боловсролын яам болон харьяа байгууллагууд, СЗСҮТ, МБУЧОС, МУСИҮХ, Сонсголгүйн боловсрол, Тэгш тусгал ТББ-дын төлөөлөл, Олон улсын хөгжлийн болон донор байгууллагын төлөөлөлтэй хамтран зохион байгуулсан. Мөн “Сонсголгүйн боловсрол” ТББ, Дохионы хэлний хэлмэрч орчуулагчдын холбоотой хамтран “Эрт үеийн оролцоо ба сонсголгүйн боловсрол” хэлэлцүүлгийг 06 дугаар сарын 09-ний өдөр зохион байгуулж, хуулийн төслийг хэлэлцүүлсэн. | |
| | | | Үзэл баримтлалын төсөл /тоо/ | 0 | 1 | Монгол дохионы хэлний тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг 2025 оны 12 дугаар сарын 09-ний өдөр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын, Хууль зүй, дотоод хэргийн сайдтай хамтран баталсан. | |
| 1.3.ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЗӨВ, ОНОВЧТОЙ БОДЛОГО БОЛОВСРУУЛЖ, ГЭР БҮЛД ЭЭЛТЭЙ, ЗОХИСТОЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ, ХӨДӨЛМӨРИЙН ХАРИЛЦААГ ТӨЛӨВШҮҮЛЭХ, ХӨДӨЛМӨРИЙН ХУУЛЬ ТОГТООМЖ, ЦАЛИН ХӨЛСНИЙ БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ТҮНШЛЭЛИЙН ГУРВАН ТАЛТ БОЛОН БУСАД ХАМТЫН АЖИЛЛАГААГ ХАНГАХ, САЛБАРЫН ХУУЛЬ ТОГТООМЖ, НОРМ, СТАНДАРТЫН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ, ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙД ХЯНАЛТ ТАВИХ СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 2.5.3-ИЙН ХҮРЭЭНД: | | | | | | | |
| 1.3.1. | Зорилт 1: Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцааны бодлого, хууль тогтоомжийг боловсронгуй болгох замаар хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг дэмжин, тэнцвэрийг хангах | үйл ажиллагааны зардал | Ажлын байрны захиалгын гүйцэтгэл /хувь/ | 29.7 | 45 | Жилийн турш | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 22. | 1.3.1.1.”Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ.<br><br>*/Алсын хараа-2050 2.6.2, МУЗГҮАХ 2024-2028 2.1.2.1/* | үйл ажиллагааны зардал | Шинэчлэн боловсруулсан баримт бичиг /тоо/ | 2 | 3 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн төсөл, үзэл баримтлалын төслийг боловсруулах техникийн ажлын хэсгийг ГБХНХЯ-ны ТНБД-ын 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн А/128 тоот тушаалаар байгуулж төслүүдийг боловсруулж, үзэл баримтлалын төслийг ХЗДХЯ-нд 2024 оны 11 дүгээр сарын 29-ны өдрийн 01/1422 тоот албан бичгээр хүргүүлж батлуулсан. 2025 оны 7 дугаар сард Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн өөрчлөгдсөнтэй холбогдуулан хуулийн үзэл баримтлалын төслийг дахин батлуулах шаардлага үүсэж, улмаар 2025 оны 08 дугаар сард дахин батлуулсан.<br>Хуулийн төслийг холбогдох 3 судалгааны хамт боловсруулан Засгийн газрын гишүүдээс санал авахаар 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 01/1870 тоот, 2025 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 01/3088 тоот албан бичгээр тус тус хүргүүлсэн. Хуулийн төсөлд 13 салбарын яамдаас санал ирүүлж, саналыг нэгтгэн хуулийн төсөлд тусгах ажлыг хийсэн.<br>Мөн Европын холбооны Socieux+ төслийн санхүүжилтээр "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийг шинэчлэн найруулах замаар хөдөлмөр эрхлэлтийн тогтолцоог боловсронгуй болгох" төслийг боловсруулан Европын холбооны хурлаар батлуулаад байна. Уг төслөөр Олон Улсын 2 зөвлөх Монгол Улсад 2025 оны 9-11 саруудад хөдөлмөр эрхлэлтийн тогтолцоог сайжруулах чиглэлээр хамтран ажиллаж, хуулийн төсөлд нарийвчилсан санал зөвлөмж өгч, хамтран ажилласан.<br>ГБХНХЯ-аас Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж байна. Хуулийн шинэчлэлд тусгаж байгаа гол чиглэлийн нэг нь хүн амын бүлгүүдийн онцлог, хэрэгцээнд нийцсэн | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үйлчилгээ, арга хэмжээг хэрэгжүүлэх, ялангуяа байнгын асаргаатай хүн асардаг иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нэмэгдүүлэхтэй холбоотой зохицуулах явдал юм. ХЗДХ-н сайд 2025 оны 9 дүгээр сард солигдсон тул хуулийн үзэл баримтлалын төслийг ХЗДХЯ-нд 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдөр дахин хамтран батлуулахаар хүргүүлсэн.<br><br>Хуулийн төслийг 2026 оны 1 дүгээр улиралд багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн барихаар төлөвлөж байна.<br><br>**Шинэчлэн боловсруулсан хуулийн төсөл-1**<br><br>**Үзэл баримтлал-2** | |
| 23. | 1.3.1.2.“Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай ” хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын их хурлын чуулганаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангаж ажиллана.<br><br>*/Алсын хараа-2050 2.6.2, МУЗГҮАХ 2024-2028 2.1.2.1/* | үйл ажиллагааны зардал | Баримт бичиг /тоо/ | 2 | 1 | Гадаад ажилтны ажлын байрны төлбөрийг зарим салбарт чөлөөлөхтэй холбоотойгоор Засгийн газрын 2023 оны 45 дугаар тэмдэглэлээр Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад (хуучнаар) даалгасан.<br><br>Үүний дагуу Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу Засгийн газрын гишүүд, олон нийтээс санал авах болон бусад хуульд заасан ажлыг гүйцэтгэн Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн.<br><br>Улмаар Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн хуралдааны 5 дугаар тэмдэглэлээр Ажиллах | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцээд хуралдаан дээр Засгийн газрын гишүүдээс гаргасан саналын дагуу холбогдох яамдаас дахин санал авсны үндсэн дээр хэлэлцэхээр тогтсон.<br><br>Монгол Улсын Их Хурлын 2024 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.2.2.5-д “Өндөр мэдлэг, ур чадвар бүхий нарийн мэргэжлийн ажиллах хүчний болон хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг хангах зорилгоор гадаадаас авах ажиллах хүчний тоонд тавих хязгаарлалтыг уян хатан болгох, ажлын байрны төлбөрөөс бүрэн чөлөөлөх бодлого баримтална” гэж заасан.<br><br>Дээрх Улсын Их Хурлын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн хэрэгжилтийг хангах хүрээнд Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам эцэслэн боловсруулж, хуулийн төслийн үзэл баримтлалыг Хууль зүй, дотоод хэргийн сайдтай хамтран баталж, хуулийн төслийг Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн бөгөөд Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдөр өргөн мэдүүлсэн болно.<br><br>Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудалд тусгасан хэдий ч одоогийн байдлаар чуулганаар хэлэлцээгүй байгаа болно. Бэлтгэл ажил хангах хүрээнд уг хуулийн төсөлтэй холбоотой тоон мэдээлэл, асуулт хариултыг боловсруулах ажлыг гүйцэтгэж байна.<br><br>Тус хуулийг Монгол Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцүүлэх асуудал нь яамнаас үл хамаарах шалтгаанаар хийгдээгүй байгаа тул үнэлэх боломжгүй юм. | |
| 24. | 1.3.1.3.Хөдөлмөрийн харилцааны хөтөлбөрийг шинэчлэн баталж, хэрэгжилтийг хангана.<br>*/Алсын хараа-2050 2.6.3, 3.3, МУЗГҮАХ 2024-2028 2.1.2.10/* | ХЭДС<br>1.7 тэрбум төгрөг | Шинэчлэн боловсруулсан баримт бичиг /тоо/ | 0 | 2 | Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2025 оны 04 дүгээр тогтоолоор “Хөдөлмөрийн харилцааны хөтөлбөр”-т нэмэлт, өөрчлөлт оруулан батлуулсан. Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдамжийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны А/111 дүгээр тушаалаар батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллах чиглэлийг ХХҮЕГ-т хүргүүлэв.<br><br>2025 оны 06 дугаар сарын 12-14-нд 3 дахь, 11 дүгээр сарын 27-29 нд 4 дэх удаагийн сургалтыг зохион байгуулж байгаа бөгөөд сургалтад 5 аймаг, Улаанбаатар хотоос хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал, хуульч, эрх зүйч, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй болон бусад чиглэлээр мэргэшсэн нийт 37 шилдэг мэргэшсэн хүмүүс цуглан сургалтад хамрагдан мэдлэг, мэдээллээ шинэчлэн “Мэргэшсэн зөвлөх” гэрчилгээ гардлаа.<br><br>Өнгөрсөн онд хөдөлмөрийн харилцааны зөвлөх үйлчилгээнд 13 аймаг, 7 дүүргийн 82 аж ахуйн нэгж, байгууллага хамрагдсан байна.<br><br>-Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн дотоод 563 дүрэм, журам, тушаал, холбогдох бусад баримт бичгийг боловсруулсан; | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | -Сургалтын арга хэмжээнд 225 аж ахуйн нэгж, байгууллагын ажил олгогч, хүний нөөцийн 1253 хүн хамрагдсан байна.<br><br>2025 оны 12 дугаар эхний байдлаар 75 ААНБ-д хөдөлмөрийн дотоод журам, цалин хөлсний журам, ажилтны мэдээлэл авах, хадгалах, ашиглах журам зэрэг дотоод хэм хэмжээг боловсруулах, цалин хөлс, үндсэн болон нэмэгдэл, нэмэгдэл хөлс тооцох,ажил, амралтын цагийн зохицуулалт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, хөдөлмөрийн нөхцөл, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт, урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөлт, нийгмийн даатгалын хууль тогтоомж, санхүү татварын асуудлаар зөвлөх үйлчилгээ үзүүлж, сургалтад хамрагдсан байна. | |
| 25. | 1.3.1.4.Төрийн албан хаагчдын зайнаас, цахимаар, цагаар ажиллах журам боловсруулан батлуулна. *\/ЗГҮАХ 2024-2028 2.1.2.9./* | үйл ажиллагааны зардал | Шийдвэр бүхий баримт бичиг /тоо/ | 0 | 2 | Манай яам, Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүүхдийн сантай хамтран Хөдөлмөрийн тухай хуулийн 43.3, гэр бүлд ээлтэй хөдөлмөрийн харилцааны бодлогын хэрэгжилтийг үнэлэх зорилгоор “Монгол Улс дахь гэр бүлд ээлтэй бодлогын хэрэгжилтийн нөхцөл байдлын судалгаа”-г хийж байна.<br>Тус судалгааг “IRIM” судалгааны хүрээлэнгээс гүйцэтгэж байгаа бөгөөд судалгааны зорилго нь Монгол Улс дахь төр, төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагуудын хүүхдэд ээлтэй бодлого, ажилтны ажил амьдралын тэнцвэрийг хангах зохицуулалт хэр түвшинд хэрэгжиж байгааг ажилтны хөдөлмөрийн бүтээмж, ажилдаа сэтгэл ханамжтай ажиллах нөхцөл бүрдсэн эсэх асуудалтай холбон судалж, гэр бүлд ээлтэй бодлогыг хэрэгжүүлэх тэр дундаа зайнаас, цахимаар ажиллах хөдөлмөрийн дотоод журам боловсруулах аргачлал, | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зөвлөмжийг боловсруулахаар ажиллаж байна. Судалгааны эцсийн тайланг 2025 оны 12 дугаар сарын 22-нд хүлээн авна.<br>Судалгааны эхний үр дүн болон дотоод, гадаадын байгууллагуудын сайн туршлагыг судлан Төрийн албан хаагчид болон аж ахуйн нэгж, байгууллагад зайнаас, цахимаар ажиллах хөдөлмөрийн дотоод журам, журам боловсруулах аргачлал, зөвлөмжийн төслийг боловсруулаад байна.<br>Судалгааны эцсийн тайланг хүлээж авсны дараа журмын төслийг холбогдох байгууллагын төлөөллийг оролцуулан хэлэлцүүлэн батлуулна. | |
| 26. | 1.3.1.5.Аж ахуйн нэгж, байгууллагад зайнаас, цахимаар ажиллах хөдөлмөрийн дотоод журам боловсруулах аргачлал, зөвлөмжийг боловсруулан батлуулна.<br>*/МУЗГҮАХ 2.2.9/* | үйл ажиллагааны зардал | Боловсруулсан баримт бичиг /тоо/ | 0 | 1 | Манай яам, Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүүхдийн сантай хамтран Хөдөлмөрийн тухай хуулийн 43.3, гэр бүлд ээлтэй хөдөлмөрийн харилцааны бодлогын хэрэгжилтийг үнэлэх зорилгоор “Монгол Улс дахь гэр бүлд ээлтэй бодлогын хэрэгжилтийн нөхцөл байдлын судалгаа”-г хийж байна.<br>Тус судалгааг “IRIM” судалгааны хүрээлэнгээс гүйцэтгэж байгаа  бөгөөд судалгааны зорилго нь Монгол Улс дахь төр, төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагуудын хүүхдэд ээлтэй бодлого, ажилтны ажил амьдралын тэнцвэрийг хангах зохицуулалт хэр түвшинд хэрэгжиж байгааг ажилтны хөдөлмөрийн бүтээмж, ажилдаа сэтгэл ханамжтай ажиллах нөхцөл бүрдсэн эсэх асуудалтай холбон судалж, гэр бүлд ээлтэй бодлогыг хэрэгжүүлэх тэр дундаа зайнаас, цахимаар ажиллах хөдөлмөрийн дотоод журам боловсруулах аргачлал, зөвлөмжийг боловсруулахаар ажиллаж байна. Судалгааны эцсийн тайланг 2025 оны 12 дугаар сарын 22-нд хүлээн авна. | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Судалгааны эхний үр дүн болон дотоод, гадаадын байгууллагуудын сайн туршлагыг судлан Төрийн албан хаагчид болон аж ахуйн нэгж, байгууллагад зайнаас, цахимаар ажиллах хөдөлмөрийн дотоод журам, журам боловсруулах аргачлал, зөвлөмжийн төслийг боловсруулаад байна.<br><br>Судалгааны эцсийн тайланг хүлээж авсны дараа журмын төслийг холбогдох байгууллагын төлөөллийг оролцуулан хэлэлцүүлэн батлуулна. | |
| 1.3.2. | Зорилт 2: Хүн амын бүлгүүдийг хөдөлмөр эрхлэх тэгш боломжийг бүрдүүлж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээг сайжруулж, тогтвортой ажлын байрыг бий болгоход дэмжлэг үзүүлэх | үйл ажиллагааны зардал | Хөдөлмөрийн гэрээ байгуулж 3-аас дээш сар ажлын байртай болсон иргэдийн тооны өсөлт /хувь/ | 3 | 3 | Жилийн турш | |
| 27. | 1.3.2.1.Бүс, орон нутгийн хөгжил болон эдийн засгийн тэргүүлэх салбарын бүтээн байгуулалтын ажлын ажиллах хүчний хэрэгцээг хангах салбар дундын хөдөлмөр эрхлэлтийн бодлого, арга хэмжээг хэрэгжүүлэх *Алсын хараа-2050 2.6.17, МУЗГҮАХ 2024-2028 2.1.2.1/* | үйл ажиллагнаан ы зардал | Шийдвэр бүхий баримт бичиг /тоо/ | 0 | 2 | Аймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулах 2025 онд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хууль тогтоомж, бусад баримт бичигт заасан эрх хэрэгжүүлж, үүрэг гүйцэтгэх гэрээнд дараах арга хэмжээг тусган хамтарч ажилласан. Үүнд:<br>- /Орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн төлөв байдлыг эдийн засгийн үйл ажиллагааны салбар, ажил мэргэжлийн байдлаар нарийвчлан судлан тодорхойлж, хүний нөөцийн оновчтой төлөвлөлт, хуваарилалтын зохицуулалтыг хийж ажиллах;<br>- Техник технологийн хөгжил дэвшилд тулгуурласан бүтээмж өндөртэй, инноваци | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шингэсэн шинэлэг санал санаачилгыг дэмжих, холбогдох төрийн болон хувийн хэвшлийн байгууллагатай хамтран ажиллахад нь дэмжлэг үзүүлэх;<br>- Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төв (job center)-ийг орон нутагт нээн ажиллуулах, дэмжлэг үзүүлэх;<br>- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжилт авсан ААНБ, иргэдийн бараа бүтээгдэхүүнд борлуулалтын дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг шинэ түвшинд гаргаж, арга барилыг сайжруулж шинэчлэх, томоохон ААНБ-тай гэрээ байгуулж, борлуулалт хийх, хамтран ажиллах гарцыг бий болгох;<br>- Хөдөлмөрийн тухай хуулийн 144.3 дахь заалт, Ашигт малтмалын тухай хуулийн 43.3 дахь заалт, Ахмад настны тухай хуулийн 3 дугаар зүйлийн хэрэгжилтийг хангуулж, төвлөрсөн хөрөнгийг орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, ажилгүйдлийг бууруулах үйл ажиллагаанд зориулалтын дагуу зарцуулах болно.<br>Мөн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа /хөтөлбөр/-ны хэрэгжилтийг хангуулахад шаардагдах суурь судалгаа, мэдээллийг шинэчлэн бий болгох зорилгоор “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хэрэгцээний судалгаа”-г аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсүүдээр дамжуулан гүйцэтгэсэн. Тус судалгаагаар засаг захиргааны нэгж тус бүрээрх ажилгүй иргэний бүртгэл, судалгаа гарч, улмаар хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээнд хамрагдах хүсэлт, хэрэгцээний талаарх тодорхой мэдээлэл бий болсон ба тус мэдээллийг ХЭДС-ийн төсвийн хуваарилалтыг оновчтой, бодитой болгох, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хэрэгжилтийг сайжруулах суурь мэдээллээр ашигласан.<br><br>““Job center” төвийг дэмжих туршилтын төслийг боловсруулж, ХЭҮЗ-ийн 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 2 дугаар тогтоолоор батлуулсан. Төслийг хэрэгжүүлэх удирдамжийг боловсруулж, ГБХНХСайдын 2025 оны 3 дугаар сарын А/27 дугаар тушаалаар батлуулсан.<br><br>2025 оны 11 дүгээр сарын сүүлчийн байдлаар улсын хэмжээнд 14 төв үйл ажиллагаа явуулж байгаагаас орон нутагт 4 төв, Улаанбаатар хотод 10 төв ажиллаж байна. Тус төвүүд нь хөдөлмөр эрхлэх чадварын үнэлгээ хийх үйлчилгээг 2647 хүн, хувийн хөдөлмөр эрхлэлтийн төлөвлөгөө боловсруулах үйлчилгээг 1806 хүнд, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөх үйлчилгээг 6369 хүн,бүлгийн зөвлөгөөг 1494 бүлэгт, ажил зуучлах үйлчилгээг 645 хүнд тус тус үзүүлсэн.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 5 үндсэн үйл ажиллагааг улсын хэмжээнд хэрэгжүүлсэн. 2025 оны 11 дүгээр сарын сүүлчийн үйл ажиллагаа, хөтөлбөрт 50,732 хүн хамрагдаж 46.2 тэрбум төгрөг зарцуулсан.<br><br>ГБХНХЯ-аас Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж байна. Хуулийн шинэчлэлд тусгаж байгаа гол чиглэлийн нэг нь “орон нутгийн хөгжил болон хөдөлмөр эрхлэлтийн бодлого” хоорондын уялдаа холбоог хангах зохицуулалт юм. Хуулийн төслийг 2026 оны 1 дүгээр улиралд багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн барихаар төлөвлөж байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Түүнчлэн Засгийн газрын 2025 оны “Ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай” 31 болон 49, 96 дугаар тогтоолоор гадаадын хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн хүрээнд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх болон стратегийн ач холбогдол бүхий дэд бүтцийн бүтээн байгуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх 57 аж ахуйн нэгж, байгууллагын 17562 гадаад ажилтныг 2025 онд ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх шийдвэрийг гаргасан.2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар 103 орны 18 мянган гадаад ажилтныг ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх шийдвэрийг гаргуулсан.<br><br>ГБХНХ-ын сайд болон аймгийн засаг дарга нартай байгуулсан гэрээ-21<br>Засгийн газрын тогтоол-3<br>ХЭҮЗ-ийн тогтоол-8<br>ГБХНХ-ын сайдын тушаал-3 | |
| 28. | 1.3.2.2.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээг гүйцэтгэлийн үр дүн, чанарт суурилсан байдлаар шинэчлэн боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллана. */Алсын хараа-2050 2.6.3, 3.3.1, 3.3.3, 3.3.4, МУЗГҮАХ 2024-2028 2.1.1.12, 2.1.1.17, 2.1.1.20, 2.1.1.28, 2.1.1.30, 2.1.2.3,* | 130.7 тэрбум төгрөг | Шийдвэр бүхий баримт бичиг /тоо/ | 0 | 4 | 2025 онд хэрэгжүүлэх Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа/хөтөлбөр/-г төсөл боловсруулах, батлуулах ажлын хүрээнд дараах ажлыг гүйцэтгэсэн. Үүнд:<br>- 2025 онд хэрэгжүүлэх хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны төсөлд яамны дотоод нэгжийн газрууд, ХХҮЕГ, аймаг, дүүргийн ХХҮГ-ууд, МАОЭНХ, МҮЭХ, МҮХАҮТ-ийн төлөөлөл, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-ийн төлөөлөл, Монголын Хувийн хөдөлмөрийн биржүүдийн нэгдсэн холбооны удирдлага болон ЖобЦэнтр төвийн ажилтнуудын төлөөллүүдтэй уулзалт, хэлэлцүүлэг хийж холбогдох саналыг авсан. | 100 |
| | | | Хэрэгжилтийн баримт бичиг /тоо/ | 0 | 1 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | *2.1.2.8-9, 2.1.3.12, 2.1.3.15-16, 3.2.2.5 /* | | | | | - Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ болон төслийг боловсруулж 2025 оны 2 дугаар сарын 11-ний Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулсан. Энэ хүрээнд хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийн сургалтын үйл ажиллагаа, санхүүгийн дэмжлэгийн үйл ажиллагаа, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, түр ажлын байрыг дэмжих болон ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа гэсэн 5 үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, мөн Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн тодорхойлсон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бусад туршилтын төсөл, үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажилласан.<br>- Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн тогтоолыг үндэслэн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын А/50 дугаар тушаалаар Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны нэгдсэн удирдамж, зардлын жишиг хэмжээг батлуулсан.<br>- 2025 оны 7, 8 дугаар сарууддад Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн ээлжит хуралдааныг зохион байгуулж, 2025 онд хэрэгжүүлж байгаа Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа/хөтөлбөр/ болон ХЭДС-н төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулсан.<br>Түүнчэн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хэрэгжилтийг хангаж ажиллах чиглэлээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 01/886, Хөдөлмөрийн бодлогын | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | газрын 2025 оны 06 дугаар сарын 16-ний өдрийн 06/1966 тоот албан бичиг, 05 дугаар сарын 27-ний 06/1732 тоот албан бичгээр тус тус ХХҮЕГ-т чиглэл хүргүүлсэн.<br>Шийдвэр бүхий баримт бичиг /тоо/-2<br><br>Хэрэгжилтийн баримт бичиг /тоо/- Газрын даргын албан бичиг-2 | |
| 29. | 1.3.2.3.Хилийн чанадаас эх орондоо эргэн суурьших Монгол иргэдэд чиглэсэн цогц хөтөлбөр батлуулж хэрэгжүүлнэ.<br>*/ЗГҮАХ 2024-2028 2.1.2.5, 2.1.3.16/* | 5000.0 сая.төг | Судалгаа /тоо/ | 0 | 2 | НҮБ-ын Олон улсын шилжих хөдөлгөөний байгууллагатай гадаадад ажиллаж, амьдарч байгаа Монгол иргэд болон Монгол Улсад ажиллаж байгаа гадаадын ажилчдын асуудлаар хамтран ажиллах чиглэлээр санал солилцон хамтран ажиллаж байна. Тус байгууллагын гадаадад суралцаж, ажиллаж байгаа өндөр ур чадвартай иргэдийг эх орондоо эргэн ирэх, хөдөлмөр эрхлэхэд нь дэмжих чиглэлээр хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа судалгаа, туршилтын хөтөлбөрийн ажлын даалгавартай танилцан санал хүргүүлсэн.<br><br>Мөн хоёр улсын Засгийн газар хооронд байгуулсан санамж бичгийн дагуу БНСУ болон Япон улсад хууль ёсоор хөдөлмөр эрхэлж байгаа, нутаг буцах хугацаа нь дөхсөн иргэдийн судалгаа, мэдээллийг гаргах, хөдөлмөр эрхлэх хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, холбогдох дэмжлэгийн арга хэмжээг хэрэгжүүлэхээр холбогдох судалгааг хийж байгаа бөгөөд БНСУ-д хөдөлмөр эрхлээд нутаг буцаж буй Монгол иргэдэд бизнесийн дэмжлэг үзүүлэх судалгааг БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв хийсэн болно.<br><br>Бичил, жижиг бизнес эрхлэгчдэд бизнесийн үйл ажиллагаагаа хөгжүүлэхэд зориулсан зээл, санхүүгийн дэмжлэгийг өргөтгөж, хүртээмжийг нэмэгдүүлэхээр Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тухай хуулийн 6.3.8 дахь заалтын хүрээнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан болон Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас санхүүжүүлэн хэрэгжүүлэх “Хөгжлийн гүүр” хөтөлбөрийг боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж дэмжсэн. Засгийн газрын тусгай сангуудын үйл ажиллагааг уялдуулах хууль эрх зүйн орчин хангалттай бүрдээгүйн улмаас хөтөлбөрийг албажуулах ажил хойшилж, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон дагалдан гарах хуулийн өөрчлөлтийн төсөлд холбогдох зохицуулалтыг тусгахаар ажиллаж байна. Хөгжлийн гүүр хөтөлбөрт гадаадаас эх орондоо эргэн ирсэн иргэний үүсгэн байгуулсан аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулахаар төлөвлөсөн байсан.<br><br>ГБХНХЯ, ХХҮЕГ-аас БНСУ болон Япон улсад хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаад эх орондоо эргэн ирсэн иргэд, мөн гадаад улсад хөдөлмөрийн гэрээгээр ажиллах хүсэлтэй иргэдийг бүртгэж, хөдөлмөрийн зах зээлийн мэдээ, мэдээллээр хангах, сургалтад хамрагдах, бичил бизнес эхлүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор 2025 оны 12 дугаар сарын 5-ны өдөр “Хөдөлмөр-Хөгжил” өдөрлөгийг зохион байгуулсан. Тус өдөрлөгийн үеэр ажиллах хүчний шилжилт хөдөлгөөн, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн даатгалын бодлого, хууль тогтоомж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээний талаар иргэдэд зөвлөгөө, мэдээлэл өгөх, сурталчлан таниулах, санал хүсэлтийг хүлээн авч ажилласан. Өдөрлөгт ЖДҮГ, НДЕГ, дүүргүүдийн ХХҮГ болон Япон, Солонгос хэлний сургалтын байгууллагууд оролцож 11 иргэнд үнэ төлбөргүй сургалтад хамрагдах | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | эрхийн бичиг гардуулан өгсөн. Мөн өдөрлөгийн үеэр иргэдэд үйлчилгээг “Өртөөчилсөн булан” хэлбэрээр үзүүлсэн нь онцлог болсон ба нийт 350 иргэн үйлчлүүлсэн.<br><br>Судалгаа-1 | |
| 30. | 1.3.2.4.Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээнд суурилсан урьдчилан сэргийлэх (аюулыг илрүүлэх, эрсдэлийг үнэлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх) арга зүйг нэвтрүүлж, өндөр эрсдэлтэй аж ахуйн нэгжийн хамрагдах хувийг нэмэгдүүлж, зөвлөмжийн дагуу нөхцөлийг сайжруулна. */ЗГҮАХ 2024-2028 2.1.1.16/* | үйл ажиллагааны зардлаар | Гүйцэтгэл /хувь/ | 0 | 100 | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-д хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг стандартын асуудал эрхэлсэн байгууллагын итгэмжлэл бүхий мэргэжлийн байгууллага хийхээр заасны дагуу Итгэмжлэлийн үндэсний төвөөс хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх итгэмжлэлтэй дараах 6 байгууллага ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг хийж байна. Үүнд:<br>1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв<br>2. “Түмэн тэрэм” ХХК<br>3. “Хэлт инспекшин” ХХК<br>4. “Эв ихт глюк” ХХК<br>5. “Хэлт сэфти энд фрий воркплэйсэс” ХХК<br>6. “Даблью эйч эс” ХХК<br><br>Дээрх байгууллагууд 2025 оны 11 дүгээр сарын байдлаар 160 аж ахуйн нэгж, байгууллагын 2065 ажлын байранд хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг хийж, ажлын байрны орчин нөхцөлийг сайжруулах талаар зөвлөмж хүргүүлж ажилласан байна.<br><br>Мөн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин түгээмэл гардаг, эрсдэл өндөртэй салбарын аж ахуйн нэгж олноор төвлөрсөн аймаг, дүүргүүдэд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвтэй хамтран “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мэндийн урьдчилан сэргийлэх цогц аян”-ыг зохион байгуулсан. Тодруулбал, уг аяныг Налайх дүүрэгт 2025.09.09–2025.09.10-ны өдрүүдэд, Багануур дүүрэгт 2025.11.10–2025.11.13-ны өдрүүдэд, Төв аймагт 2025.12.05–2025.12.10-ны өдрүүдэд тус тус зохион байгуулж, нийт 176 ажил олгогч, 152 хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэнийг хамруулсан.<br><br>Аяны хүрээнд сонгогдсон аж ахуйн нэгж, байгууллагад хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээ хийснээс гадна ажил олгогчдод зориулсан сургалт, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн сургалт, аймаг болон сумдын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн зөвлөлийн гишүүдийг чадавхжуулах сургалтыг тус тус зохион байгуулж, зөвлөмж өгч ажилласан. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/155 дугаар тушаалаар баталсан “Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх” журмын дагуу ажил олгогч хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний тайланг хүлээн авснаас хойш 12 сарын дотор зөвлөмжийг хэрхэн хэрэгжүүлсэн тайланг баталгаажуулан үнэлгээ хийсэн итгэмжлэгдсэн байгууллагад хүргүүлэхээр заасан байдаг. Үүний хүрээнд хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний итгэмжлэгдсэн байгууллагууд зөвлөмжийн мөрөөр сайжруулсан арга хэмжээг хяналт тавин ажиллана. | |
| 31. | 1.3.3.1.Төрийн албан хаагчдын үндсэн цалинг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлнэ. | Улсын төсөв: 424.4 тэрбум төгрөг | Нэмэгдсэн хувь | 0 | 8 | Өнгөрсөн хугацаанд төрийн албан хаагчдын цалин хөлсийг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх зарчмыг баримталж ирсэн бөгөөд төрийн албан хаагчийн цалин хөлсний бодлогын шинэчлэлийн хүрээнд 2022 оноос | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | */Алсын харааа-2050 2.6.6. ЗГҮАХ 2.1.2.7/* | | | | | эхлэн цалингийн шатлалыг хялбаршуулахад чиглэсэн арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлж байна. Уг бодлогыг үргэлжлүүлж Монгол Улсын 2023 оны төсвийн тодотголын хүрээнд төрийн албан хаагчдын цалин хөлсийг 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс дунджаар 40 хувиар нэмэгдүүлэн тогтоосон. Мөн 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс төрийн нийтлэг үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалинг 20 хувиар, бусад төрийн албан хаагчдын үндсэн цалинг 10 хувиар нэмэгдүүлэн тогтоосон.<br><br>Монгол Улсын 2025 оны улсын төсөвт тусгасны дагуу Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолоор инфляфын түвшинтэй уялдуулан 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс төрийн албан хаагчдын үндсэн цалинг 6 хувиар нэмэгдүүлэн тогтоосон. Уг арга хэмжээний үр дүнд төрийн захиргааны болон төрийн мэргэжлийн үйлчилгээний албан хаагчдын цалингийн доод хэмжээ 1,166.0 мянган төгрөг, төрийн нийтлэг үйлчилгээний албан хаагчийн цалингийн доод хэмжээ 954.0 мянган төгрөг болсон.<br><br>Түүнчлэн эрүүл мэнд, боловсрол, шинжлэх ухааны салбарын нэмэлт хэлэлцээрийн дагуу 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс боловсролын салбарын албан хаагчдын үндсэн цалинг 50 хувиар, эрүүл мэндийн салбарын албан хаагчдын үндсэн цалинг 30 хувиар, шинжлэх ухааны салбарын албан хаагчдын үндсэн цалинг 20 хувиар тус тус нэмэгдүүлэхээр тохиролцсон. Бусад салбарын төрийн албан хаагчдын цалин хөлсийг үе шаттайгаар нэмэгдүүлнэ. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 32. | 1.3.3.2. Төрийн зарим албан тушаалын ангилал, зэрэглэлд өөрчлөлт оруулна. */Алсын хараа-2050 2.6.6. МУЗГҮАХ 2.1.2.7/* | Улсын төсөв 15.6 тэрбум төгрөг | Шийдвэр бүхий баримт бичиг /тоо/ | 0 | 1 | Засгийн газрын 2022 оны “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай” 487 дугаар тогтоолд Засгийн газрын Засгийн газрын 2025 оны 08, 38, 93, 107 дугаар тогтоолоор тус тус нэмэлт, өөрчлөлт оруулсан.<br>Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, цалин хөлсний талаарх судалгаа, цаашид авах арга хэмжээний саналыг боловсруулан Төрийн нарийн бичгийн даргын 2025.03.31-ний өдрийн 02/1000 тоот албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газар /Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжаар байгуулагдсан Төрийн албаны реформ хийх асуудлыг судалж, санал дүгнэлт боловсруулах Ажлын хэсэг/-т хүргүүлсэн. | 100 |
| 33. | 1.3.3.3. Цалин хөлсний статистик мэдээллийг ажил, мэргэжлээр илүү нарийвчлалтай гаргана. */МУЗГҮАХ 2.1.2.2/* | Улсын төсөв (ХЭДС) | Цалин хөлсний судалгаа /тоо/ | 0 | 1 | “Цалин хөлсний бүтцийн судалгаа” нь улсын хэмжээнд идэвхтэй үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуй нэгж байгууллагын ажиллагчдын нийт цалингийн бүрэлдэхүүн буюу үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, шагнал урамшууллын жил бүрийн өөрчлөлт, салбар болон ажиллагчдын тооны бүлгээрх уялдаа холбоог нарийвчлан тодруулж, боловсруулсан мэдээллийн хүрээнд бодлого боловсруулагчдын шийдвэр гаргалтад хэрэглэхүйц тоон мэдээлэл бэлтгэх зорилготойгоор хоёр жил тутамд үндэсний хэмжээнд зохион байгуулдаг томоохон түүвэр судалгаа юм. Тус судалгааг 2019, 2021, 2023 онуудад хийсэн бөгөөд Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт судалгааны хүрээлэнгээс 2025 оны судалгааг хийх удирдамжийг боловсруулж 2025 оны 11 дүгээр сар хүртэлх хугацаанд нийт 3000 ААНБ-ыг тус судалгаанд хамруулсан. Судалгааны тайлан 2025 оны 12 дугаар сард эцэслэн гарна. Мөн | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | “Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн дунд хугацааны эрэлт, нийлүүлэлтийн таамаглал”-ын судалгаанд эрэлт, нийлүүлэлтийг зохицуулагч, хөдөлмөрийн харилцааны гол хүчин зүйл болдог цалингийн түвшнийг авч үзсэн. | |
| 1.3.4. | Зорилт 4: Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талын хамтын ажиллагааг бэхжүүлэх | үйл ажиллагааны зардал | Салбарын хэлэлцээрийн тоо, салбар, аймаг, нийслэлийн хороодын тоо /өссөн дүнгээр/ | 10 | 20 | I-IV улирал | |
| 34. | 1.3.4.1. Салбарын хамтын хэлэлцээрүүдийг хууль тогтоомжийн дагуу бүртгэн, мэдээллийн санг бүрдүүлнэ. | үйл ажиллагааны зардал | Салбарын хэлэлцээрийн тоо, салбар, аймаг, нийслэлийн хороодын тоо /өссөн дүнгээр/ | 0 | 1 | Нийгмийн түншлэлийн хүрээнд улс, аймаг, орон нутгийн нийгэм, эдийн засаг, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, иргэд, хөдөлмөрчдийн орлого, амьжиргааны түвшнийг дээшлүүлэхтэй холбогдсон олон асуудлууд хөдөлмөр, хүн амын нийгмийн хамгааллын болон хөдөлмөрлөх эрхийн асуудлуудыг нийгмийн түншлэлийн хоёр болон гурван талт хэлэлцээрээр баталгаажуулан хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Аймаг, нийслэлийн хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт 22 хороо, аймаг, нийслэлийн 22 хамтын хэлэлцээр, салбарын 14 хэлэлцээр байгуулагдан ажиллаж байна.<br>2025 оны 10-11 дүгээр сард салбарын хэлэлцээрүүд болон салбарын нэмэлт хэлэлцээрүүдийг бүртгэв. Үүнд:<br>-2025 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр Боловсрол, шинжлэх ухааны яам болон Монголын боловсрол, шинжлэх ухааны үйлдвэрчний эвлэлийн холбооны хооронд 2024-2026 онд байгуулсан хамтын хэлэлцээр”-ийн нэмэлт хэлэлцээр; | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | -2025 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр “Эрүүл мэндийн салбарын 2024-2026 оны хамтын /тариф/-ын хэлэлцээр"-ийн нэмэлт хэлэлцээр;<br>-2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Монголын эрчим хүч, геологи, уул уурхайн үйлдвэрчний эвлэлийн холбоо, Монголын уул уурхайн үндэсний ассосиацийн хооронд байгуулсан “Аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарын 2026-2027 оны хамтын хэлэлцээр";<br>-2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Эдийн засаг, хөгжлийн яам болон Монголын боловсрол, шинжлэх ухааны үйлдвэрчний эвлэлийн холбоо хоорондын 2026-2028 оны хамтын хэлэлцээрүүдийг Хөдөлмөрийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсэгт заасны дагуу хянан дээрх тус тус бүртгэн хүргүүлсэн болно.<br>Дээрх 2 нэмэлт хэлэлцээрийг бүртгэн баталгаажуулснаар боловсролын салбарын ажил хаялт, эрүүл мэндийн салбарын суулт зогсч тус салбаруудын үйл ажиллагаа улсын хэмжээнд хэвийн үргэлжлэх боломжтой болсон. | |
| 1.4. НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ ШИНЭЧИЛЖ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ, НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, АСАРГААНЫ ХУВИЛБАРТ ҮЙЛЧИЛГЭЭГ ХӨГЖҮҮЛЖ, ХУВИЙН ХЭВШИЛ, ОРОН НУТАГ, ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ, ЗОРИЛТОТ БҮЛЭГТ ЧИГЛҮҮЛЭХ ЗАМААР НИЙГМИЙН ХАЛАМЖ ҮЙЛИЧЛГЭЭНИЙ ЧАНАР, ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 2.5.5-ЫН ХҮРЭЭНД: | | | | | | | |
| 1.4.1. | Зорилт 5: Зорилтот өрх, иргэдийн хэрэгцээ, шаардлагад үндэслэсэн 3-аас доошгүй үйлчилгээг шинээр үзүүлэх | үйл ажиллагааны зардал | Шинэчлэн үзүүлсэн үйлчилгээ /тоо/ | 0 | 1 | I-IV улирал | |
| 35. | 1.4.1.1.Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн | үйл ажиллагааны зардал | Өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /тоо/ | 0 | 1 | “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т “Халамжаас хөдөлмөрт шилжих бодлоготой уялдуулан хөдөлмөр эрхлэлт, нийгмийн үйлчилгээний эрх | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | найруулгын төслийг УИХ-д өргөн мэдүүлнэ.<br><br>*/Алсын хараа-2050 3.1.4, МУХТЖҮЧ 2021-2025 3.1.3, МУЗГҮАХ 2024-2028/* | | | | | зүйн орчныг шинэчилж, ядуурлыг бууруулах бодлого баримтална.” гэж заасан.<br>Энэхүү зорилтын хүрээнд Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүн өөрчлөгдсөнтэй холбоотойгоор 2024.12.20, 2025.09.25, 2025.12.09-ний өдрүүдэд Хууль зүй, дотоод хэргийн сайдтай 3 удаа хамтран баталсан.<br><br>Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, конвенц, бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулсан. Энэ хуулийн төсөлтэй холбогдуулан 21 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар хуулийн төслүүдийг боловсруулсан.<br><br>2025 онд яамдаас ирүүлсэн 2 удаагийн саналыг тусган хуулийн төслийг сайжруулан боловсруулж Улсын Их хуралд өргөн мэдүүлэхэд бэлэн болсон. Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэрэгжилтийн үр дагаварын үнэлгээ, зардлын тооцоо, дэлгэрэнгүй болон товч танилцуулга, үр нөлөөний үнэлгээ, хэлэлцүүлгүүдийн тайлан зэрэг иж бүрдлийг бүрэн хангасан. | |
| | | | Боловсруулсан баримт бичиг /тоо/ | 0 | 3 | Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг дагалдуулан зардлын тооцоо, үр нөлөөний үнэлгээг статистик тоо баримт, бодлогын зөвлөмж, судалгааны тайлангуудад үндэслэн боловсруулլаа.<br><br>Мөн хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хуулийн төслийг Засгийн газар, Улсын Их | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хуралд өргөн мэдүүлэхэд шаардлагатай дараах баримт бичгийг боловсруулсан:<br>1. Хуулийн төслийн үзэл баримтлал;<br>2. Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;<br>3. Дагалдах 21 хуулийн төсөл;<br>4. Хуулийн төслийн товч танилцуулга;<br>5. Хуулийн төслийн дэлгэрэнгүй танилцуулга;<br>6. Нийгмийн халамжийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварын үнэлгээ;<br>7. Хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ;<br>8. Зардлын тооцоо;<br>9. Хэлэлцүүлгийн тайлан /Олон нийт, холбогдох бусад байгууллага, иргэд/;<br>10. Бодлогын зөвлөмжийн нэгтгэл болон хуулийн төслийн хэлэлцүүлэгт шаардлагатай бусад материал.<br>Баримт бичгийг Хууль тогтоомжийн тухай хууль тогтоомжид заасан шаардлагад нийцүүлэн боловсруулж бэлтгэлээ. | |
| 36. | 1.4.1.2.Нийгмийн халамжийн үйлчилгээний хэрэгжилтийг зохион байгуулах хүрээнд Засгийн газрын тогтоолоор журмыг шинэчлэн батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллана. | үйл ажиллагааны зардал | Боловсруулж батлуулсан журам /тоо/ | 0 | 2 | 1.Засгийн газрын 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” 117 дугаар тогтоолын хавсралтаар “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд тусламж, хөнгөлөлт олгох журам”-ыг батлуулсан.<br>Журмын хэрэгжилтийг хангах үүднээс нэгдсэн ойлголт мэдээллийг хүргэхээр аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэст 2025 оны 11 сарын 14-ний өдрийн 01/3681 дугаар албан бичгээр чиглэл хүргүүлэх тухай бичгийг хүргүүлсэн.<br>Журам шинэчлэн батлагдсанаар төсөвт нэмэлт хөрөнгө шаардахгүй бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүнд хөнгөлөлт, тусламж үзүүлэх шат дамжлага багасаж, үйлчилгээг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | цахимжуулж, хяналт үнэлгээг сайжруулах юм. Энэ шинэчилсэн журам 2025 оны 12 сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжиж байна.<br><br>Журам боловсруулахад төр, төрийн бус, олон улсын байгууллага, албан хаагчидтай уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулан, санал авч журмын шинэчлэлд тусган ажилласан.<br><br>2.Засгийн газрын 2025 оны 05 сарын 21-ний өдрийн “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” 247 дугаар тогтоол "Хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох журам"-д өөрчлөлт оруулж батлуулсан.<br><br>Уг тогтоолд орсон нэмэлт, өөрчлөлтийн дагуу Монгол Улстай нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах олон улсын гэрээтэй Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Унгар Улс, Бүгд Найрамдах Польш Улс, Бүгд Найрамдах Турк Улс, Бүгд Найрамдах Чех Улс болон Бүгд Найрамдах Австри улсын харьяат, Монгол Улсад хууль ёсоор оршин суудаг гадаадын иргэн, харьяалалгүй хүний 0-18 хүртэлх насны хүүхдэд хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох ба 2025 оны 12 дугаар сарын байдлаар 12 хүүхдийн тэтгэмжийн хүсэлтийг хүлээн авсан.<br><br>Гадаадын иргэн харьяатын газраас авч буй сервист зарим гадаад иргэдийн оршин суух хугацаа, хаягийн мэдээлэл бүртгэлгүй байгаа тул бүрэн мэдээлэл солилцох талаар тус байгууллагатай хамтран ажиллаж байна. Мөн Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 24.3-т заасны дагуу албан болон хувийн хэргээр оршин суугч гадаадын иргэнд түүнийг харьяалах улсын товчлол, төрсөн он, сар, өдөр, хүйс зэрэг өгөгдлийг багтаасан | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хоорондоо давхцахгүй бүртгэлийн дугаараар нийгмийн халамжийн үйлчилгээг үзүүлэх тул тус бүртгэлийн дугаараа авсан, Халамжийн нэгдсэн системд ЮД регистрийн дугаараар бүртгэлтэй гадаадын иргэдийн үйлчилгээг хөрвүүлэх, бүртгэлийн дугаарыг аваагүй гадаадын иргэдийн үйлчилгээг зогсоох, мөн ЮД регистрийн дугаараар хүсэлт хүлээн авахгүй байх системийн хөгжүүлэлтийг хийлгэхээр Санхүүгийн мэдээллийн технологийн төвтэй хамтран ажиллаж байна.<br><br>3.Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн “Нийгмийн халамжийн сангаас олгох протез, ортопедийн болон тусгай хэрэгслийн жагсаалт, жишиг үнийг шинэчлэн батлах тухай” 363 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Нийгмийн халамжийн сангаас олгох протез, ортопедийн болон тусгай хэрэгслийн жагсаалт, жишиг үнэ”-д нэмэлт оруулж 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн Засгийн газрын 248 дугаар тогтоолыг батлуулсан.<br><br>Уг тогтоолд батлагдсан төсөвтэй уялдуулан байнгын асаргаа шаардлагатай, хүнд хэлбэрийн өдөр тутам живх хэрэглэдэг, 2-оос дээш насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд олгох живхний үнийг 3 жилд нэг удаа олгох 1,800,000 төгрөг олгохоор тусгасан. 2025 оны 12 дугаар сарын 01-ээс живх олголт улсын хэмжээнд хийгдэж эхлээд байна.<br><br>Түүнчлэн иргэдээс сонсголын аппаратны чанар, эдэлгээ, нийлүүлэлтийн асуудлаар өргөдөл, гомдол нэлээд олон ирдэг. Үүнтэй холбогдуулан хяналт, шалгалт, аудитын байгууллагаас олон зөрчил илрүүлж, дүгнэлт, зөвлөмж өгдөг. Иргэдийн хэрэгцээг хангадаггүй, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | чанар, эдэлгээ муутай, шуугьдаг, зай нь амархан мууддаг, хямд үнэтэй сонсголын аппарат нийлүүлдэг, таарч тохирохгүй сонсголын аппарат хэрэглэснээр гарч болзошгүй хүндрэл, бэрхшээл үүсдэг талаар иргэдээс гомдол ирдэг. Иймд Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн Засгийн газрын 248 дугаар тогтоолоор "сонсголын дижитал аппаратны чанарт тавигдах техникийн үзүүлэлт"-ийг нэмж тусган батлуулсан. Батлагдсан журмыг мөрдөж ажиллах тухай чиглэлийг ерөнхий газар, харьяа газар, хэлтэст хүргүүлэн хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. | |
| 37. | 1.4.1.3.Ахмад настны цогц тусламж, үйлчилгээ, идэвхтэй насжилтыг дэмжих үйлчилгээний үнэ тарифыг ГБХНХ-ын сайд, Сангийн сайдын хамтарсан тушаалаар баталж хэрэгжүүлнэ. | Улсын төсөв | Шийдвэр бүхий баримт бичиг /тоо/ | 0 | 1 | Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2025 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн "Үйлчилгээний жишиг үнэ, иргэний хариуцах төлбөрийн хэмжээ батлах тухай" А51/А37 дугаар хамтарсан тушаал тус тус батлан ахмад настанд үзүүлэх урт хугацааны тусламж үйлчилгээ үзүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэн ажиллаж байна.<br><br>Батлагдсан журмын хүрээнд аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсээс идэвхтэй насжилтыг дэмжих үйлчилгээ үзүүлэх 37 байгууллага, гэрээр асрах болон өдрөөр асрах үйлчилгээ үзүүлэх 22 байгууллага, байнга асрах үйлчилгээ үзүүлэх 1 байгууллагыг сонгон шалгаруулж гэрээ байгуулан ажиллаж байна. 2025 оны 11 дүгээр сарын тайлангаар идэвхтэй насжилтыг дэмжих үйлчилгээнд 19,992 ахмад настан хамрагдаж, 356,769,000 төгрөг, гэрээр асрах болон өдрөөр асрах үйлчилгээнд 1,506 ахмад настан хамрагдаж, 438,386,000 төгрөг, байнга асрах үйлчилгээнд 43 ахмад настан хамрагдаж, 178,885,430 төгрөг буюу нийт 21,541 ахмад | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | настан үйлчилгээнд хамрагдаж, 974,040,430 төгрөгийн санхүүжилтийг нийгмийн халамжийн сангаас олгоод байна. | |
| 38. | 1.4.4.4.Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний аргачлал заавар, шалгуур, журам, үнэ тарифыг шинэчлэн батлуулна. | Орон нутгийн төсөв | Батлуулах баримт бичиг /тоо/ | 0 | 3 | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн А/35, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн А/53 дугаар тушаалаар “Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний аргачлал, заавар, үйлчилгээний үнэ тариф, гэрээний загвар’’, Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний чанарт тавигдсан шалгуур, журмыг тус тус шинээр боловсруулан батлуулсан. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээ нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй өрхөд, ахмад настанд, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд, хүчирхийлэлд өртсөн иргэнд, согтуурах, мансуурах донтох өвчтэй иргэнд, хорих ангиас суллагдсан иргэнд, гэр оронгүй тэнэмэл амьдралтай өрх, иргэнд, өрх толгойлсон эх, эцэгт, шилжин суурьшсан нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэнд, эдгэшгүй хүнд өвчтэй иргэнд, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай энэ хуулийн 3.1.2-т заасан өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах үйлчилгээнд хамруулж байна. 2025 оны 11 сарын байдлаар 93 байгууллагатай гэрээ байгуулж 3357 өрх, иргэнд 1.2 тэрбум төгрөг зарцуулжээ. | 100 |

| 1.5. НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ӨӨРЧЛӨЛТ, ХҮН АМЫН НАСНЫ БҮТЦИЙН ХЭТИЙН ТӨЛӨВИЙГ ХАРГАЛЗСАН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТОГТОЛЦООНЫ ШИНЭЧЛЭЛИЙГ ЭРЧИМЖҮҮЛЭХ, НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХУУЛЬ ТОГТООМЖ, БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ, ЗОХИОН БАЙГУУЛАХ СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 2.5.4-ЫН ХҮРЭЭНД: | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.5.1. | Зорилт 1: Олон давхаргат тэтгэврийн тогтолцоог нэвтрүүлэх | үйл ажиллагааны зардал | УИХ-д өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /тоо/ | 0 | 1 | I-IV улирал | |
| 39. | 1.5.1.1. Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн УИХ-д өргөн мэдүүлнэ.<br><br>*/Алсын хараа-2050 3.1.4, ТТШТББ /2015-2030/ 3.2.17, МУХТЖҮЧ 2021-2025 3.1.1, МУЗГҮАХ 2024-2028 2.1.3.5/* | үйл ажиллагааны зардал | УИХ-д өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /тоо/ | 0 | 1 | Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/84 дүгээр тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан. Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг хамтран батлахаар 2025.02.05-ны өдрийн 01/374 дүгээр албан бичгээр, 2025.02.25-ны өдрийн 01/637 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн сайдад хүргүүлж, үзэл баримтлалыг хамтран баталсан. Хуулийн төсөлд яамны газар, хэлтэс, ажлын хэсгийн гишүүн байгууллагуудаас ирүүлсэн саналыг тусгаж ажилласан. Мөн хуулийн төслийн явцын танилцуулгыг 2025.04.14-ний өдөр Төрийн нарийн бичгийн даргад танилцуулж, өргөтгөсөн ажлын хэсгийн хурлыг 2025.04.17-ны өдөр хийж хуулийн төслийг эцэслэн хэлэлцэж дууссан. Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн болон дагалдах хуулийн төсөлд Засгийн газрын гишүүд, Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанкнаас санал авахаар 2025.05.05-ны өдрийн 01/1446 дугаар албан бичгээр тус тус хүргүүлж, ирүүлсэн саналыг тусгасан.<br><br>Засгийн газрын 2025.06.04-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэж, УИХ-д өргөн мэдүүлэхийг дэмжлээ. | 70 |
| | | | Дагах хуулийн төсөл /тоо/ | 0 | 13 | | |
| | | | Боловсруулсан үзэл баримтлал /тоо/ | 0 | 1 | | |
| | | | Хавсаргасан тооцоо, судалгаа /тоо/ | 0 | 2 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлэх бэлтгэл ажлыг хангаж ажиллаж байна. Мөн тус хуулийн төсөлтэй уялдуулан дагах 13 хуулийн төсөл боловсруулж, хувийн нэмэлт тэтгэврийн даатгалын тухай олон улсын туршлага, одоо зах зээл ижил төрлийн үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээдийн талаарх судалгааг боловсруулсан. | |
| 1.5.2. | Зорилт 2: Нийгмийн даатгалын сангийн тогтвортой байдлыг хангасан нийгмийн даатгалын тогтолцооны шинэчлэл хийх | үйл ажиллагааны зардал | УИХ-д өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /тоо/ | 0 | 1 | I-IV улирал | |
| 40. | 1.5.2.1. Нийгмийн даатгалын багц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн УИХ-д өргөн мэдүүлнэ.<br><br>*/МУЗГҮАХ 2024-2028 3.2.1.5./* | үйл ажиллагааны зардал | УИХ-д өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /тоо/ | 0 | 1 | Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн болон Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг тус тус боловсруулж, 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 01/1783, 01/1778 дугаар албан бичгээр Сангийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яаманд тус тус хүргүүлснээр Хуулийн төслүүдийн үзэл баримтлалыг хамтран баталсан.<br>Хуулийн төслийг боловсруулах хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн зарим зүйл, хэсэг, заалтын хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн зарим зүйл, хэсэг, заалтын хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан, хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ, Хуулийн төсөлд хийсэн зардлын тооцооны тайлан болон хуулийн төслүүдийг тус тус боловсруулсан. Хуулийн төслүүдийг Засгийн газрын 2025 оны 06 дугаар сарын 04-ний | 70 |
| | | | Боловсруулсан үзэл баримтлал /тоо/ | 0 | 1 | | |
| | | | Хавсаргасан тооцоо, судалгаа /тоо/ | 0 | 2 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хуралдаанаар хэлэлцэн дэмжиж, УИХ-д өргөн мэдүүлэхээр тогтсон.<br>Харин Засгийн газар шинэчлэн байгуулагдсантай холбогдуулан хуулийн төслийг Засгийн газрын 2025 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаанд дахин хэлэлцүүлсэн бөгөөд Засгийн гишүүдийн гаргасан саналын дагуу хуулийн төслийг хэлэлцэхийг хойшлуулаад байна. | |
| 41. | 1.5.2.2. Ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээгээр тохирсон хөдөлмөрийн хөлсөнд нийгмийн даатгалын шимтгэл ногдуулахдаа уян хатан, хөнгөлөлттэй байх нөхцөлийг бүрдүүлэх талаар холбогдох тооцоо, судалгаа хийнэ.<br><br>*/МУЗГҮАХ 2024-2028 3.2.1.6/* | үйл ажиллагааны зардал | Боловсруулсан судалгаа /тоо/ | 0 | 1 | Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд “өмчийн бүх хэлбэрийн хуулийн этгээд, хүнтэй ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээний дагуу ажиллаж байгаа ажилтан хэд хэдэн ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээний дагуу ажиллаж байгаа бол зөвхөн эхний гэрээгээр тохирсон цалин хөлснөөс нийгмийн даатгалын шимтгэл төлөх” болон “хөдөлмөрийн гэрээний дагуу албан журмаар даатгуулагч өмчийн бүх хэлбэрийн хуулийн этгээд, хүнтэй ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээний дагуу ажиллаж байгаа бол нийгмийн даатгалын шимтгэл төлөхгүй” гэсэн уян хатан зохицуулалтыг Хуулийн төслийн үзэл баримтлал, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн зарим зүйл, хэсэг, заалтын хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайланд үндэслэн тусгасан болно. | 100 |
| 42. | 1.5.2.3. Монгол Улсаас гадаад улстай нийгмийн хамгааллын олон улсын хэлэлцээр байгуулах чиглэлээр хамтран ажиллах, хэлэлцээ хийнэ. | үйл ажиллагааны зардал | Нийгмийн хамгааллын хэлэлцээр байгуулах чиглэлээр хамтран ажилласан улс /тоо/ | 3 | 4 | 1. Улаанбаатар хотноо 2024 оны 10 дугаар сарын 29-ний өдөр гарын үсэг зурсан “Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын Тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Засгийн газрын 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | */МУЗГҮАХ 2024-2028 2.3.1.6/* | | | | | дэмжиж, Улсын Их Хуралд 2025 10 дугаар сарын 30-ны өдөр өргөн мэдүүлсэн.<br>Улсын Их Хурлын 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар “Тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээрийг соёрхон батлах тухай” хуулийг баталсан бөгөөд “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2025 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн №47(1392) дугаарт нийтлэгдсэн.<br><br>2.“Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хоорондын хэлэлцээр”-ийн төслийг хэлэлцэх III шатны хэлэлцээр 2025 оны 03 дугаар сарын 08-ны өдрөөс 15-ны өдрийн хооронд Улаанбаатар хотод зохион байгуулж, Олон улсын гэрээний тухай хуулийн 9.3-т заасны дагуу Монгол Улсын Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон Бүгд Найрамдах Австри Улсын Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, сувилахуй, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах яам, Европ болон олон улсын харилцааны яам хооронд эцэслэн тохиролцсон.<br>Хэлэлцээрийн төслийг Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн, УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаар тус тус хэлэлцэн дэмжсэн. Хэлэлцээрт Улаанбаатар хотноо 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдөр гарын үсэг зурсан.<br>Түүнчлэн, тус Хэлэлцээр нь Олон улсын гэрээний тухай хуулийн 8.1.3-т заасан заавал соёрхон батлах олон улсын гэрээ тул “Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хоорондын хэлэлцээр соёрхон батлах тухай” хуулийн төслийг | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Засгийн газрын 2025 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэн дэмжиж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсэн.<br>Хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх бэлтгэл ажлыг хангаж байна.<br><br>3.Австралийн Холбооны Улстай байгуулах нийгмийн хамгааллын хэлэлцээрийн төслийг боловсруулах II шатны хэлэлцээг 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдөр цахим хэлбэрээр, III шатны хэлэлцээг 2025 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр цахим хэлбэрээр, IV шатны хэлэлцээг 2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдрөөс 13-ны өдрийн хооронд Улаанбаатар хотод тус тус хийсэн. Талууд хэлэлцээрийн төслөөр урьдчилсан тохиролцоонд хүрсэн бөгөөд дотоодын хяналтын шаардлагыг хангуулах, дараагийн шатны хэлэлцээг 2026 онд үргэлжлүүлэн хийхээр тохиролцсон.<br><br>4.Оросын Холбооны Улстай байгуулах нийгмийн хамгааллын хэлэлцээрийн төслийг боловсруулах шинжээчдийн ажлыг хэсгийн V шатны хэлэлцээг 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдөр цахим хэлбэрээр хийсэн. V шатны хэлэлцээгээр тохирсны дагуу Монгол Улс Засгийн газрын гишүүдээс 2025 оны 06 дугаар 27-ны өдрийн 01/2092 дугаар албан бичгээр санал авч, үр дүнгийн талаар ОХУ-ын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд 2025 оны 09 дүгээр сарын 16-ны өдөр албаны шугамаар хүргүүлээд байна. | |
| 2. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ | | | | | | | |
| 2.2.МОНГОЛ ХҮНИЙ АМЬДРАЛЫН ЧАНАРЫГ ДЭЭШЛҮҮЛЖ, ХҮН АМЫН БҮЛГҮҮДИЙН ХӨГЖИЛ ОРОЛЦООГ ХАНГАХ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ, НИЙГМИЙН ТААТАЙ ОРЧНЫГ БҮРДҮҮЛЭХЭД ЧИГЛЭСЭН САЛБАР ДУНДЫН ГЭР БҮЛД ЭЭЛТЭЙ ЦОГЦ | | | | | | | |

| БОДЛОГО БОЛОВСРУУЛЖ, ХҮН АМЫН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТ, ГЭР БҮЛ, ХҮНИЙ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 2.5.2-ЫН ХҮРЭЭНД: | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.2.1. | Зорилт 1: Хүн амын бүлгүүдэд чиглэсэн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, оролцоог хангах | Улсын төсөв | Батлагдсан хөтөлбөр, аргачлал, стандарт /тоо/ | 0 | 5 | I-IV улирал | |
| | | | Үйлчилгээнд хамрагдсан хүн амын бүлэг /тоо/ | 0 | 70000 | | |
| 43. | 2.2.1.1. Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр байгуулж, хүн амын бүлгүүдэд чиглэсэн үйлчилгээ нэвтрүүлнэ.<br><br>*/ЗГҮАХ 2024-2028- 2.1.1.4, 2.1.1.13, 2.1.1.15, 2.1.1.18/* | Улсын төсөв 20,000 | Гэр бүлийн хөгжлийн цогц төв /тоо/ | 0 | 4 | Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвийг ажиллуулахад ямар нэгэн барилга байшин шинээр барихгүй бөгөөд орон нутагт байгаа барилга, байгууламждаа түшиглэн ажиллуулах юм. 2025 онд Батноров, Бор-Өндөр сумдад Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвийг загвар болгон байгуулан ажиллуулж эхлээд байна. Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төв байгуулахад тухайн сумаас дэмжлэг үзүүлж, төв байгуулах байрыг шийдвэрлэж өгсөн бөгөөд Бор-Өндөр сумын Засаг даргын тамгын газраас 24 мкв байрыг засварлан хүлээлгэж өгсөн. Төвийн байрыг дотоод нөөц бололцоогоо ашиглаж тохижуулан одоо үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. Батноров сумын Засаг даргын тамгын газраас төв байгуулах байраар хангаж, байрны засварын ажлыг хийсэн. Сэлэнгэ аймагт Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний барилга байгууламж бэлэн болсон бөгөөд санхүүжилт шийдвэрлээгүйгээс төвийн үйл ажиллагааг 2026 оноос эхлүүлэхээр ажиллаж байна. Иймээс Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 01/3405 тоот албан бичгээр 2026 оны орон нутгийн төсөвт цогц төвийг ажиллуулах зардлыг тусгуулах чиглэлийг бүх шатны Засаг дарга нарт болон Иргэдийн | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төлөөлөгчдийн хурлын дарга нарт хүргүүлээд байна. Улсын нэгдсэн төсөвт энэ үйл ажиллагаанд тусгайлан батлагдсан төсөв тусгагдаагүй. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд орон нутгийн барилга байгууламж, хүний нөөцийг түшиглэн гэр бүлийн үйлчилгээний төв байгуулж, тухайн орон нутгыхаа хүн амын хөгжил, оролцоог дээшлүүлэх заавар боловсруулны дагуу эхний ээлжид төсвийн хүндрэлтэй байгаа ч 2 сум өөрсдийн нөөцөд тулгуурлан төвиыг нээн ажиллуулж байна. | |
| | | | Эхчүүд, эмэгтэйчүүдэд чиглэсэн хөтөлбөр, үйлчилгээ /тоо/ | 0 | 1 | Гэр бүлийг дэмжих анхдагч хуулийн төслийг боловсруулж байна. Энэхүү хуулийн төслийн хүрээнд гэр бүлийг дэмжих цогц төвүүдийг аймаг, дүүрэг бүрт байгуулахаар төлөвлөж байна. Цогц төвөөр үйлчлүүлэх эхчүүд, эмэтэйчүүдэд зориулсан нийгмийн цогц үйлчилгээний хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 25 хүний бүрэлдэхүүнтэйгээр 2025 оны 10 дугаар сарын 27-ны А/284 дугаар тушаалаар батлуулсан. Эхчүүд эмэгтэйчүүдэд зориулсан нийгмийн үйлчилгээний цогц хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийн хурлыг 2025.11.11-ний өдөр зохион байгуулсан. Хөтөлбөрийн дагуу Эмэгтэй удирдагч сан ТББ-ийн тэргүүн С.Болормаа "Эмэгтэйчүүдийн аж байдлыг сайжруулах талаар авч хэрэгжүүлж байсан арга хэмжээний талаар", ГББГ-ын ахлах шинжээч С.Цогтбаатар "Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төв ажиллуулах заавар, зөвлөмж" -ийн талаар, ГББГ-ын ахлах шинжээч М.Одонцэцэг "Эхчүүд, эмэгтэйчүүдэд зориулсан нийгмийн цогц үйлчилгээний хөтөлбөрийн төсөл"-ийн талаар тус тус танилцуулга хийсний дараа нэгдсэн хэлэлцүүлэг хийсэн. Тус хөтөлбөрийн зорилго нь охид, эмэгтэйчүүд, эхчүүдийн эрүүл мэнд, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | боловсрол, эдийн засаг, нийгмийн хамгаалал, сэтгэл зүйн дэмжлэг зэрэг олон талт хэрэгцээнд нь суурилсан цогц үйлчилгээг төр, хувийн хэвшил болон мэргэжлийн байгууллагуудын хамтын оролцоонд тулгуурлан хүртээмжтэй, үр нөлөөтэй хүргэх замаар тэдний хөгжил, хамгааллыг дэмжихэд оршино. Тус хөтөлбөрт мэдээлэл зөвлөгөө өгөх үйлчилгээ, сургалтын арга хэмжээ болон Эмэгтэйчүүдийн хөгжил, хамгааллыг дэмжих үйлчилгээ гэсэн үндсэн 3 арга хэмжээнээс бүрдэж байна. Энэхүү нийгмийн цогц хөтөлбөрийн хүрээнд эрүүл мэнд, боловсролыг дэмжих , эдийн засгийн чадавхжуулалт, ажил-амьдралын тэнцвэрт байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх, хувь хүний хөгжил, чадавхжуулалтын дэмжих зэрэг сургалтууд багтаасан төдийгүй, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээ, хүүхэд харах үйлчилгээ, хууль эрх зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээ, Аюулгүй байдлын хамгаалалтын үйлчилгээ зэргийг цогцоор багтааж өгснөөрөө нэг цэг дээрээс эмэгтэйчүүд эхчүүд өөрт хэрэгцээт үйлчилгээндээ хамрагдах боломжийг бүрдүүлж өгөх юм.Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлсний үр дүнд охид, эмэгтэйчүүд эрүүл мэнд, боловсрол, эдийн засаг, сэтгэл зүй, хамгааллын хэрэгцээнд суурилсан цогц үйлчилгээг авч, өөрийн нөөц боломжоо бүрэн ашиглах чадавхтай, хамгаалагдсан, идэвхтэй оролцоот иргэн болон хөгжих нөхцөл бүрдэнэ. Мөн хөтөлбөр нь эмэгтэйчүүдийн амьдралын чанарыг сайжруулж, хөдөлмөр эрхлэлт, орлого, аюулгүй байдал, нийгмийн оролцоог нэмэгдүүлэх бодит үр нөлөө гарна гэж үзэж байна. | |
| | | | Эрэгтэйчүүд, аавуудад чиглэсэн | 0 | 1 | Чанартай амьдрал гэр бүлийн гишүүдийн оролцооны хөтөлбөрт Эрэгтэйчүүд, аавуудад | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хөтөлбөр, үйлчилгээ /тоо/ | | | чиглэл үйлчилгээний хөтөлбөр боловсруулж байна. | |
| | | | Ахмадуудад чиглэсэн хөтөлбөр, үйлчилгээ /тоо/ | 0 | 1 | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/76, А/515 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Ахмад настанд цогц үнэлгээ хийх, тусламж үйлчилгээ үзүүлэх журам”-ын дагуу Гэр бүлийн хөгжлийн цогц төвөөр ахмад настанд үзүүлэх үйлчилгээний хувилбарыг боловсруулав. | |
| 44. | 2.2.1.2. Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээний стандарт, санхүүжүүлэх зардлын аргачлал, нормативыг батлан мөрдүүлнэ.<br><br>*/ЗГҮАХ 2024-2028 - 2.1.1.7/* | Улсын төсөв 4.9 тэрбум | Баталсан аргачлал, норматив | 0 | 1 | “Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын норматив”-ын төслийг боловсруулж, Боловсролын сайд, Сангийн сайдад санал авахаар 2025 оны 07 дугаар сарын 07-ны өдөр "Санал авах тухай" 01/2333 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Сангийн яамны 2025 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн 01/7383 дугаар албан бичиг, Боловсролын яамны 2025 оны 01/3073, 6/4697, 2/4908 дугаар албан бичгүүдээр ирүүлсэн саналыг үндэслэж, аргачлалд сайжруулалтыг хийсэн. Боловсролын сайдад 2025 оны 09 дүгээр сарын 29-ны өдөр 01/3073, Сангийн сайдад 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 01/3640 дугаар албан бичгүүдээр “Аргачлал, үйлчилгээний зардлын норматив”-ыг батлахаар хүргүүлсэн бөгөөд 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын Төсвийн зарлагын хэлтэс, 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдөр Боловсролын яамны Ерөнхий боловсролын газрын хамт олонтой аргачлал, үйлчилгээний зардлын нормативыг батлахтай холбогдуулж уулзалтыг хийсэн. Боловсролын сайдад 2025 оны 12 дугаар сарын 04-ний өдөр “Санал хүргүүлэх тухай” 01/3936 дугаар албан бичгээр "Аргачлал, үйлчилгээний зардлын норматив"- | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ын төслийг хүргүүлж батлуулсан. Сангийн сайдад хамтран батлуулахаар хүргүүлээд байна. | |
| | | | Батлагдсан стандарт /тоо/ | 0 | 1 | Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээний стандартын төслийг боловсруулж, Хүүхдийн хөгжил, хамгааллын стандартчиллын (ТХ-46) техникийн хорооны хурлаар хэлэлцүүлж, Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2025 оны С/27 дугаар тушаалаар “Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 7076:2025” стандартыг батлуулсан. Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын даргын 2025 оны А/125 дугаар тушаалаар байгуулагдсан 8 дэд ажлын хэсэг MNS 5633:2023, Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээнд тавих нийтлэг шаардлагын хэрэгжилтийн хяналт шалгалтыг Булган, Завхан, Орхон, Дундговь, Баянхонгор, Төв аймаг зэрэг 6 аймгийн 9 хүүхдийн зуслан, Баянзүрх, Налайх, Хан-Уул, Сүхбаатар дүүргийн 15 хүүхдийн зусланд хийж, мөн Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 7076:2025”-ыг сурталчлан мөрдөн ажиллах арга зүй өгч ажилласан. Салбарын 2026 оны төлөвлөгөөт хяналт, шалгалт хийгдэх объектын жагсаалтад Цагаан нуга, Энэрэл, Тамир, Тэрэлж boarding school, English camp, Янзага, Ундраа зэрэг зуслангуудад “Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 7076:2025 стандартын үзлэг шалгалтыг хийхээр төлөвлөсөн. | |
| | | | Хөгжлийн үйлчилгээнд хамрагдсан хүүхэд /тоо/ | 0 | 70000 | Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээнд 2025 оны 11 сарын байдлаар 184,426 хүүхдийг хамруулаад байна. Жилийн эцсийн тоон мэдээлэл 2026 оны 1 сард эцэслэн гарна. | |
| 45. | 2.2.1.3. НҮБ-ын Хүүхдийн эрхийн | Улсын төсөв 80.0 сая | Засгийн газрын | 0 | 1 | Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 02 дугаар сарын 13- | ХБ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | конвенцын МУЗГ-ын 6,7 дугаар тайланг боловсруулж, НҮБ-ын хүүхдийн эрхийн хороонд хүргүүлнэ.<br><br>*/Хүүхдийн эрхийн тухай конвенц, НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооны 5 дугаар зөвлөмжийн 49 дүгээр зүйл/* | | хуралдааны тэмдэглэл /тоо/; | | | ны өдрийн 03/771 дугаар албан бичгээр “Хүүхдийн эрхийн тухай конвенцын Хорооны Нарийн бичгийн дарга нарын газраас 2027 оныг хүртэл Монгол Улсын Хүүхдийн эрхийн тухай конвенцын хэрэгжилтийн талаарх ээлжит 6, 7 дугаар хамтатгасан илтгэлийг хялбаршуулсан журмаар бэлтгэж хүргүүлэх хуваарь хойшилсон”-ыг уламжилсан. 2027 онд Засгийн газрын тогтоол гарна. | |
| | | | Боловсруулсан тайлан /тоо/; | 0 | 1 | Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 03/771 дугаар албан бичгээр “Хүүхдийн эрхийн тухай конвенцын Хорооны Нарийн бичгийн дарга нарын газраас 2027 оныг хүртэл Монгол Улсын Хүүхдийн эрхийн тухай конвенцын хэрэгжилтийн талаарх ээлжит 6, 7 дугаар хамтатгасан илтгэлийг хялбаршуулсан журмаар бэлтгэж хүргүүлэх хуваарь хойшилсон”-ыг уламжилсан. Яамны зүгээс 2026 онд тайлан боловсруулах ажлын хэсэг байгуулж, мэдээлэл цуглуулна. | |
| 2.3. ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЗӨВ, ОНОВЧТОЙ БОДЛОГО БОЛОВСРУУЛЖ, ГЭР БҮЛД ЭЭЛТЭЙ, ЗОХИСТОЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ, ХӨДӨЛМӨРИЙН ХАРИЛЦААГ ТӨЛӨВШҮҮЛЭХ, ХӨДӨЛМӨРИЙН ХУУЛЬ ТОГТООМЖ, ЦАЛИН ХӨЛСНИЙ БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ТҮНШЛЭЛИЙН ГУРВАН ТАЛТ БОЛОН БУСАД ХАМТЫН АЖИЛЛАГААГ ХАНГАХ, САЛБАРЫН ХУУЛЬ ТОГТООМЖ, БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ, ЗОХИОН БАЙГУУЛАХ СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 2.5.3-ИЙН ХҮРЭЭНД: | | | | | | | |
| 2.3.1. | Агаарын бохирдлыг бууруулах талаар холбогдох хэмжээ авч хэрэгжүүлэх | Улсын төсөв | Агаарын бохирдлыг бууруулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ /тоо/ | 1 | 3 | I-IV | |
| 46. | 2.3.1.1. “Тэрбум мод хөтөлбөр”-ийг дэмжих хүрээнд хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд | Улсын төсөв | Мод тарих арга хэмжээнд хамрагдсан иргэн /тоо/ | 5100 | 2457 | Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаар “Түр ажлын байрыг дэмжих болон ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа”-г хэлэлцэн баталсан. | 50 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хамрагдах иргэдийг мод тарих арга хэмжээнд хамруулна. | | | | | Уг үйл ажиллагааны хүрээнд “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд байгаль орчинд ээлтэй үйл ажиллагааг дэмжих, иргэдийн идэвх санаачилгыг нэмэгдүүлэх, ажилгүй иргэн болон ахмад настны оролцоог хангах, тэдний орлогыг нэмэгдүүлэх зорилгоор мод услах, арчлах, орчныг хамгаалах арга хэмжээг зохион байгуулах арга хэмжээг улсын хэмжээнд хэрэгжүүлсэн.<br>2025 оны 11 дүгээр сарын сүүлчийн байдлаар тус арга хэмжээнд 161 байгууллага, 2457 иргэн хамрагдаж 1,151.0 сая төгрөг зарцуулсан байна.<br><br>Гүйцэтгэлийн хувь- 2025 оны 11 дүгээр сарын байдлаар 84 хувьтай байна. Хүлээгдэж буй гүйцэтгэлээр зорилтод түвшинд хүрэх боломжтой. | |
| 47. | 2.3.1.2. Нийслэлд оршин суудаг Нийгмийн халамжийн тухай хуулийн 22.1.1-д заасан хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ авдаг өрхийн ахмад настан болон хүндэт донор ахмад настанд нийтийн халаалтгүй сууц, гэрт амьдардаг бол түлш худалдан авах эрхийн бичиг олгох арга хэмжээ авна. | Улсын төсөв | Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ авдаг өрхийн ахмад настан болон хүндэт донор ахмад настан нийтийн халаалтгүй сууц, гэрт амьдардаг бол тэдэнд олгосон түлш худалдан авах эрхийн бичиг /тоо/ | 0 | 3000 | Ахмад настны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3-т заасан Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдаж байгаа өрхийн ахмад настанд орон сууцны хөлс төлөхөд, хэрэв нийтийн халаалтгүй сууц, гэрт амьдардаг бол түлш худалдан авахад зориулан жилд нэг удаа мөнгөн тусламжийг олгохоор туссан. Энэ заалт 2025 оноос эхлэн хэрэгжиж байна, энэ заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн А/186 дугаар тушаалаар "Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний журмыг шинэчлэн батлуулсан.<br><br>Тус журам нь 12 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөгдөж эхэлсэн. Журмын хүрээнд 180-аас доош оноотой 29,421 өрхийн жагсаалтыг аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэст хүргүүлж судалгааны мэдээллийг Захиргааны | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мэдээлэлтэй тулгаж мэдээлэл зөрүүгүй өрхийг үйлчилгээнд хамруулж байна. Одоогийн байдлаар мэдээлэл зөрүүгүй 3,500 өрхийг системд хамруулалт хийгдсэн байна. Жагсаалтад орсон өрх, иргэн нь зөрүүтэй мэдээллээ мэдээлэл хариуцагч байгууллагаар засварлуулан шинэчлүүлж зөрүүг арилгасан тохиолдолд Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэст байгуулагдсан ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлж үйлчилгээнд хамруулах эсэх шийдвэрийг гаргах юм.<br><br>Мөн хуулийн заалтаар хүндэт донор ахмад настанд орон сууцны хөлс төлөхөд, хэрэв нийтийн халаалтгүй сууц, гэрт амьдардаг бол түлш худалдан авахад зориулан жилд нэг удаа мөнгөн тусламж олгохоор заасны дагуу 2025 оны 11 сарын байдлаар 1,026 ахмад настан хамрагдаж, нийгмийн халамжийн сангаас 144,200.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна. | |
| 48. | 2.3.1.3.Нийслэлд нийтийн халаалтгүй сууц, гэрт амьдардаг Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд түлш худалдан авах эрхийн бичиг олгох арга хэмжээ авна. | Улсын төсөв | Нийслэлд нийтийн халаалтгүй сууц, гэрт амьдардаг хөгжлийн бэрхшээлтэй иргэнд түлш худалдан авахад олгосон эрхийн бичиг /тоо/ | 0 | 4000<br>22800 | 2025 онд шинэчлэн батлуулсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хөнгөлөлт, тусламж үзүүлэх журам”-ын 3.2-т Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 26.1.1-д заасан орон сууцны хөлс төлөхөд, хэрэв нийтийн халаалтгүй сууц, гэрт амьдардаг бол түлш худалдан авах мөнгөн тусламжийг жилд нэг удаа олгоход нэгдсэн системээс цахимжсан комисс /зөвлөл/-ын шийдвэрийг үндэслэн олгохоор заасан бөгөөд 2025 оны 12 дугаар сарын 01-ээс мөрдөж эхлээд байна. Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнээс бүрдүүлэх цаасан материал шаардахгүйгээр 100% цахимаар үйлчилгээ үзүүлэх боломжийг бүрдүүлсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Бүрэн цахимжих хугацаанд иргэдэд хүндрэл, чирэгдэл үүсгэхгүй байхад анхаарч, цаасан болон цахим хэлбэрээр түлш, орон сууцны мөнгөн тусламжийн үйлчилгээ үзүүлж байхыг ХХҮЕГ, аймаг, дүүргийн халамжийн газар, хэлтэст чиглэл өгч ажиллаж байна.<br><br>2025 оны 11 сарын байдлаар 22,981 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд түлш, орон сууцны хөлс төлөхөд зориулж 3.2 тэрбум төгрөгийн тусламжийг нийгмийн халамжийн сангаас зарцуулж, хүндрэл чирэгдэлгүй үйлчилгээ үзүүлсэн байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль шинэчлэн батлагдсаны дараа түлшний хөнгөлөлтийг эрхийн бичгээр өгөх нөхцөл бүрдэх бөгөөд түлш, орон сууцны мөнгөн тусламжийг нийгмийн халамжийн сангаас олгож байна. | |
| 2.4. НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ӨӨРЧЛӨЛТ, ХҮН АМЫН НАСНЫ БҮТЦИЙН ХЭТИЙН ТӨЛӨВИЙГ ХАРГАЛЗСАН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТОГТОЛЦООНЫ ШИНЭЧЛЭЛИЙГ ЭРЧИМЖҮҮЛЭХ, НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХУУЛЬ ТОГТООМЖ, БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ, ЗОХИОН БАЙГУУЛАХ СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 2.5.4-ЫН ХҮРЭЭНД: | | | | | | | |
| 2.4.1. | Зорилт 1: Нийгмийн даатгалын тогтолцооны шинэчлэлийг эрчимжүүлэх | Байгалийн баялаг, ногдол ашиг болон улсын төсөв | Хэрэгжүүлсэн арга хэмжээ /тоо/ | 0 | 2 | I-IV улирал | |
| 49. | 2.4.1.1. Үндэсний баялгийн сангаар дамжуулж хуримтлалын хөтөлбөрийг хэрэгжүүлж, иргэн бүрийн хуримтлалын нэрийн дансанд хүүгийн орлого болон ногдол ашгийг бүртгэнэ. | Байгалийн баялаг, ногдол ашиг | Хуримтлуулсан хөрөнгийн хэмжээ, /төгрөг/ | 495.6 тэрбум | 507.1 тэрбум | Монгол Улсын иргэн бүрд хуримтлалын нэрийн данс үүсгэх, хөтлөх, сангаас зарцуулалт хийх журмыг хэрэгжүүлэх хүрээнд Монгол Улсын нийт 3,565.9 мянган иргэний хуримтлалын нэрийн дансанд 138.9 мянган төгрөгийн бүртгэл үүсгэж, И-Монгол системийн Профайл цэсийн "Чингис Хаан" Үндэсний Баялгийн сан хэсгээс иргэн өөрийн нэрийн дансны үлдэгдлийг харах нөхцөлийг бүрдүүлсэн.<br>Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь заалт, Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 179 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | */МУЗГҮАХ 2024-2028 2.1.3.1/* | | | | | дүгээр тогтоолын дагуу Хуримтлалын санд 2024 онд төвлөрүүлсэн эх үүсвэрийг орон сууцны хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийг санхүүжүүлж, хуульд заасны дагуу арвижуулах зорилгоор 2024 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 81-0524/171 дүгээртэй “Хуримтлалын сангийн мөнгөн хөрөнгийг удирдах, арвижуулах гэрээ”-г Сангийн яам болон Монголбанк хооронд нэг жилийн хугацаатай байгуулсан.<br>Хуримтлалын сангийн мөнгөн хөрөнгийг удирдах, арвижуулах 2024 оны гэрээний хугацаа 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдөр дуусгавар болсонтой холбогдуулан тус гэрээний дагуу тооцогдсон хүүгийн өгөөжийг Монголбанк дахь Төрийн сангийн Хуримтлалын сангийн дансанд төвлөрүүлж, тус яам Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 10.3-т заасан хүүг иргэн бүрийн хуримтлалын нэрийн дансанд хуваарилан бүртгэл хөтлөх шаардлагатай байгаа талаар 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 01/1906 тоот албан бичгийг Сангийн яам болон Монголбанканд хүргүүлсэн.<br>Монгол Улсын Засгийн газраас Хуримтлалын сангийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх бодлогыг баримтлан ажиллаж байгаа бөгөөд Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 9, 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 10 дугаар хуралдааны тэмдэглэлийн дагуу “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн энгийн хувьцааны 2024 оны 2, 3 дахь удаагийн ногдол ашгаа хуримтлалын нэрийн дансандаа хуримтлуулах эсэх талаар “И-Монголиа” цахим системээр дамжуулан иргэдээс баталгаажуулах санал асуулгыг явуулахад 600 иргэн ногдол ашгаа хуримтлуулах санал өгсөн болно.<br>”Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн энгийн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хувьцааны 2024 оны 2, 3 дахь удаагийн ногдол ашгийг Хуримтлалын сангийн хуримтлалын нэрийн дансандаа хуримтлуулах саналыг “И-Монголиа” цахим системээр дамжуулан гаргасан иргэдийн ногдол ашгийг Монголбанкан дах Төрийн сангийн Үндэсний баялгийн сан (Хуримтлалын сан) шилжүүлэх зохицуулалтыг тусгасан "Хуримтлалын сангийн талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 01/874 тоот албан бичгээр яамдаас санал авч, Засгийн газрын, 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, 177 дугаар тогтоолоор батлуулсан.<br>Иргэн өөрийн хүсэлтээр хуримтлалын нэрийн дансанд оруулсан 2024 оны “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 1072 ширхэг хувьцааны ногдол ашгийн орлогыг төрийн үйлчилгээний нэгдсэн И-Монголиа системийн Профайл цэсийн "Чингис Хаан" Үндэсний Баялгийн сан хэсгээс Хуримтлалын нэрийн дансны мэдээллээс шалгах боломж бүрдүүлэхээр ажиллаж байна. | |
| 50. | 2.4.1.2. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн хэмжээг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлнэ. *\/МУЗГҮАХ 2024-2028 2.1.1.22/* | Улсын төсөв | Тэтгэврийн нэмэгдэл /хувь/ | 0 | 6 | Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт тэтгэвэр авагчийн тэтгэврийн хэмжээг өмнөх оны инфляцын жилийн дундаж түвшинтэй уялдуулж жил бүрийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн нэмэгдүүлэхээр заасан. Энэ хүрээнд Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 221 дүгээр тогтоолоор 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс нийгмийн даатгалын сангаас олгож байгаа болон цэргийн тэтгэвэр авагчийн авч байгаа тэтгэврийн хэмжээг 6 хувиар тус тус нэмэгдүүлсэн. Энэхүү арга хэмжээнд нийт | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 505.6 мянган тэтгэвэр авагч хамрагдаж, тэтгэврийн нэмэгдэлд 300.0 тэрбум төгрөг зарцуулсан. Ингэснээр дундаж тэтгэврийн хэмжээ 859.5 мянга, бүрэн тэтгэврийн доод хэмжээ 689.0 мянга, хувь тэнцүүлсэн тэтгэврийн хэмжээ 572.4 мянган төгрөгт тус тус хүрсэн.<br>Түүнчлэн, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулиар нийгмийн даатгалын сангаас олгож байгаа болон цэргийн тэтгэвэр авагчийн авч байгаа тэтгэврийн хэмжээг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс нэмэгдүүлэхэд шаардагдах 477.9 тэрбум төгрөгийг баталсан. Энэ хүрээнд бүх төрлийн тэтгэврийг 80.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэх тооцоолол хийн Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангаж байна. Засгийн газрын “Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх, тэтгэврийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоолын төсөлд Засгийн газрын гишүүдээс 2025 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 01/3943 дугаар албан бичгээр санал авч, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж байна. | |
| 3. ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ | | | | | | | |
| 3.1. МОНГОЛ ХҮНИЙ АМЬДРАЛЫН ЧАНАРЫГ ДЭЭШЛҮҮЛЖ, ХҮН АМЫН БҮЛГҮҮДИЙН ХӨГЖИЛ, ОРОЛЦООГ ХАНГАХ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ, НИЙГМИЙН ТААТАЙ ОРЧНЫГ БҮРДҮҮЛЭХЭД ЧИГЛЭСЭН САЛБАР ДУНДЫН ГЭР БҮЛД ЭЭЛТЭЙ ЦОГЦ БОДЛОГО БОЛОВСРУУЛЖ, ХҮН АМЫН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТ, ГЭР БҮЛ, ХҮНИЙ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 2.5.2-ЫН ХҮРЭЭНД | | | | | | | |
| 3.1.1. | Зорилт 1: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил бодлогын удирдамжаар хангах | | Хэрэгжүүлсэн арга хэмжээ /тоо/ | 10 | 25 | I-IV улирал | |
| 51. | 3.1.1.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх үйлчилгээний | үйл ажиллагааны зардал | Зураглал /тоо/ | 0 | 1 | Хүүхдийг эхийн хэвлийд бүрэлдэхээс эхлээд хөгжлийн хоцрогдол, хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, үнэлэх, нийгмийн оролцоог | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | зураглалыг боловсруулна. | | | | | хангахад чиглэсэн тогтолцоог оновчтой бүрдүүлэх асуудлыг холбогдох хууль тогтоомжид тусгаж, амьдралын туршид нь нийгмийн хамгааллын нийцсэн үйлчилгээ үзүүлэх зорилгоор хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх нийгмийн үйлчилгээний зураглалыг төрийн бус байгууллагуудтай хамтран боловсруулсан. Үйлчилгээний зураглалын төслийг Эрүүл мэндийн яам, Боловсролын яамны холбогдох төлөөлөлд танилцуулсан. Зураглалыг Эрүүл мэндийн яам, Боловсролын яамны холбогдох албан хаагчдад танилцуулан саналыг тусгав. Мөн 5 сарын 26-ны өдөр Төрийн бус байгууллагуудын төлөөллүүдэд танилцуулан санал авах уулзалтыг зохион байгуулав. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх үйлчилгээний зураглалын үр дүнд үндэслэн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, үнэлэх, нийгмийн оролцоог хангахад чиглэсэн зохицуулалтыг тусгасан. | |
| 52. | 3.1.1.2.Хөгжлийн бэрхшээлийн үйлдлийн чадамжийг тогтоох олон улсын аргачлалыг туршина.<br><br>*/ЗГҮАХ 2024-2028 - 2.1.1.25/* | Улсын төсөв 50 | Туршилт хийх аймаг, дүүрэг /тоо/ | 0 | 4 | Хөгжлийн бэрхшээлийн үйлдлийн чадамжийг тогтоох олон улсын аргачлал (ICF)-ыг ашиглаж буй салбаруудын өнөөгийн байдал, цаашдын хамтын ажиллагааны талаарх салбар дундын уулзалт, хэлэлцүүлгийг 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдөр зохион байгуулсан. Уулзалтын үр дүнд хөгжлийн бэрхшээлийн үйлдлийн чадамжийг тогтоох олон улсын аргачлалыг үе шаттай нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэх, Эрүүл мэндийн яам, Боловсролын яамтай хамтран ажиллах талаар ярилцсан. Мөн хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг тогтоож байгаа өвчин гэмтлийн жагсаалт, шалгуур үзүүлэлтэд Хөгжлийн бэрхшээлийн үйлдлийн чадамжийг тогтоох олон улсын аргачлал (ICF)-тай уялдуулан шинэчлэхээр Гэр | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн А/207 тоот тушаалаар “Байнгын асаргаа шаардлагатай 0-16 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өвчин, гэмтлийн жагсаалт, шалгуур үзүүлэлт”-ийг шинэчлэн боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан ажиллаж эхэлсэн. Хөдөлмөр эрхлэх сонирхолтой хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг бүртгэх, хэрэгцээ, ур чадварт нийцсэн үйлчилгээ үзүүлэх стратегийг боловсруулах, суурь мэдээллийг цуглуулах 2 үе шаттай бүртгэл, судалгааны ажлыг үндэсний хэмжээнд зохион байгуулж 1-р үе шат болох цахим бүртгэлд 50,000 гаруй хүн хамрагдсан. 1-р үе шатанд хөдөлмөр эрхлэх сонирхолтойгоо илэрхийлсэн гэсэн 15,400 гаруй иргэдээс 2-р ше шатанд асуумжийн аргаар судалгааг авч нэгтгэж байна. Уг судалгааны асуулгад үйлдлийн чадамжийг тогтоох асуулгыг багтаасан. Мөн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвөөс үйлчилгээ авах иргэдийн үнэлгээнд хөгжлийн бэрхшээлийн үйлдлийн чадамжийг тогтоох олон улсын аргачлал (ICF)-ыг ашиглахаар 120 гаруй иргэдийг хамруулсан туршилтын үнэлгээ хийсэн. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийн даргын 2025 оны А/03 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэх чадварыг үнэлэх маягт, аргачлалыг хөгжлийн бэрхшээлийн үйлдлийн чадамжийг тогтоох олон улсын аргачлал (ICF)-д суурилан хөгжлийн бэрхшээлийн 4 төрөл /Хараа, сонсгол, хөдөлгөөн, оюун ухаан/-д үнэлгээний хуудас, арга аргачлалыг боловсруулсан. 2025 оны 12 дугаар сарын 9–11-ний өдрүүдэд зохион | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгуулагдсан “Хөгжлийн бэрхшээлийн үйлдлийн чадамжийг тогтоох олон улсын аргачлал (ICF)-ын хэрэгжилт, салбар хоорондын хэрэглээний талаарх оролцогч талуудын зөвлөлдөх уулзалт”-д "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагаанд ICF-ыг ашиглах нь” сэдвээр илтгэл бэлтгэн оролцлоо. | |
| 53. | 3.1.1.3.Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийг аймаг, дүүрэгт байгуулна.<br><br>*/ЗГҮАХ 2024-2028 - 2.1.1.26/* | Улсын төсөв 6.000.0 | Хөгжлийн төвтэй болсон аймаг, дүүрэг /тоо/ | 6 | 8 | АХБ-ны санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах” төслийн хүрээнд тус яамнаас Баянзүрх дүүрэг, Завхан аймагт Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийг барьж, 2026 оны 09 дүгээр сард ашиглалтад оруулахаар төлөвлөсөн.<br>1.Завхан аймагт баригдах Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийг барих гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг нийт 3 удаа зарлаж, хамгийн сайн тендерээр үнэлэгдсэн “Морин сувд” ХХК-тай гэрээ байгуулсан.<br>2.Баянзүрх дүүрэгт баригдах Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийг барих гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн А/209 тоот тушаалаар батлуулж, тендерийг зарлаж, хамгийн сайн тендерээр үнэлэгдсэн “Хөххайрхан трейд” ХХК-тай 2025 оны 10 дугаар сарын 29-ний өдөр 02/156 тоот гэрээ байгуулсан.<br>3. “Хөгжлийн бэрхшээлтэй хүний талаар авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 164 дүгээр тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тогтоолын төслийг Засгийн газрын 2025 оны 04 дүгээр сарын 30- | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 212 дугаар тогтоолоор Өмнөговь аймаг дахь хөгжлийн төвийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын харьяанд ажиллуулах Засгийн газрын тогтоолыг батлуулсан. | |
| 54. | 3.1.1.4.Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих төвийг төв, орон нутагт ажиллуулна | үйл ажиллагааны зардал | Үйл ажиллагаа явуулах төв /тоо/ | 4 | 10 | Улсын хэмжээнд байнгын асаргаа шаардлагатай, боловсролын үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаа хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг дэмжих төвөөр дамжуулан хөгжүүлэх, үйлчилгээнд хамруулах зорилгоор 2025 оны төсөвт 7 тэрбум төгрөг тусгасан байна. 2025 оны байдлаар Улаанбаатар хотод 11, орон нутагт 1 буюу нийт 12 төв ажиллаж, 4.6 тэрбум төгрөгийн гэрээний санхүүжилтээр 635 хүүхдэд үйлчилгээ үзүүлсэн байна. Дэмжих төвд хамрагдсан хүүхдэд хувь хүний үнэлгээ, хэрэгцээнд нь үндэслэн эрүүл мэндийн тусламж, боловсролын дэмжлэг, асаргаа сувилгаа болон хөгжлийн цогц үйлчилгээ хүргэж байгаа юм. Тус үйлчилгээгээр дамжуулан хүүхдийн хөгжлийн ахиц, нийгмийн оролцоо нэмэгдэх төдийгүй асран хамгаалагчдын хөдөлмөр эрхлэх боломж сайжирч, гэр бүлийн амьдралын чанарт эерэг нөлөө үзүүлж байна. Дэмжих төвийн орон нутагт ажиллуулах талаар орон нутгийн Хүүхэд, гэр бүл, хөгжил хамгааллын газрын удирдлага болон Аймгийн Засаг дарга, нийгмийн бодлогын хэлтсийн дарга нарт мэдээлэл өгч ажилласан. | 100 |
| 55. | 3.1.1.5.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын | үйл ажиллагааны зардал | -Засгийн газрын тогтоол /тоо/;<br>-Сайдын тушаал /тоо/; | 0 | 2 | Засгийн газрын 2021 оны 173 дугаар тогтоолоор батлагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын дүрэм”-ийг шинэчлэн боловсруулж, төрийн болон төрийн бус байгууллага, салбар комиссын гишүүдэд 2 | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | холбогдох дүрэм, журмыг шинэчилнэ. | | | | | удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын гишүүдээс саналыг авч тусгасан. Дүрмийн төслийг боловсруулан яамдаас санал авахаар хүргүүлсэн. | |
| 4. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ | | | | | | | |
| 4.1.ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БОЛОН ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ, БАЙГУУЛЛАГЫН СОЁЛЫГ ТӨЛӨВШҮҮЛЭХ, ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ, ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ, ХУУЛЬ ТОГТООМЖ СУРТАЛЧЛАХ, СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ, ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГААГ ХӨГЖҮҮЛЭХ, ӨРГӨЖҮҮЛЭХ, ЯАМНЫ САНХҮҮГИЙН ӨДӨР ТУТМЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 2.5.1-ЫН ХҮРЭЭНД: | | | | | | | |
| 4.1.1. | Зорилт 1: Салбарын гадаад хамтын ажиллагааг эрхэлж, гадаад орон, олон улсын байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийг зохицуулахад дэмжлэг үзүүлэх | Улсын төсөв | Салбарын гадаад хамтын ажиллагааны чиглэлээр төлөвлөсөн арга хэмжээ хэрэгжсэн эсэх / тийм-1, үгүй-0/ | 0 | 1 | I- IV улирал | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 56. | 4.1.1.Монгол Улс, гадаад улс хоорондын хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр хэлэлцээр болон санамж бичиг байгуулахад зохицуулалтаар хангах, арга зүйн дэмжлэг үзүүлнэ. | Улсын төсөв | Англи хэл дээр боловсруулсан баримт бичиг /тоо/ | 0 | Гүйцэтгэл-ээр /тоо/ | -Монгол-Австрийн Засгийн газар хооронд байгуулах “Нийгмийн хамгааллын хэлэлцээр”-т гарын үсэг зурсан. Энэхүү хэлэлцээр нь Монгол, Австрийн парламентууд соёрхон батalснаар хүчин төгөлдөр болохоор хүлээгдэж байна.<br><br>-Монгол-Оросын Засгийн газар хоорондын 1981 онд байгуулагдсан “Нийгмийн хангамжийн салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр”-ийг шинэчлэхээр 2018 оноос 2 талын шинжээчдын ажлын хэсэг ажиллаж, нийт 5 удаагийн хэлэлцээ хийгдсэн. Хоёр талын дотоодын холбогдох яамдын санал эцэслэгдэж, хэлэлцээрийг шинэчлэн байгуулах чиглэлээр үргэлжлүүлэн ажиллаж байна.<br><br>-Монгол-Австралийн Засгийн газар хооронд байгуулах “Нийгмийн хамгааллын хэлэлцээр”-ийн 3 удаагийн цахим уулзалтууд хийгдсэн. 2025 оны 11 дүгээр сард Австралийн Холбооны Улсын Засгийн газрын төлөөлөгчид Монгол Улсад дээрх хэлэлцээрийг байгуулах асуудлаар ажиллав.<br><br>-Монгол-Казахстаны Засгийн газар хоорондын тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээрийг 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр Улсын Их хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж соёрхон баталсан.<br><br>-Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг шинэчлэн байгуулах чиглэлээр хамтран ажиллаж байна.<br><br>-Монгол Улс БНСУ хооронд “Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох тогтолцооны дагуу ажилтан илгээх болон хүлээн авах тухай харилцан ойлголцлын санамж бичиг”-ийг ойрын | 100 |
| | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хугацаанд шинэчлэн байгуулах чиглэлээр хамтран ажиллаж байна.<br><br>Европын холбооноос цалин хөлсний асуудлаар зөвлөх урьж ажиллуулах хүсэлт, ажлын даалгавар бүхий баримт бичгийг боловсруулж, орчуулахад дэмжлэг үзүүлж, Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөр эрхлэлтийн бодлогын газартай хамтран ажиллав. | |
| 57. | 4.1.2.НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд, Хөгжлийн байгууллагуудтай хамтран ажиллана. | | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр гадаад улсуудтай хамтран ажилласан эсэх /тийм-1, үгүй-0/ | 0 | 1 | Олон улсын хөдөлмөрийн Бага хурлын 113 дугаар чуулган 2025 оны 06 дугаар сарын 2-13-ны өдрүүдэд Швейцарын Холбоон Улсын Женев хотноо зохион байгуулагдлаа. Чуулганд Монгол Улсыг төлөөлж Засгийн газар, ажил олгогч болон ажилтны төлөөлүүд оролцсон. Монгол Улсын төлөөлөгчдийг НҮБ-ын Женев дэх төв болон олон улсын бусад байгууллагын дэргэд суугаа Байнгын төлөөлөгч, Элчин сайд Д.Гэрэлмаа ахалж оролцсон бөгөөд 6 дугаар сарын 5-ны өдрийн Чуулганы нэгдсэн хуралдаанд Монгол Улсад зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хууль, эрх зүйн орчны шинэчлэл, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг сайжруулах чиглэлээр Засгийн газраас авч хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагааны талаар танилцуулж, үг хэлэв. Төлөөлөгчдийн ахлагч Д.Гэрэлмаа Монгол Улсын Засгийн газраас Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ОУХБ)-тай хамтран хөдөлмөр эрхлэлтийн хууль, эрх зүйн орчны цогц үнэлгээ хийж, хөдөлмөрийн хяналтын тогтолцоог бэхжүүлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжоо шинэчлэх, албадан хөдөлмөрийн бүх хэлбэрийг устгахад анхаарч ажиллаж байгаагийн зэрэгцээ байгаль орчны тогтвортой байдал, зохистой хөдөлмөр эрхлэлтийг хослуулах замаар ногоон эдийн засагт шилжих | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шилжилтийг дэмжиж, сэргээгдэх эрчим хүчний салбарт хөрөнгө оруулалт хийж, ногоон ур чадварыг хөгжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлж байгаа талаар танилцуулав. Түүнчлэн Монгол Улсын Засгийн газар 2025 онд нийгмийн хамгааллын хүртээмжийг сайжруулах, тэтгэмж олгох ажлыг цахимжуулах, тэтгэврийн тогтолцоог шинэчилж, нийгмийн даатгалын тогтолцоог илүү хүртээмжтэй, шуурхай болгох шинэчлэлийн алхмуудыг авч хэрэгжүүлж байгааг мэдээлэв. Нийгмийн гурван талт яриа хэлэлцээ нь Монгол Улсын хөдөлмөрийн бодлогын тулгын чулуу болохыг Байнгын төлөөлөгч онцолж, Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт Үндэсний хороо нь хөдөлмөрийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох, зохистой хөдөлмөрийг дэмжих, хөдөлмөр эрхлэлтийн шинэ тутам асуудлыг хэлэлцэн шийдвэрлэхэд идэвхтэй үүрэг гүйцэтгэсээр байгааг тэмдэглэлээ.<br><br>Энэ удаагийн ээлжит чуулганаар биологийн аюултай хүчин зүйлээс хамгаалах тухай олон улсын конвенц, зөвлөмж батлах, эдийн засагт зохистой хөдөлмөрийг хангах талаар олон улсын конвенц боловсруулах, албан бус хөдөлмөр эрхлэлтийг бууруулж, албан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих шинэлэг арга зам хэлэлцүүлэг, энэ оны 11 дүгээр сард Доха хотноо болох Нийгмийн хөгжлийн асуудлаарх дэлхийн хоёрдугаар чуулга уулзалтад ОУХБ-аас дэвшүүлэх гурван талт санал, зөвлөмж, Далайн хөдөлмөрийн тухай конвенцын Дүрэмд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл, ОУХБ-ын суурь конвенциудын хэрэгжилт зэрэг асуудлыг хэлэлцэв. | |
| | | | Чуулган болон бага хуралд | 0 | 1 | -2025 оны 03 дугаар сарын 09-21-ний өдрүүдэд АНУ-ын Нью-Йорк хотноо НҮБ-ын Эдийн засаг, | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | орлцуулах төлөөлөгчийн бэлтгэл хангасан эсэх /тийм-1, үгүй-0/ | | | нийгмийн зөвлөлийн эмэгтэйчүүдийн аж байдлын 69 дүгээр чуулганд Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзулаар ахлуулсан төлөөлөгч нар Ерөнхий хэлэлцүүлэгт Монгол Улсын сүүлийн 30 жилд жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн эрхийг хангах чиглэлээр олсон амжилт, үр дүнгээс танилцуулсан. Чуулганы үеэр Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул Монгол, Аргентин, Турк, Шинэ Зеланд, Европын Холбооны төлөөлөгчийн газраас хамтран зохион байгуулсан "Бээжин+30: Эмэгтэйчүүд, охидын эсрэг хүчирхийллийг устгах хариуцлагыг дээшлүүлэх асуудал" сэдэвт арга хэмжээнд үг хэлэхийн зэрэгцээ мөн асуудлаар ИБУИНХУ, Канад, Колумб, Мексик, Францын өндөр түвшний төлөөлөгчидтэй ажил хэргийн уулзалтад оролцож, манай улсад эмэгтэйчүүд, охидын эсрэг хүчирхийллийг устгах, урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй бодлого, арга хэмжээг танилцуулж, санал солилцов. ЭБАК-ын 69 дүгээр чуулганаас Дэлхийн эмэгтэйчүүдийн дөрөвдүгээр бага хурлын 30 жилийн ойд зориулсан Улс төрийн тунхаглал болон ЭБАК-ын дараачийн жилүүдийн үйл ажиллагааны хөтөлбөрийг тогтоолоор батлав.<br><br>-ГБХНХ-ын Сайдын зөвлөх Г.Саран, шинжээч О.Ундрал нар Катар Улсын Доха хотноо 11 дүгээр сарын 3-6-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Нийгмийн хөгжлийн Дэлхийн II дээд хэмжээний чуулганд амжилттай оролцож, нийгмийн хамгааллын бодлогоор бүс нутагтаа манлайлагч орон гэдгээ бататгав. Төлөөлөгчид уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй, хүртээмжтэй хөгжлийн асуудлаар олон улсын тавцанд туршлагаа хуваалцаж, хүүхдийн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мөнгөний бүх нийтэд чиглэсэн бодлого, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамт олонд түшиглэн дэмжих аргачлал, COVID-19 үеийн уян хатан хамгааллын туршлагыг сайшаалтайгаар үнэлүүлэв. Монгол Улс цаашид нийгмийн хамгааллын хүртээмжийг өргөжүүлэх, эмзэг бүлгийн үйлчилгээ, боловсрол, эрүүл мэндийг сайжруулах зорилтоо илэрхийлэв. Чуулганд 40 орны төрийн тэргүүн, 170 сайдын түвшний төлөөлөгч, нийт 14 мянга гаруй хүн оролцож, Тогтвортой хөгжлийн зорилтуудыг дэмжсэн Дохагийн Улс төрийн тунхаглалыг баталсан өндөр үр дүнтэй арга хэмжээ болж өндөрлөв.<br><br>-НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн зөвлөлийн эмэгтэйчүүдийн аж байдлын 70 дугаар чуулганы бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.<br><br>-Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзулыг Америкийн Нэгдсэн Улсын Вашингтон хотноо 2025 оны 10 дугаар сарын 11-18-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Дэлхийн банк, Олон улсын валютын сангийн жилийн уулзалтад Монгол Улсын тэтгэврийн даатгалын тогтолцоог шинэчлэх техник туслалцааны төслийг ОУВС-ийн санхүүгийн дэмжлэгээр хэрэгжүүлэх асуудлыг хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг бүрэн ханган ажилласан. | |
| 58. | 4.1.3. Яамны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, түүний хэрэгжилтийн тайланг гаргах ажлыг зохион байгуулна. | үйл ажиллагааны зардал | Төлөвлөгөө /тоо/ | 0 | 1 | Төлөвлөгөө 1:<br><br>ГБХНХЯ-ны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Төрийн нарийн бичгийн даргын 2024.12.26-ны өдрийн А/195 дугаар тушаалаар байгуулсан ажлын хэсэг тус гүйцэтгэлийн төлөвлөгөөг ЗГХЭГ-ын даргын 2020 оны 100 тоот тушаалын 3 дугаар | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хавсралтын дагуу боловсруулж, Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан.<br><br>ГБХНХЯ-ны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, “Алсын хараа-2050” зэрэг бодлогын баримт бичигт гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр дэвшүүлсэн зорилт, арга хэмжээтэй уялдуулав.<br><br>Яамны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 128 арга хэмжээ /209 шалгуур үзүүлэлт/ авч хэрэгжүүлэхээр төлөвлөсний 46 нь бодлогын баримт бичигт тусгагдсан, 8 нь хуулиар тусгайлан олгосон чиг үүргийн, 5 нь хуулиар олгосон чиг үүргийн, 50 нь хуулиар олгосон нийтлэг чиг үүргийн, 19 нь төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилтын 19 арга хэмжээ байна.<br><br>Түүнчлэн Засгийн газрын 2025 оны “Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай” 07 дугаар тогтоол, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны “Яамны бүтэц, зохиион байгуулалтын нэгжийг шинэчлэн батлах тухай” А/218 дугаар тушаал батлагдсантай холбогдуулан Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний арга хэмжээг хариуцах газар, нэгжийн чиг үүрэг өөрчлөгдсөн тул ЗГХЭГ-ын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 3 дугаар хавсралтын дагуу хариуцах газар, нэгжийг | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | өөрчлөн боловсруулж, 2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдөр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан. Батлагдсан төлөвлөгөөг цахимаар нийт албан хаагчдад хүргүүлж, танилцуулсан. | |
| | | | Тайлан /тоо/ | 0 | 2 | ГБХНХЯ-ны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 128 арга хэмжээний 209 шалгуур үзүүлэлт баталсаны эхний хагас жилд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 113 арга хэмжээний 192 шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшингийн биелэлтийг нэгтгэн боловсруулж, ХШҮДАГ-т хүргүүлэв.<br><br>ГБХНХЯ-ны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 125 арга хэмжээний жилийн эцсийн тайланг шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшингийн биелэлтийг нэгтгэн боловсруулж, СХШҮДАГ-т хуулийн хугацаанд хүргүүлэв. | |
| 59. | 4.1.4. Салбарын стратеги төлөвлөгөө, яамны ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн болон яамны 2025 оны сар бүрийн үйл ажиллагааны тайлан гаргах ажлыг зохион байгуулна. | үйл ажиллагааны зардал | Салбарын стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх ГБХНХЯ-ны 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийн тайлан /тоо/ | 0 | 1 | ГБХНХ-ын сайдын 2025.05.26-ны өдрийн А/119 дүгээр тушаалаар баталсан "Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын 2025-2028 оны стратеги төлөвлөгөө"-нд 2025 онд хийхээр төлөвлөсөн нийт 16 зорилтын 64 шалгуур үзүүлэлтийн биелэлтийг эхний хагас жилийн байдлаар гарган ХШҮДАГ-т цахим хэлбэрээр хүргүүлсэн.<br><br>2025 онд хийхээр төлөвлөсөн 16 зорилтын 64 шалгуур үзүүлэлтийг чиг үүргээр нь авч үзвэл:<br>1/ Хүн амын гэр бүлийг дэмжих хөгжлийн бодлогын 3 зорилт 18 шалгуур үзүүлэлт;<br>2/ Хөдөлмөрийн бодлогын 4 зорилтын 10 шалгуур үзүүлэлт;<br>3/ Нийгмийн халамжийн бодлогын 3 зорилтын 13 шалгуур үзүүлэлт;<br>4/ Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын 5 зорилтын 9 шалгуур үзүүлэлт; | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 5/Салбарын цахимжилт, мэдээллийн технологийн 1 зорилтын 14 шалгуур үзүүлэлт байна.<br>“Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын 2025-2028 оны стратеги төлөвлөгөө”-нд 2025 онд хийхээр төлөвлөсөн нийт 16 зорилтын 64 шалгуур үзүүлэлтийн биелэлтийг 2025 оны жилийн эцсийн байдлаар гарган хуулийн хугацаанд СХШҮДАГ-т хүргүүлэхээр ажиллаж байна. | |
| | | | Яамны 2024 оны ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн тайлан /тоо/ | 0 | 1 | ГБХНХЯ-ны Нээлттэй мэдээллийн ил тод байдлын нийт 48 заалтын хэрэгжилтийг 2025 оны эхний хагас жилийн байдлаар нэгтгэн боловсруулж, хуулийн хугацаанд багтаан ХШҮДАГ-т хүргүүлэв. Үүнд:<br>1. Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдлын 10 заалт;<br>2. Хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдлын 6 заалт;<br>3. Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдлын 14 заалт;<br>4. Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдлын 2 заалт;<br>5. Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдлын 16 заалтын биелэлтийг тус тус нэгтгэв.<br>ГБХНХЯ-ны Нээлттэй мэдээллийн ил тод байдлын нийт 48 заалтын хэрэгжилтийг 2025 оны жилийн эцсийн байдлаар нэгтгэн боловсруулж, хуулийн хугацаанд багтаан СХШҮДАГ-т хүргүүлэхээр ажиллаж байна. | |
| | | | Засгийн газрын хяналт-шинжилгээ, | 1 | 12 | Тайлан 6:<br>ГБХНХЯ-ны 2025 оны 1, 2, 3, 4, 5, 6 дугаар саруудын үйл ажиллагааны тайланг хуулийн хугацаанд нэгтгэн “Засгийн газрын хяналт- | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | үнэлгээний цахим систем”-д байршуулсан яамны 2025 оны сар бүрийн үйл ажиллагааны тайлан /тоо/ | | | шинжилгээ, үнэлгээний цахим систем” (www.unelgee.gov.mn)-д хугацаанд нь байршуулж баталгаажуулав. Тайланг хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох, бодлого төлөвлөлтийг сайжруулах, бодлогын хэрэгжилтийг зохицуулах, санхүү, хөрөнгө оруулалт, дотоод ажил, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх гэсэн 6 чиглэлээр, гүйцэтгэсэн ажлыг тулгамдсан болон хоцорч буй ажил, УИХ, ЗГ-т өргөн барьсан, салбарын хүрээнд хийгдсэн болон шинэлэг ажил гэсэн 4 төрлөөр тус тус гарган хүргүүлж ажиллав.<br>ГБХНХЯ-ны 2025 оны 7, 8, 9, 10, 11, 12 дугаар саруудын үйл ажиллагааны тайланг хуулийн хугацаанд нэгтгэн “Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим систем” (www.unelgee.gov.mn)-д хугацаанд нь байршуулж баталгаажуулав. Тайланг хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох, бодлого төлөвлөлтийг сайжруулах, бодлогын хэрэгжилтийг зохицуулах, санхүү, хөрөнгө оруулалт, дотоод ажил, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх гэсэн 6 чиглэлээр, гүйцэтгэсэн ажлыг тулгамдсан болон хоцорч буй ажил, УИХ, ЗГ-т өргөн барьсан, үр дүнд хүрсэн гэсэн 3 төрлөөр тус тус гарган хуулийн хугацаанд хүргүүлж ажиллалаа. | |
| 60. | 4.1.5. Монгол Улсын хөгжлийн урт, дунд, богино хугацааны 4 бодлогын баримт бичигт гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр 2024 онд хэрэгжүүлэхээр дэвшүүлсэн зорилт, | үйл ажиллагааны зардал | 4 бодлогын баримт бичгийн тайлан /тоо/ | 1 | 10 | Тайлан-8:<br>1/ Улсын Их Хурлын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 23 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 2025 оны хэрэгжилтийг холбогдох газар, нэгжүүдээс авч нэгтгэн боловсруулж ХШҮДАГ-т хүргүүлэв.<br>2/1. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” | 100 |
| | | | Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн тайлан /тоо/ | 1 | 1 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | арга хэмжээ, ГБХНХЯ-ны 2024 оны эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн хэрэгжилтийн тайлан гаргах ажлыг зохион байгуулна. | | | | | Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын тайлангийн тайланг хагас жилийн байдлаар гаргаж 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр ЗГХЭГ-т цахим хэлбэрээр хүргүүлсэн. Түүнчлэн 82 зорилтын 84 арга хэмжээний хэрэгжилтийг холбогдох газар, нэгжүүдээс авч нэгтгэн боловсруулж, СХШҮДАГ-т 2025 оны 10 дугаар сарын 03-ны өдөр цахим хэлбэрээр хүргүүлсэн.<br><br>3/ Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 218 дугаар тогтоолоор батлагдсан “Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ”-ний төлөвлөгөөний 58 зорилтын 105 арга хэмжээний хэрэгжилтийг эхний улирлын байдлаар газар, нэгжүүдээс авч нэгтгэн боловсруулж 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдөр ХШҮДАГ-ын цахим хэлбэрээр хүргүүлсэн.<br>Тус тайланг 2025 оны эхний хагас жилийн байдлаар гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр туссан 62 зорилтын 104 арга хэмжээний хэрэгжилтийг холбогдох газар, хэлтсүүдээс авч нэгтгэн ХШҮДАГ-т цахим хэлбэрээр хүргүүлсэн. Түүнчлэн 2025 оны хагас жилийн биелэлтээр “Үр дүнгүй” үнэлэгдсэн 41 арга хэмжээний тайлан, тайлбарыг нотлох баримтын хамт нэгтгэн боловсруулж 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр СХШҮДАГ-т хүргүүлэв. Мөн жилийн эцсийн байдлаар нэгтгэн боловсруулж 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдөр СХШҮДАГ-т цахим хэлбэрээр хүргүүлсэн.<br>4/ Улсын Их Хурлын 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 35 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-ний зорилт, арга хэмжээний | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэрэгжилтийг тайлагнах хүснэгтийн загварыг боловсруулан 01 дүгээр улирлын байдлаар гарган 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдөр ХШҮДАГ-т хүргүүлэв.<br>-Монгол Улсын 2025 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэлийн 52 арга хэмжээний хэрэгжилтийг 1 дүгээр хавсралтаар;<br>-Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний 12 арга хэмжээний хэрэгжилтийг 2 дугаар хавсралтаар;<br>-Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хяналт-шинжилгээ, үнэлгээний жилийн үзүүлэлтийн 8 арга хэмжээний хэрэгжилтийг хавсралтаар тус тус гарган ХШҮДАГ-т заасан хугацаанд багтаан хүргүүлэв.<br>Түүнчлэн 2025 оны эхний хагас жилийн байдлаар “Үр дүнгүй” үнэлэгдсэн 6 арга хэмжээний хэрэгжилт, тайлбарыг нэгтгэн боловсруулж 2025 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр СХШҮДАГ-т хүргүүлсэн. Мөн тус тайланг 2025 оны жилийн эцсийн байдлаар нэгтгэн боловсруулж 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдөр СХШҮДАГ-т цахим хэлбэрээр хүргүүлэв.<br>ГБХНХЯ-ны 2024 оны Эдийн засаг, нийгмийн хөгжлийн 19 үзүүлэлтийн биелэлтийг нэгтгэн, хуулийн хугацаанд ХШҮДАГ-т хүргүүлсэн. | |
| 61. | 4.1.6.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг цахимд байршуулж, хэрэгжилтийн тайланг нэгтгэн боловсруулах ажлыг зохион байгуулна. | үйл ажиллагааны зардал | ЗГ-ын шийдвэрийг ABLE-д байршуулсан эсэх /тийм, үгүй/ | 0 | 1 | 2025.06.17-ны байдлаар нийт 101 шийдвэрийг Засгийн газрын хуралдааны цахим системээс ГБХНХЯ-ны ABLE цахим системд яамны нийт албан хаагчдад харагдах байдлаар байршуулав. Үүнд:<br>-Засгийн газрын 41 тогтоол;<br>-Засгийн газрын хуралдааны 48 тэмдэглэл;<br>- Ерөнхий сайдын 12 захирамж байна.<br>2025 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар нийт 62 шийдвэрийг Засгийн газрын хуралдааны цахим системээс ГБХНХЯ-ны ABLE цахим системд яамны нийт албан | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хаагчдад харагдах байдлаар байршуулав. Үүнд:<br>-Засгийн газрын 17 тогтоол;<br>-Засгийн газрын хуралдааны 36 тэмдэглэл;<br>- Ерөнхий сайдын 4 захирамж,<br>-Монгол Улсын Ерөнхий сайдын албан даалгавар-5 байна. | |
| | | | Тайлан /тоо/ | 0 | 4 | Тайлан 2:<br>-Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг жагсаалтын дагуу 240 заалтын хэрэгжилтийг нэгтгэн боловсруулж, 2025 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр СХШҮДАГ-т цахим хэлбэрээр хүргүүлсэн. Түүнчлэн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хүрээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Улсын Их Хурлын тогтоол, Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэр, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, хуралдааны тэмдэглэл болон албан даалгаврын хэрэгжилт, биелэлтэд судалгаа хийх үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн А/268 дугаар тушаалаар байгуулсан. Тус ажлын хэсгийн дүгнэлт, шийдвэрийн дагуу Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн судалгаа, саналыг боловсруулан Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн 01/3558 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.<br>-Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг ЗГХЭГ-с ирүүлсэн 2025 оны жилийн эцсийн жагсаалтын дагуу **638** заалтын хэрэгжилтийг нэгтгэн боловсруулж, хуулийн хугацаанд багтаан СХШҮДАГ-т хүргүүлсэн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 62. | 4.1.7.Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хэмжээнд Төрийн албаны салбар зөвлөлийн чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллана. | -Салбарын хүний нөөцийн туршлага солилцох өдөрлөг-7,0 сая төгрөг;<br>-Яамны сул орон тоог нөхөх тусгай шалгалт зохион байгуулах зардал-5,0 сая төгрөг+техник, тоног төхөөрөмж 25,0 сая төгрөг;<br>-ТАХ-ийн Үндэсний чуулган зохион байгуулах зардал-50,0 сая төгрөг; | Төрийн албаны салбар зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө /тоо/ | 1 | 1 | Төлөвлөгөө 1:<br>Төрийн албаны зөвлөлийн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны дэргэдэх салбар зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хуралдаанд танилцуулж, 23 дугаар тогтоолоор батлуулан хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна. | 100 |
| | | | Хэрэгжилтийн тайлан /тоо/ | 2 | 2 | Дээрх төлөвлөгөөний дагуу Салбар зөвлөлийн хуралдааны бэлтгэлийг хангаж, хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг тухай бүр боловсруулан хуралдааныг дэгийн дагуу хуралдуулан, хурлаас гарсан шийдвэрийг 3 хоногийн дотор эцэслэн албажуулан ажиллалаа. Энэ оны хагас жилийн байдлаар Салбар зөвлөлийн хурлыг 4 удаа хуралдуулж дараах асуудлуудыг хэлэлцүүлж шийдвэр гаргуулсан байна. Үүнд:Төрийн албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалын сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалт зохион байгуулах ажлын хэсэг томилох тухай, Харьяа байгууллагуудын зарим удирдах болон гүйцэтгэх албан тушаалын сул орон тоог нөхөх тусгай шалгалтын тайлан, Албан тушаалд нэр дэвшүүлж, санал болгох тухай, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон харьяа байгууллагуудын төрийн захиргааны албан хаагчдад албан тушаалын зэрэг дэв шинээр болон ахиулан олгох санал гаргах тухай, Төрийн албаны тэргүүний ажилтан шагналд уламжлах тухай зэрэг асуудлыг хэлэлцэн, хэлэлцсэн асуудлаар 65 тогтоол гаргасан байна.<br>Төрийн албаны хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, төрийн албаны шинэтгэл болон сайн засаглалын зарчмыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд орон нутгийн сумдын төрийн албан хаагчдад сургалт, мэдээлэл өгөх, соён | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | гэгээрүүлэх, хяналт шалгалт хийх, мэргэшил арга зүйн зөвлөгөө өгөх, зөвлөн туслах ажлаар орон нутагт Төрийн албаны зөвлөлийн ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллах Хөдөлмөрийн бодлогын газрын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж хариуцсан ахлах шинжээч П.Хишигжаргал, Салбарын хяналтын газрын Хөдөлмөрийн хяналтын бодлого төлөвлөлт, зохицуулалт хариуцсан ахлах мэргэжилтэн М.Ууганбаатар, хөдөлмөрийн бодлогын газрын Хөдөлмөрийн харилцаа, цалин хөлсний хэлтсийн шинжээч О.Мягмарсүрэн нарыг оролцуулав. | |
| 63. | 4.1.8.Яамны хүний нөөцийг чадавхижуулах, 2025 оны сургалтын төлөвлөгөөг Төрийн нарийн бичгийн даргаар батлуулж, хэрэгжүүлнэ. | Улсын төсөв | Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар баталсан төлөвлөгөө /тоо/ | 0 | 1 | Төлөвлөгөө 1:<br>Яамны албан хаагчдыг чадавхижуулах 2025 оны сургалтын төлөвлөгөөг боловсруулж, Төрийн нарийн бичгийн даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | 100 |
| | | | Хагас, бүтэн жилээр гаргах тайлан /тоо/ | 0 | 2 | Яамны албан хаагчдыг чадавхижуулах 2025 оны сургалтын төлөвлөгөөний дагуу эхний хагас жилийн байдлаар Удирдлагын академийн багц сургалтад 5 албан хаагч, худалдан авах ажилллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх сургалтыг 2025 оны 1 дүгээр сарын 3-4-ний өдрүүдэд 25 албан хаагчийг хамруулан зохион байгуулсан.<br>-Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын Хүний нөөцийн албан хаагчдад Төрийн албаны хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо цахим системийн шинэ модуль, дэд системүүдийг танилцуулах, түүнийг хэрэглээнд нэвтрүүлэх, систем хэрэглэгчдийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалтыг Төрийн албаны зөвлөлтэй хамтран зохион байгуулж, Захиргааны нэгжийн дарга | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нар, Хүний нөөцийн албан хаагчид 78 ажилтан; цахимаар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын орон нутаг дахь байгууллагуудын Газрын дарга, Захиргааны нэгжийн дарга, Хүний нөөцийн албан хаагчид 202, нийт 280 орчим албан хаагч оролцсон.<br>-БНХАУ-ын их дээд сургуульд суралцах магистр, докторын сургалтад яам, харъяа агентлагын албан хаагчдаас нэрсийг авч ЗГХЭГ-т хүргүүлсэн. -Түүнчлэн БНХАУ-ын Засгийн газрын дэмжлэгээр зохион байгуулагдсан хүний хөгжлийн 21 хоногийн сургалтад ТЗУГ-ын ахлах шинжээч Д.Энхзаяа, НБТГ-ын ахлах шинжээч Б.Энхтуул нар хамрагдсан.<br>-Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Засгийн газар, Гадаад хэргийн яамны харьяа Энэтхэгийн Техник, эдийн засгийн хамтын ажиллагааны схемийн хөтөлбөрийн хүрээнд тус яамны СХГ-ын шинжээч А.Урангуа, ГББГ-ын шинжээч Л.Дуламсүрэн нар Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Нью-Дели хотноо 2025 оны 03 дугаар сарын 25-наас 04 дүгээр сарын 24-ний хооронд зохион байгуулагдсан "36th International Trianing Programme in Legislative Drafting" сургалтад хамрагдсан.<br>-Яамны албан хаагчдыг чадавхижуулах, байгууллагын соёлыг төлөвшүүлэх, бэхжүүлэхээр Team consaltancy ХХК-ын Ц.Онон багш “Байгууллагын соёл” сэдвээр 3 акк. цагийн мэдээлэл өгч, нийт 120 албан хаагч хамрагдсан.<br>-Хөвсгөл, Орхон, Булган, Дундговь, Өмнөговь, Дорноговь, Говьсүмбэр аймгуудын Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар, Нийгмийн даатгалын хэлтэс, аймгийн хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн албан хаагчдад салбарын бодлого, эрх зүйн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шинэчлэл, салбар дундын уялдааг хангах чиглэлээр сургалт, зөвлөгөөн зохион байгуулж 272 албан хаагчид хамрагдсан.<br>Хөвсгөл аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн албан хаагчдыг чадавхжуулах сургалт Хөвсгөл, Дундговь аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн албан хаагчдыг чадавхжуулах сургалтыг зохион байгуулж, төвийн нийт 57 албан хаагчид хамрагдсан.<br>Тус сургалтын зорилго нь орон нутаг дах харьяа төвүүдийн ажилтан, албан хаагчдыг чадавхжуулах, хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт хандлагыг нэмэгдүүлэх, салбарын хууль тогтоомжийн хэрэгжилт, тулгамдаж буй асуудлын талаар санал солилцох, зөвлөлдөх, цаашид анхаарах асуудлаар мэргэжил арга зүйн удирдлагаар хангах зорилготой юм.<br>-Хөвсгөл, Дундговь аймгийн ажил олгогч нарт (Төр, ТББ, ААНБ) хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийн байдалд хийсэн хяналт шалгалт, ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа, ажлын байрны хүртээмжтэй орчинг бүрдүүлэх, дэд бүтэц, мэдээллийн хүртээмжийн тухай төр, ТББ, ААНБ-уудын хамтын ажиллагаа сэдвээр сургалт зохион байгуулж, нийт 168 хүн хамрагдсан.<br>-Монгол бичгийн компютерийн сургалтыг 05 дугаар сарын 13-ны өдрөөс 4 долоо хоногийн хугацаанд Мягмар, Пүрэв гаригт нийт албан хаагчдад зохион байгуулсан.<br>-Албан хэрэг хөтлөлтийн сургалтыг ахмад ажилтан Б.Аюуш “Албан бичгийн боловсруулалт, анхаарах асуудлууд” сэдвээр албан хаагчдад зохион байгуулсан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Зохион байгуулсан сургалт /тоо/ | 0 | Төлөвлөгөө-нд туссанаар | Энэ хүрээнд Удирдлагын академийн Төрийн албаны сургуульд албан хаагчийг ахлах болон эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад байгууллагын зардлаар болон улсын төсвийн санхүүжилтээр хамруулах хүсэлт хүргүүлснээс эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 3 албан хаагч, ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 1 албан хаагч, төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 1 албан хаагчийг хамруулан суралцуулахаар гэрээ байгуулан ажиллалаа. Мөн БНХАУ-ын их дээд сургуульд суралцах магистр, докторын сургалтад яам, харъяа агентлагын албан хаагчдаас нэрсийг авч ЗГХЭГ-т хүргүүлсэн.<br>КОЙКА олон улсын байгууллагаас зохион байгуулж буй “Өндөр настны тогтвортой орлогыг дэмжих тогтолцооны менежментийн чадавхыг бэхжүүлэх 2023-2025” сургалтад 5 албан хаагчийн нэрсийг Сангийн яаманд хүргүүлсэн. | |
| | | | Сургалтад хамрагдсан албан хаагчийн эзлэх хувь | 0 | 100% | Нийт сургалтад хамрагдах ёстой албан хаагчдын 90 хувь хамрагдсан. Албан томилолт болон ажлын заалшгүй шаардлагаар 10 хувь нь хамрагдаагүй. | |
| 64. | 4.1.9.ГБХНХЯ-ны албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах дунд хугацаа (2022-2025 он)-ны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, (2026-2029 он)-ы хөтөлбөрийг боловсруулж Төрийн | 650,0 сая төгрөг | 2022-2025 оны хөтөлбөрийн хэрэгжилт /хувь/ | 0 | 80% | -Тайлант хугацаанд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны А/235 дугаар тушаалаар баталсан “Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр”-ийн хүрээнд ар гэрийн гачигдал гарсан, эрүүл мэндийн шалтгааны улмаас удаан хугацаагаар эмчлүүлэх шаардлагатай болсон, гэрлэлтээ батлуулж шинэ байранд орсон зэрэг асуудлаар хүсэлт гаргасан **25** албан хаагчид буцалтгүй тусламж үзүүлж, **37** албан хаагчид | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | нарийн бичгийн даргаар батлуулна. | | | | | байгууллагын дотоод журамд заасны дагуу хүндэтгэн үзэх шалтгааны дагуу цалинтай чөлөө олгох асуудлыг холбогдох удирдлагуудад танилцуулан, тэтгэмж, тусламж үзүүлэх тушаалын төсөл боловсруулж албажуулан Санхүүд хүргүүлэн ажиллалаа. | |
| | | | Тухайн жилдээ Нийгмийн баталгааны хөтөлбөрт хамрагдсан албан хаагчдын хувь | 0 | 100 хувь | Тайлант хугацаанд албан хаагчдын 29%-д нийгмийн баталгааны хөтөлбөрийн дагуу тэтгэмж, тусламж үзүүлсэн байна. | |
| | | | Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар баталсан хөтөлбөр /тоо/ | 0 | 1 | ГБХНХЯ-ны албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах дунд хугацааны хөтөлбөрийн хэрэгжилтийн хугацаа 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болох бөгөөд дараагийн дунд хугацааны хөтөлбөр батлагдах хугацаа болоогүй байна. | |
| 65. | 4.1.10. ГБХНХ-ын сайдын 2025 оны тушаалын болон 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийн тайлан мэдээг сар бүр нэгтгэж, удирдлагуудад танилцуулна. | үйл ажиллагааны зардал | Сайдын 2025 оны тушаалын хэрэгжилтийн тайлан /тоо/ | 0 | 2 | Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны бодлого, үйл ажиллагааны хэрэгжилтийг хангаж ажиллах, эрчимжүүлэх тухай 01 албан даалгаврын албан даалгаврын биелэлтийг сар, улирлаар нэгтгэн Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газарт хүргүүлж байна.<br>Сайдын албан даалгаврын 90 заалтын хэрэгжилтийг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний байдлаар болон эхний хагас жилийн байдлаар нэгтгэн ХШҮДАГ-т хүргүүлсэн. Сайдын тушаалын биелэлтийг 2025 оны жилийн эцсийн байдлаар гарган нэгтгэн боловсруулж, СХШҮДАГ-т хүргүүлэхээр ажиллаж байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | -Тус яамны 9 газарт өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт /хувь/;<br><br>- Тайлан /тоо/ | 0<br><br>0 | Хэрэгжилт-ийн хувь /явцын гүйцэтгэл/;<br>4 | Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны бодлого, үйл ажиллагааны хэрэгжилтийг хангаж ажиллах, эрчимжүүлэх тухай 01 албан даалгаврын албан даалгаврын биелэлтийг сар, улирлаар нэгтгэн Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газарт хүргүүлж байна.<br><br>Сайдын албан даалгаврын 90 заалтын хэрэгжилтийг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний байдлаар болон эхний хагас жилийн байдлаар нэгтгэн ХШҮДАГ-т хүргүүлсэн. | |
| 66. | 4.1.11.Сайдын зөвлөлийн хуралдаан болон Төрийн нарийн бичгийн даргын шуурхай хуралдааныг товлосон хугацаанд зохион байгуулж, хурлаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг нэгтгэн удирдлагуудад танилцуулна. | үйл ажиллагааны зардал | Сайдын зөвлөлийн хуралдааны тэмдэглэл хөтөлсөн эсэх /тийм-1, үгүй-0/ | 1 | 1 | Сайдын шуурхай хуралдааныг 2025 оны 06, 08, 10 дугаар саруудад зохион байгуулж, салбарын хууль эрх зүйн шинэчлэлийн хүрээнд шинэчлэн найруулж буй болон нэмэлт өөрчлөлт оруулж буй хуулиудын явцтай танилцаж, холбогдох үүрэг даалгавар өгсөн.<br>Тус хуралдааны тэмдэглэлийг хөтөлж Төрийн нарийн бичгийн дарга болон ТЗУГ-ын даргад танилцуулсан. | 100 |
| | | | Сайдын зөвлөлийн хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын биелэлт /хувь/; | 90% | 100% | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын эрхлэх асуудлын хүрээнд сайдын шуурхай хуралдаан 2025 оны 06 дугаар сарын 23, 2025 оны 08 дугаар сарын 04, 2025 оны 10 дугаар сарын 29-ний өдрүүдэд тус тус хуралдсан. Хуралдаанд яамны газар, нэгжийн дарга нар болон харьяа агентлаг, байгууллагын удирдлагууд бүрэн бүрэлдэхүүнтэйгээр оролцсон бөгөөд салбарын эрхлэх асуудлын хүрээнд хуулийн төслүүдийн боловсруулалтын явц, үзэл баримтлал, тулгарч буй хүндрэл бэрхшээлийг авч хэлэлцэн, УИХ-д өргөн мэдүүлэх хууль эрх зүйн актуудын явц, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | цаашдын зохион байгуулалтын асуудлыг шийдвэрлэж ажиллах чиглэлийг хүргүүлэв.<br><br>Сайдын шуурхай хуралдаанаас өгсөн нийт 82 үүрэг даалгаврын хүрээнд биелэлтийг газар, хэлтсийн дарга нараас тухай бүр авч нэгтгэн удирдлагуудад танилцуулж ажилласан. Сайдын шуурхай хуралдааны үүрэг даалгаврын биелэлт 92 хувийн гүйцэтгэлтэй байна. | |
| | | | Төрийн нарийн бичгийн даргын шуурхай хуралдааны тэмдэглэл хөтөлсөн эсэх /тийм-1, үгүй-0/ | 1 | 1 | -Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын Төрийн нарийн бичгийн даргын шуурхай хуралдааныг Даваа гараг бүрийн 09:00 цагт зохион байгуулж, хуралдааны тэмдэглэлийг тухай бүр хөтлөн Төрийн нарийн бичгийн дарга болон ТЗУГ-ын даргад танилцуулан ажиллалаа.<br>-2025 оны хагас жилийн байдлаар нийт 17 удаагийн шуурхай хуралдааныг зохион байгуулж, 72 хуудас шуурхайн хуралдааны тэмдэглэлийг хөтлөн албажуулан удирдлагуудад танилцуулсан байна.<br>-Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын Төрийн нарийн бичгийн даргын шуурхай хуралдааныг Даваа гараг бүрийн 09:00 цагт зохион байгуулж, хуралдааны тэмдэглэлийг тухай бүр хөтлөн Төрийн нарийн бичгийн дарга болон ТЗУГ-ын даргад танилцуулан ажиллалаа.<br><br>-2025 оны жилийн эцсийн байдлаар нийт 42 удаагийн шуурхай хуралдааныг зохион байгуулж, 174 хуудас шуурхайн хуралдааны тэмдэглэлийг хөтлөн албажуулан удирдлагуудад танилцуулсан байна. | |
| | | | Төрийн нарийн бичгийн | 90% | 100% | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын эрхлэх асуудлын хүрээнд Төрийн нарийн бичгийн даргын шуурхай хуралдаан | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | даргын шуурхай хуралдаанаас өгсөн даалгаврын биелэлт /хувь/; | | | 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн долоо хоног бүр тогтмол зохион байгуулагдаж, нийт 24 удаа хуралдсан байна. Эдгээр хуралдаанаас нийт 240 үүрэг, даалгавар өгч, үүрэг даалгаврыг заалт бүрээр нь ангилан холбогдох газар, хэлтсүүдэд хүргүүлэн хэрэгжилтийн явцад тогтмол хяналт тавьж ажилласан.<br><br>Шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг, даалгаврын биелэлтийг нэгтгэн дүгнэхэд нийт гүйцэтгэл 95 хувьтай байна. Үүрэг, даалгаврын биелэлтийг өгсөн долоо хоногтоо багтаан нэгтгэн гаргаж, холбогдох газар, хэлтсийн дарга нарт хүргүүлэн хэрэгжилтийг хангуулж ажиллаж байна.<br><br>Мөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг тогтмол нэгтгэн дүгнэж, хэрэгжилтийн тайлан, мэдээллийг Төрийн захиргаа, удирдлагын газрын даргад танилцуулан, Төрийн нарийн бичгийн даргад тухай бүр хүргүүлэн ажилласан болно. | |
| 67. | 4.1.12.ГБХНХЯ-ны архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулна. | үйл ажиллагааны зардал | Баримт нягтлан шалгах комисс байгуулсан Төрийн нарийн бичгийн даргын тушаал /тоо/ | 0 | 1 | Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн А/55 дугаар тушаалаар Архив, албан хэрэг Гэр бүл, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны дэргэдэх БНШК-ын бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулсан. | 90 |
| | | | 2025 онд Хөтлөх хэргийн нэрийн | 0 | 1 | -ГБХНХЯамын 2025 оны Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг Төрийн нарийн бичгийн даргаар 2025 оны 2 дугаар сарын 24-ны өдөр | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | жагсаал баталсан Төрийн нарийн бичгийн даргын тушаал /тоо/ | | | батлуулсан шинэчлэн боловсруулж батлуулсан.<br>-2019 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу өнгөрсөн онуудад бүрдүүлсэн баримтыг бүрэн бүрдэлтэйгээр үдэж хавтаслах шаардлагатай задгай баримтыг стандартын дагуу үзэж хавтаслаж байнга, түр хадгалах данс, бүртгэлийн дагуу архивын баримтыг дараалалд оруулж байрлуулах, нүүр дардас дарж, дугаар бичих ажлыг шинэчлэн хийж байна. | |
| | | | 2024 онд хүлээн авсан баримт, хадгаламжийн нэгж /тоо/ | 0 | Гүйцэтгэл /тоо/ | 2025 оны байдлаар 2023-2024 оны 350 хадагаламжийн нэгж архивт хүлээж аваад байна. | |
| | | | Албан цахим баримт бичиг /тоо/; | 0 | Гүйцэтгэл /тоо/ | Төрийн байгууллагын албан бичиг солилцооны дундын системээр болон “Able” системийг хэрэглэж байгаа төрийн байгууллагуудтай цахим баримт бичиг солилцож байгаа бөгөөд 2025 оны 06 дугаар сарын 18-ны байдлаар төрийн байгууллагуудаас 3425 албан бичиг цахимаар хүлээн авч, ABLE системийг ашиглан нийт 2114 албан бичгийг илгээсэн байна.<br>Төрийн байгууллагын албан бичиг солилцооны дундын системээр болон “Able” системийг хэрэглэж байгаа төрийн байгууллагуудтай цахим баримт бичиг солилцож байгаа бөгөөд 2025 оны 12 дугаар сарын 05-ны байдлаар төрийн байгууллагуудаас 7100 албан бичиг цахимаар хүлээн авч, тус яам 2025 оны 12 дүгээр сарын 05-ны байдлаар ABLE системийг ашиглан нийт 4200 албан бичгийг илгээсэн байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 68. | 4.1.13.ГБХНХЯ-ны архив, албан хэрэг хөтлөлтийн 2025 онд улсын үзлэгт бэлтгэх төлөвлөгөөг батлуулан, хэрэгжилтийг хангаж ажиллана. | /архивын баримтыг нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой гарах зардал/ + Сургалтын зардал | Архив, албан хэргийн хөтлөлтийн тухай хуульд заасан улсын үзлэг явуулахад гарах зардлыг шийдвэрлэх тухай Сайдын тушаал /тоо/ | 0 | 1 | Архивын улсын үзлэгийн бэлтгэл ажил зохион байгуулах тухай 2025 оны 02 дугаар сарын 17-ний өдрийн А/44 тоот сайдын тушаал батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br><br>Газар хэлтэсүүдээс нийт 350 хадгаламж архивд хүлээн авч 301 хадгаламжийн нэгжийг үдэж, хавтаслан, дардас даран нүүр бичилт хийгдсэн.<br><br>Задгай байсан 2018-2023 оны ирсэн явсан бичиг ангилан ялгаж дугаарлалт хийгдсэн;<br><br>Өрнөх Бэйлийнхэн ХХК-тай гэрээ байгуулж, 2019-2020 оны баримтуудыг бүрэн хийж дуусгаагүй учир дутуу хийгдсэн ажлуудыг үргэлжлүүлэн хийж эмхлэн цэгцэлж, ангилан ялгалт хийгдэж байна.<br><br>**Байнга, түр, 70 жил бүртгэлтэй тулган хайрцаглан тавиурт байршуулсан байдал:**<br><br>- **Төрийн үйлчилгээ УҮГ**<br>Байнга 2006-2020 7хн, 70 жил 31хн;<br><br>- **Хүнс тэжээл НХНС төсөл**<br>Байнга 2016-2020 425хн, түр 171хн,<br><br>70 жил 16 хн<br><br>- **Жижиг дунд үйлдвэр**<br>Байнга 2009-2012 11хн, түр 51хн, 70 жил 15хн<br><br>- **Мэргэжил боловсрол сургалт**<br>Байнга 2009-2012 байнга 15хн, 70 жил 2хн<br>- **Нийгмийн хамгааллын СХХ**<br>Байнга 2011- 2011 72 хн, түр 15хн<br>- **Хөдөлмөр эрхлэх УД-лэх МОН3243 төсөл** | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Байнга 2015-2024 152хн, түр 292хн, 70 жил 7хн<br>- **Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл**<br>Байнга 54хн<br>- **Барилгын зураг төсөл**<br>Байнга 464 хн<br>- **Онцгой байдлын төсөл**<br>Байнга 85 хн<br>- **ХНХЯ хүүхэд үрчлэлт**<br>Байнга 291хн, 70 жил 420хн байршуулсан байна.<br>Хадгалах хугацаа дууссан баримтуудыг устгах жагсаалтад бүртгэж ялган, шуудайлж, устгахад бэлэн болгосон байна. | |
| | | | Архивын улсын үзлэгт бэлдэх ажлын хэсэг байгуулах, холбогдох зардлыг шийдвэрлэсэн Төрийн нарийн бичгийн даргын тушаал /тоо/ | 0 | 1 | Архивын улсын үзлэгийн бэлтгэл ажил зохион байгуулах тухай 2025 оны 02 дугаар сарын 17-ний өдрийн А/44 тоот Сайдын тушаал, Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн А/56 дугаар тушаалаар архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг угтаж, бэлтгэх ажлын төлөвлөгөө, ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг, ажлын төлөвлөгөөг, шаардагдах зардлыг батлуулан ажиллаж байна. Архивын баримтад эрдэм шинжилгээ техник боловсруулалтын ажил ,үйлчилээг үзүүлэх гэрээг Өрнөх Бэйлийхэн ХХК-тай байгуулан 17,252,000 төгрөг зарцуулсан | |
| | | | Архивын улсын үзлэг зохион байгуулах төлөвлөгөө /тоо/ | 0 | 1 | Архивын баримт бичгийг цэгцлэх ажил, үйлчилгээ үзүүлэх тухай П.Туултай хөлсөөр ажиллах гэрээг байгуулж, Гэрээгээр гүйцэтгэх ажил, үйлчилгээний нийт хөлс нь дараах байдлаар буюу архивын баримт гэрээгээр цэгцлэх үйлчилгээний ажлын хөлс 4 сарын хугацаанд 9,500,000 (есөн сая таван зуун мянга) төгрөг болсон. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Архивын улсын үзлэгт зохион байгуулах төлөвлөгөөний биелэлт /хувь/ | 0 | 100% | Архивын улсын үзлэгийн бэлтгэл ажил зохион байгуулах тухай 2025 оны 02 дугаар сарын 17-ний өдрийн А/44 тоот Сайдын тушаал, Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн А/56 дугаар тушаалаар архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг угтаж, бэлтгэх ажлын төлөвлөгөө, ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг гаргаж батлуулсан. Энэ хүрээнд:<br>- Өрнөх Бэйлийхэн ХХК-тай гэрээ байгуулж 2019 оноос хойшхи архивын баримт бичгүүдийг хууль тогтоомж, дүрэм журам, стандартын дагуу дахин боловсруулж, архивлах цэгцлэх ажлыг эхлүүлсэн.<br>- П.Туултай хөлсөөр ажиллах гэрээ байгуулж, Гэрээгээр гүйцэтгэх ажил, үйлчилгээний нийт хөлс нь дараах байдлаар буюу архивын баримт гэрээгээр цэгцлэх үйлчилгээний ажлын хөлс 4 сарын хугацаанд 9,500,000 ( есөн сая таван зуун мянга) төгрөг Тус компанийн сургагч багш нар “архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд шинээр дагаж буй хууль эрх зүйн баримт бичгүүдийн тухай, анхаарах асуудлууд”-ын хүрээнд яамны албан хаагчдад сургалтыг үе шаттай зохион байгуулж байна.<br>- Архивын цахим мэдээллийн сан үүсгэхэд шаардлагатай баримт бичгүүдийн боловсруулалтыг хийж, 2022-2023 оны Сайдын А .Б тушаалуудыг сканйнердаж бүртгэлжүүлэн бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.<br>- Төрийн албан хаагчийн able системд архивын нэгж, мэдээллийн санг үүсгэн туршиж, холбогдох хүмүүстэй хамтран хөгжүүлэлт хийх ажиллаж байна . | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - Төрийн албан хаагчийн эйбл системийн цахим архивд 2024-2025 оны сайдын тушаал, төрийн нарийн бичгийн нарийн тушаалыг эйбл системийн тушаал хэсгээс байршуулсан. 2024 оны нарийн бичгийн даргын тушаалыг сканнердаж оруулсан.<br>- 2025 оны 1-5 дугаар сарын байдлаар 2024 оны газар хэлтсүүдийн архивын 350 нэгж баритыг хүлээн авсан<br>2019-2020 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу өнгөрсөн онуудад бүрдүүлсэн баримтыг бүрэн бүрдэлтэйгээр үдэж хавтаслах шаардлагатай задгай баримтыг стандартын дагуу үзэж хавтаслаж байнга, түр хадгалах данс, бүртгэлийн дагуу архивын баримтыг дараалалд оруулж байрлуулах, нүүр дардас дарж, дугаар бичих ажлыг шинэчлэх хийж байна.<br><br>ГБХНХЯ-ны Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг жил бүр шинэчлэн боловсруулж батлуулсан.<br><br>Архивын баримтад нягтлан шалгалт, дахин боловсруулалтын ажлыг “Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль”, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны А/222 дугаар тушаалаар батлагдсан “Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам”, Үндэсний архивын газрын даргын 2007 оны 160 дугаар тушаалаар батлагдсан “Байгууллагын үйл ажиллагаанд үүссэн удирдлагын нийтлэг баримт бичгийн хадгалах хугацааны үлгэрчилсэн жагсаалт”-ыг тус тус мөрдлөг болгож, он цаг, зохион байгуулалтыг баримтлан, баримтын нэр төрлөөр ангилан төрөлжүүлсэн.<br><br>Байгууллагын үндсэн үйл ажиллагаанд хамаарах баримтуудыг байнга хадгалахаар, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | цаг үеийн шинж чанартай баримтуудыг түр хадгалахаар, хүний нөөцийн холбогдолтой баримтуудыг 70 жил хадгалахаар ялгаж, тухайн байгууллагад хадгалагдаж байсан баримтын хэмжээгээр бүрдүүлж, хадгалах хугацааг тогтоосны үндсэн дээр дараах (данс) бүртгэлийг үйлдсэн.<br>Үүнд:<br>**Байнга, түр, 70 жил бүртгэлтэй тулган хайрцаглан тавиурт байршуулсан байдал:**<br>- **Төрийн үйлчилгээ УҮГ**<br>Байнга 2006-2020 7хн, 70 жил 31хн;<br>- **Хүнс тэжээл НХНС төсөл**<br>Байнга 2016-2020 425хн, түр 171хн,<br>70 жил 16 хн<br>- **Жижиг дунд үйлдвэр**<br>- Байнга 2009-2012 11хн, түр 51хн, 70 жил 15хн<br>- **Мэргэжил боловсрол сургалт**<br>Байнга 2009-2012 байнга 15хн, 70 жил 2хн<br>- **Нийгмийн хамгааллын СХХ**<br>Байнга 2011- 2011 72 хн, түр 15хн<br>- **Хөдөлмөр эрхлэх УД-лэх МОН3243 төсөл**<br>Байнга 2015-2024 152хн, түр 292хн, 70 жил 7хн<br>- **Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл**<br>Байнга 54хн<br>- **Барилгын зураг төсөл**<br>Байнга 464 хн<br>- **Онцгой байдлын төсөл**<br>Байнга 85 хн<br>- **ХНХЯ хүүхэд үрчлэлт** | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Байнга 291хн, 70 жил 420хн байршуулсан байна.<br>**Нийт: Байнгын 1415 хн**<br>**Түр 491**<br>**70 жил -640** тус тус баримтыг хайрцаглан байршуулсан байна.<br>Устгах хэргийн жагсаалтад сургалтын чадавхжуулах төлөвлөгөө, тайлан, шалгараагүй тендерийн баримт болон холбогдох бусад баримтуудыг ялгаж, жагсаалт үйлдсэн болно. Хадгалах хугацаа дууссан баримтуудыг устгах жагсаалтад бүртгэж ялган, шуудайлж, устгахад бэлэн болгосон байна.<br>**Сургалт:**<br>2025 оны 10 дугаар сарын 14-ний өдөр “Шинээр томилогдсон албан хаагчдын дунд зохион байгуулсан сургалтад”<br>Архив, албан хэрэгт хөтлөлт, стандарт сэдвээр сургалт зохион байгуулсан болно. | |
| 69. | 4.1.14.Монгол хэлний тухай хуулинд 2025 оны 01 сарын 01-нээс эхлэн Төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага албан хэргээ крилл болон үндэсний хос бичгээр хөтлөн явуулахаар заасны дагуу ГБХНХЯ нь хос бичгийн ашиглалтыг сайжруулна. | Гэрээт ажилтаны жилийн цалин 24.0 сая төгрөг + Хөрвүүлэгч Програмын үнэ | Хос бичгээр явуулах албан бичгийн нийт албан бичигт эзлэх хувь | 0 | 20 хувь хүртэл | Монгол хэлний тухай хуулинд 2025 оны 01 сарын 01-с эхлэн Төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага албан хэргээ крилл болон үндэсний хос бичгээр хөтлөн явуулахаар заасны дагуу ГБХНХЯ 2025 оны 01 дүгээр сарын 01-с эхлэн хос бичгээр хөтлөх журмыг хэрэгжүүлж албан хэрэг хөтлөлтийн ABLE системийг ашиглан үндэсний хос бичгээр 2025 оны 12 дугаар сарын байдлаар нийт **3217** албан бичгийг илгээсэн байна. | 70 |
| 70. | 4.1.15.Байгууллагын ил тод байдлыг хангах, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай | Улсын төсөв | Вэб сайтад байршуулах цаг үе үйл явдлын мэдээ | 0 | 250 | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас зохион байгуулсан хурал, зөвлөгөөнийг баримтжуулж, фото зураг авч, текст мэдээ бэлтгэн яамны пэйж хуудас | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хамтран ажиллах, бодлого, үйл ажиллагаа, цаг үе, үйл явдлын мэдээ мэдээллийг шуурхай бэлтгэн түгээх, байгууллагын вэб сайт болон сошиал сувгуудыг хөтөлж, хөгжүүлнэ. | | мэдээлэл /тоо/; | | | байршуулсан болно. Мөн шаардлагатай үед видео бичлэг хийж, хэвлэл мэдээллийн байгууллагаар түгээх ажлыг хийж байна. Энэ оны эхний хагас жилийн байдлаар нийт 97 мэдээ бэлтгэн нийтэлсэн. | |
| | | | Фейсбүүк пэйжийн дагагчдын тооны нэмэгдүүлэлт /тоо/; | 119,000 | 132.000 | Гүйцэтгэлийн түвшин 2025 онд давж биелсэн буюу Фейсбүүк пэйжийн дагагчдын тоо 132 000 болж нэмэгдсэн. Контентын хүртээмжтэй байдал, пэйж хуудсны хандалтын тоо тогтмол өссөн үзүүлэлттэй байна. | |
| | | | Мэдээллийн хүртээмжтэй байдлыг дээшлүүлэхэд чиглэсэн постер, видео, рийль, стори г.м бүтээсэн контент олон төрөл эсэх | 0 | 1 | Постер, видео, рийль, стори, текст мэдээ, шууд дамжуулалт /лайв/ гэсэн 6 төрлөөр мэдээллийг шуурхай, хүрээмжтэй, ил тод, нээлттэй хүргэж ажиллав. Пэйж хуудаст гэхэд өдөрт дунджаар 5 мэдээ /пост/ оруулж ажиллав.<br><br>1/ Ахмад настны тухай хуульд заасны дагуу “Ахмад настны бие бялдар, танин мэдэхүй, сэтгэл зүйн үйл ажиллагааны хэрэгцээ, түвшинг үнэлж цогц тусламж үйлчилгээ үзүүлдэг болно” сэдвийн хүрээнд видео бичлэг бэлтгэсэн.<br><br>2/ Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөрт зориулж, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны ажилтан, албан хаагчдын хүүхдүүдийн видео мэндчилгээ бэлтгэсэн.<br><br>3/ Нийгмийн халамжийн багц хуулийн төслийг шинэчлэн боловсруулж байгаатай холбогдуулан “Монгол Улсын нийгмийн хамгааллын тогтолцоо, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицоход бэлэн үү” сэдвийн хүрээнд видео бичлэг бэлтгэсэн.<br><br>4/ 2025 оны 5 дугаар сарын Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын ажилтны өдрийн хүрээнд зохион байгуулсан нээлттэй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хаалганы өдөрлөгөөр ХХҮЕГ, НДЕГ, ХГБХХЕГ-ын газрын үйл ажиллагааг сурталчилсан 4 видео бичлэг бэлтгэсэн. | |
| 71. | 4.1.16.Монгол Улсад Хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага байгуулагдсаны 65 жилийн ойн арга хэмжээний хүрээнд “Түүхэн замнал, гэрэл зургийн архив” ном бэлтгэн, хэвлүүлнэ. | Улсын төсөв | Бэлтгэсэн “Түүхэн замнал, гэрэл зургийн архив” номын эх /тоо/ | 0 | 1 | “Түүхэн замнал, гэрэл зургийн архив” ном бүтээх зорилгоор Төрийн нарийн бичгийн дарга холбогдох газрын зарим албан хаагчдад үүрэг даалгавар өгөн, мэдээлэл цуглуулах ажил хийгдэж байна.<br>Төсвийн нөхцөл байдал, удирдлагын заалтаар хэрэгжээгүй | 30 |
| | | | Хэвлүүлсэн ном /тоо/; | 0 | 600 | Гэр бүл хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны танилцуулга /ном/ хэвлүүлсэн. | |
| 4.2.2. | Зорилт 6: Хууль тогтоомжийн үзэл баримтлал, төсөл боловсруулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх; | Улсын төсөв | Арга хэмжээ /тоо/ | 0 | 10 | I-IV улирал | |
| 72. | 4.2.2.1. Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхийг түшиц шүүх болгож, гэр бүлийн хэрэг шийдвэрлэх ажиллагааны явцад гэрлэгчдэд авсан эвлэрүүлэх ажиллагааны үр дүнг нэмэгдүүлэх зорилгоор шүүх дэх эвлэрүүлэн зуучлагчтай хамтран сэтгэл зүйчийг ажиллуулж, эвлэрсэн | Сэтгэл зүйчийн цалин хөлс | Нийт гэрлэлт цуцлалтаас эвлэрүүлэн зуучлах ажиллагааны явцад эвлэрсэн гэр бүлийн эзлэх хувь | 0 | 10 хувь | Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхэд 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн сэтгэл зүйч ажиллаж эхэлснээс хойш шүүх дэх Эвлэрүүлэн зуучлалд нийт 405 өргөдөл ирсний 148 хос, тэдний 3 хүүхэд сэтгэл зүйчийн зөвлөгөө авч, үүний үр дүнд 24 хос эвлэрч, 29 хос гэрлэлт цуцлуулах өргөдлөөсөө татгалзаж, хамтын амьдралаа үргэлжлүүлэхээр болсон байна. Сэтгэл зүйч, эвлэрүүлэн зуучлалтай хамтран ажилласнаар гэрлэлтээ цуцлуулаагүй эвлэрсэн гэр бүлийн эзлэх хувь 13,08%-иар өссөн үзүүлэлттэй байна. | 70 |
| | | | Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн | 1220 | 1240 | Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхээс 2022 онд 115, 2023 онд 128, 2024 онд 117, 2025 онд | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | гэр бүлийн тоог нэмэгдүүлнэ. | | Иргэний хэргийн анхан шатны шүүхийн сүүлийн 3 жилийн хугацаанд эвлэрүүлэн зуучлагчид шилжүүлсэн хэргийн дундаж тоо | | | 81 нийт 441 хэргийг эвлэрүүлэн зуучлагчид шилжүүлсэн.<br><br>Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхэд 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн сэтгэл зүйч ажиллаж эхэлснээс хойш шүүхээс иргэний хэрэг үүсгэсний дараа 21 хэргийг эвлэрүүлэн зуучлагчид шилжүүлсэний 3 хос нь эвлэрч, 10 хос эвлэрэхээс татгалзаж, 8 хос нь эвлэрэх хугацаа авсан байна.<br><br>Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүх дэх эвлэрүүлэн зуучлахад 2025 онд 1530 өргөдөл ирсэн ба гэрлэгчдэд авсан эвлэрүүлэх ажиллагааны үр дүнд 224 хос эвлэрч, сүүлийн 3 жилийн хугацаанд 1220 хос эвлэрсэн байсныг 1444 болгон нэмэгдүүлж, 18%-иар өсгөсөн үзүүлэлттэй байна. | |
| 73. | 4.2.2.2. Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхийг түшиц шүүх болгож, гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүүхдийн асрамжийг тогтоолгохоор шинжээчийг шүүхийн тамгын газартай хамтран ажиллуулснаар гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх дундаж хугацааг багасгана. | Шинжээчийн цалин хөлс | Сүүлийн 5 жилийн гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэсэн дундаж хугацаа /хоногоор/ | 360 | 300 | 2025 оны 05 дугаар сарын 01-ны өдөр Шүүхийн ерөнхий зөвлөлтэй “Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд сэтгэл зүйч, шинжээчийн дэмжлэг үзүүлэх тухай санамж бичиг” байгуулсан Энэхүү санамж бичгийн хүрээнд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Иргэний анхан шатны тойргийн шүүхийн Тамгын газарт мэргэжлийн 2 сэтгэл зүйч ажиллаж, нийт 151 удаагийн сэтгэл зүйн зөвлөгөө өгснөөс гэрлэгчдэд ганцаарчилсан зөвөлгөө 25, хосын зөвөлгөө 123, хүүхдийн сэтгэл зүйн зөвлөгөө 3 өгөх үйлчилгээ, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд байгаа гэрлэлтийн маргаантай холбоотойгоор насанд хүрээгүй 10 хүүхдийн санал авах үйл ажиллагаанд шүүгч болон шүүхийн захиргааны ажилтантай хамтран оролцсон ба нийт 121 иргэний хэрэгт хүүхдийн | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | асрамж тогтоолгохоор шинжээч томилсон захирамж гарч шинжээчид хүргүүлснээс шинжээчийн дүгнэлт ирсэн 52, дүгнэлт ирүүлээгүй 58, хүсэлт гаргагч хүсэлтээсээ татгалзсан 12 байна.<br><br>Шинжээч нар шүүгчийн захирамжид заасны дагуу хүүхдийн асрамж тогтоох асуудлаар шинжээчийн дүгнэлтийг 1-8 сарын хугацаанд буюу 30-240 хоногийн хугацаанд гарган ажилласан байна.<br><br>Дээрх 121 иргэний хэргийн 39 нь эцэслэн шийдвэрлэгдсэн, 1 нэхэмжлэлийг буцаасан бөгөөд гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх дундаж хугацаа 60-280 хоног байна.. | |
| 74. | 4.2.2.3. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь хүүхэд хамгааллыг сайжруулна.<br><br>4.2.2.3.1. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь хүүхэд хамгааллын журмыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд, Улсын ерөнхий прокурор, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга хамтран батална. | мэргэжилтэн бэлтгэх Хөрөнгийн эх үүсвэр, хэмжээ | 74.1.1.Батлагдсан журам /тоо/ | 0 | 1 | Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/85 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг Хүүхэд хамгааллын тухай хуулийн 29.6-д заасны дагуу “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь хүүхэд хамгааллын журам”-ын төсөл боловсруулахаар ажиллаж байна. | 50 |
| | | | 74.1.2.Бэлтгэгдсэн мэргэжилтэн /тоо/ | 0 | 10 | -Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/85 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг 2025 оны ажлын хэсгийн хурлыг 04 дүгээр сарын 03-ны өдөр, 06 дугаар сарын 27-ны өдөр, 12 дугаар сарын 08-ны өдөр тус тус хуралдаж, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 29.6-д заасны дагуу “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь хүүхэд хамгааллын журам”-ын төсөл боловсруулахаар ажиллаж байна.<br><br>-Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар болон түүний харьяа 21 аймаг, 9 дүүргийн хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдсөн хэрэг, маргаанд шинжээчийн дүгнэлт гаргах мэргэжилтнийг бэлтгэх, сургах, гэрчилгээжүүлэх ажлыг Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн академитай | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 4.2.2.3.2.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдсөн хэрэг, маргаанд шинжээчийн дүгнэлт гаргах мэргэжилтнийг бэлтгэх, сургах, гэрчилгээжүүлэх ажлыг Шүүхийн ерөнхий зөвлөлтэй хамтран зохион байгуулна.<br><br>4.2.2.3.3.Хууль зүйн хорооны шийдвэр, үзүүлсэн үйлчилгээний мэдээллийн сантай танилцан, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавина. | | | | | хамтран 2025 оны есдүгээр сарын 29-30-ны өдрүүдэд танхим болон цахим хосолсон байдлаар зохион байгуулж, нийт 120 мэргэжилтнийг бэлтгэн, гэрчилгээжүүлсэн. | |
| | | | 74.1.3 Арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавьсан талаарх тайлан /тоо/ | 0 | 1 | -Өмнөговь, Сүхбаатар, Архангай, Ховд, Хөвсгөл, Орхон аймгийн Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны 82 гишүүнд Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчлэл, Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүүхэд, хамгаалал, хууль ёсны төлөөлөгчийн ажиллах чиглэл, Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр чадавхжуулах сургалт хийж, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газарт Хууль зүйн хорооны шийдвэр, үзүүлсэн үйлчилгээний мэдээллийн санг бүрдүүлэх талаар мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажилласан. | |
| 75. | 4.2.2.4. Салбарын хяналтын газартай хамтран, Эрүүгийн хэрэгт хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч шинжээчээр ажиллаж, шинжээчийн дүгнэлт гаргаж байгаа асуудал Шүүхийн шинжилгээний тухай хуульд нийцэж буй эсэхэд дүн шинжилгээ хийж, шинжээчийн дүгнэлтийг хуульд нийцүүлэн гаргана. | үйл ажиллагааны зардал | Шинээр, тухайн жилд шаардлага хангасан дүгнэлтийн нийт шаардлагад эзлэх хувь | 0 | 10 хувь | Монгол Улсын Ерөнхий прокурорын газартай хамтран холбогдох судалгааг 2025 оны 09 дүгээр сард хийхэд 2024 онд 112, 2025 оны 09 дүгээр сарын байдлаар 61 эрүүгийн хэрэгт хөдөлмөр, хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч Шүүх шинжилгээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.3-т заасны дагуу шинжээчээр ажилласан байна.Дээрх шинжээчийн дүгнэлтүүд нь Шүүх шинжилгээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт тус тус заасантай нийцэж, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны А/233 дугаар тушаалаар баталсан “Шинжилгээ хийх эрх бүхий бусад этгээдээр хийлгэж болох шинжилгээний жагсаалт”-д | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | багтсан шинжилгээ тул 2025 онд хийгдсэн дээрх шинжээчийн дүгнэлтүүд нь хуульд нийцэн гарсан байна. | |
| 76. | 4.2.2.5. Нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөрийг 10 хувиар бууруулна. | үйл ажиллагааны зардал | Нийт өр төлбөрт эзлэх төлөгдсөн шимтгэлийн өрийн хувь | 0 | 10 хувь | 2025 оны эхний үлдэгдэл 520.1 тэрбум төгрөгийн шимтгэлийн авлагаас 263.7 тэрбум төгрөгийн авлагыг 60.2 хувиар буурсан байна.<br><br>Нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй ажил олгогчийн авлагыг бууруулах талаар дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд:<br><br>Нийгмийн даатгалын ерөнхий газрын Захиргаа удирдлагын газрын Хуулийн хэлтэст шимтгэлийн өр төлбөрийг барагдуулах ажлын хүрээнд шүүхэд нэхэмжлэл хүсэлт гаргах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох талаар зөвөлгөө өгч ажилласан.<br><br>-Хан-Уул дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн нэхэмжлэлтэй, Бүрдэл Майнинг ХХК-д холбогдох нийгмийн даатгалын шимтгэлийн өр, алдангид 26.212.922.133,84 (хорин зургаан тэрбум хоёр зуун арван хоёр сая есөн зуун хорин хоёр мянга нэг зуун гучин гурван) төгрөг гаргуулах тухай иргэний хэрэгт Улсын Дээд шүүхэд гаргах хяналтын гомдлын төслийг боловсруулж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох талаар мэргэжил арга зүйн зөвөлгөө өгч ажилласан.<br><br>-Нийгмийн даатгалын ерөнхий газрын Захиргаа удирдлагын газрын Хуулийн хэлтэс, Нийслэлийн Прокурорын газартай хамтран шимтгэлийн өр төлбөрийг барагдуулах ажлын хүрээнд шүүхэд нэхэмжлэл хүсэлт гаргах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох талаар сургалт зохион байгуулахаар холбогдох албан тушаалтануудтай уулзалт зохион байгуулсан. Түүнчлэн Нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөрийг шуурхай | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | барагдуулах хүрээнд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 01/1822 дугаар албан бичгээр аймаг, дүүргийн засаг дарга нарт харьяа аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газартай хамтран ажиллах талаар чиглэл хүргүүлсэн. Мөн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын төсвийн ерөнхийлөн захирагч болон аймгийн засаг даргын хооронд хөтөлбөрийн хэрэгжүүлэлт, санхүүжилтийн талаар байгуулах гэрээнд нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй төсөвт байгууллагын өрийг барагдуулах талаар зорилт арга хэмжээг тусган ажиллаж байна. Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд 2025 оныг “Даатгуулагчдыг дэмжих, нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг барагдуулах жил” болгон зарлан ажиллаж байна. Үүний үр дүнд 2025 оны эхний үлдэгдэл 520.1 тэрбум төгрөгийн шимтгэлийн авлагаас 262.9 тэрбум төгрөг төлөгдөж, 50.5 хувиар буурсан.<br>2025 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн байдлаар 2025 онд 405.8 тэрбум төгрөгийн шимтгэлийн өр шинээр үүссэн байна.<br><br>“Итгэлцлийн аян”-ыг 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдрөөс 10 дугаар сарын 15-ны өдрийг дуустал 1 сарын хугацаатай зохион байгууллаа. Аяны хугацаанд нийтдээ 105.8 тэрбум төгрөгийн шимтгэлийн өрийг барагдуулснаас 5808 аж ахуй нэгж, байгууллагын 63.8 тэрбум төгрөгийн хуримтлагдсан өр барагдсан. | |
| 77. | 4.2.6.6. Сайд, Төрийн нарийн бичгийн даргын гаргаж буй | | Тухайн жилд шаардлага хангаж, эрх | 0 | 100 хувь | -Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын А тушаал 228, Б тушаал 37 нийт 265 тушаалын төсөл болон Төрийн нарийн бичгийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | захиргааны акт, хэм хэмжээний акт, шийдвэр, гэрээ, хэлэлцээрийн төслийн хууль зүйн үндэслэлийг хянах, бусад яам, газруудаас боловсруулсан хууль, Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол, шийдвэр, гэрээ, хэлэлцээр болон бусад шийдвэрийн төсөлд салбарын бодлого, хууль тогтоомжид нийцүүлэн санал боловсруулна. | үйл ажиллагааны зардал | бүхий байгууллагад бүртгэгдсэн захиргааны акт, захиргааны хэм хэмжээний актын нийт актад эзлэх хувь | | | даргын А тушаал 309, Б тушаал 310 нийт 619 тушаалын төслийн хууль зүйн үндэслэлийг хянаж ажилласан.<br>-Яамны удирдлагаас эрх зүйн зөрчилтэй шийдвэр гараагүй.<br>-Яамнаас бусад байгууллага, хуулийн этгээдтэй байгуулсан 173 гэрээг хянаж, бүртгэж ажилласан.<br>-Бусад яам, газруудаас боловсруулсан хууль, Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол, шийдвэр, гэрээ, хэлэлцээр болон бусад шийдвэрийн 583 төсөлд салбарын бодлого, хууль тогтоомжид нийцүүлэн санал боловсруулж, хариуг хүргүүлсэн. | |
| 78. | 4.2.6.7.Тус яамтай холбогдолтой эрүү, иргэн, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож, харьяа агентлаг, газруудад хууль, эрх зүйн зөвлөгөө өгч ажиллана. | үйл ажиллагааны зардал | Тухайн жилдээ амжилттай шийдвэрлэгдсэн хэрэг, маргааны нийт шүүхээр шийдвэрлэсэн хэрэг маргаанд эзлэх хувь | 0 | 50 хувь хүртэл | Сайдын эрхлэх асуудлын хүрээний асуудлаар эрх зүйн дэмжлэг үзүүлэн ажилласан.<br>-2025 оны байдлаар иргэний хэргийн маргаан-3, захиргааны маргаан-3, эрүүгийн 1 хэрэг, нийт 7 маргаанд яамны итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдон ажилласанаас 5 хэрэг маргааныг амжилттай шийдвэрлэсэн нь тайлант хугацаанд шүүхээр шийдвэрлэсэн хэрэг маргааны 71,4 хувийг эзлэж байна.<br>Үүнд:<br>1.З.Мөнхзулын нэхэмжлэлтэй, ГБХНХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргад холбогдох иргэний хэрэгт нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагыг шүүхэс хангаж шийдвэрлэсэн.<br>2.Б.Болорын нэхэмжлэлтэй, ГБХНХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргад холбогдох захиргааны хэрэг дээр нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзаж, хэрэг хэрэгсэхгүй болсон.<br>3.Н.Өнөржаргалын нэхэмжлэлтэй, Монгол Улсын Засгийн газар, Гэр бүл, хөдөлмөр, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нийгмийн хамгааллын яам хариуцагчтай, “Итгэлцүүр тогтоох тухай” Засгийн газрын тогтоолыг илт хууль бус болохыг тогтоолгох тухай захиргааны хэргийн шүүх хуралдаанд оролцож, шүүхээс нэхэмжлэгчийн нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.<br><br>4.Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн иргэнийн хэргийн анхан шатны тойргийн шүүхэд Хөх тавилан ХХК-ийн нэхэмжлэлтэй, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд 115.684.418 (нэг зуун арван таван сая зургаан зуун наян дөрвөн мянга дөрвөн зуун арван найм) төгрөг гаргуулах тухай иргэний хэрэгт итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож, шүүхээс нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.<br><br>4.С.Асланбекийн нэхэмжлэлтэй, Монгол Улсын Засгийн газар, Нийгмийн даатгалын ерөнхий газарт тус тус холбогдох захиргааны хэрэгт хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож, шүүхээс нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.<br><br>5.У.Баасансүрэнгийн 2024 оны 09 дугаар сарын 17-ны өдөр тус шүүхэд хандаж гаргасан “Япон Улс дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн гэрээ хэлэлцээр тэдгээрийн хэрэгжилт, зохион байгуулалт болон адар тутмын үйл ажиллагаа хариуцсан мэргэжилтний ажлын байран эргүүлэн тогтоолгох, ажилгүй байсан хугацааны цалин хөлсийг гаргуулах, нийгмийн даатгал болон эрүүл мэндийн шимтгэлийг нөхөн төлүүлж нөхөн бичилт хийлгэх” тухай иргэний хэрэгт хариуцагчийн итгэмжлэгдсэн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төлөөлөгчөөр оролцож, шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байна.<br>6.Яллагдагч Ж.Хатанбаатар нарын 8 яллагдагчид холбогдох эрүүгийн 2501000170222 дугаартай хэрэгт хохирогчийн хууль ёсны төлөөлөгчөөр оролцож, нийт 33 хавтас хэргийн материалтай танилцсан бөгөөд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байна. | |
| 79. | 4.2.6.8. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, зөрчил гаргасан эсэхийг хянан шалгаж, дүгнэлт гаргах, харьяалах байгууллагын томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн зөрчлийг шалгаж шийдвэрлэнэ. | Соён гэгээрүүлэх, сургалт, гишүүдийн урамшуулал 12.0 сая төгрөг | Сургалт, нөлөөллийн ажил, ёс зүйн зөрчил, дүгнэлтийн тоо | Сургалт, нөлөөллийн ажил, ёс зүйн дэд хорооны дүгнэлт | ГБХНХЯ-ны албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулагдаж, зөрчлийн тоо буурсан байна. | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Ёс зүйн дэд хороог яамны нийт албан хаагчдын санал асуулгын үр дүнд 7 гишүүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулж, Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн А/106 дугаар тушаалаар албажуулж, үйл ажиллагаа явуулж байна. Тус дэд хорооны 1 гишүүн өөр байгууллагад шилжин ажиллахаар болсон тул нөхөн сонгуулийг бүх албан хаагчдын дунд дахин явуулж хамгийн олон санал авсан нэр дэвшигчийг ТНБД-ын 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн А/302 дугаар тушаалаар ГБХНХЯ-ны Ёс зүйн дэд хорооны гишүүнээр баталсан. Тус дэд хороо нь 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, хуралдааны дэгийг батлан ажиллаж байгаа бөгөөд тайлант хугацаанд 4 удаа хуралдаж, төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг шаардлагыг зөрчсөн байж болзошгүй тухай 5 гомдол ирснийг хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэсэн. Ёс зүйн хорооноос зохион байгуулсан Ёс зүйн дэд хорооны гишүүдийг чадавхжуулах, “Төрийн албан хаагчийн ёс зүйн сургалтын агуулга ба хэрэгцээ” сэдэвт хэлэлцүүлэгт 2 гишүүнийг хамруулсан болно. Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах чиг үүргийн хүрээнд Ёс зүйн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хорооноос зохион байгуулсан ёс зүйн сургагч багш бэлтгэх” анхан шатны сургалтад Нийгмийн Даатгалын ерөнхий газрын Захиргаа удирдлагын хэлтсийн дарга Б.Даваахүү, ХХҮЕГ-ын ахлах мэргэжилтэн, Н.Даваадорж, тус яамны ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга Д.Энхзаяа нар хамрагдаж сургагч багшийн эрх авсан. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын 112 байгууллагын ёс зүйн дэд хорооны 498 гишүүнийг хамруулан 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Ёс зүйн дэд хорооны ажиллах журам, холбогдох бусад хууль тогтоомжийн талаар мэдлэг эзэмшүүлэх сургалтыг танхим болон цахимаар хослуулан зохион байгуулсан. | |
| 4.2.3. | Зорилт 7: “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах; | Улсын төсөв | Арга хэмжээний хэрэгжилт /хувь/ | 0 | гүйцэтгэл /хувь/ | I-IV улирал | |
| 80. | 4.2.3.1. Салбарын хэмжээнд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх манлайлал, ил тод байдлыг төлөвшүүлэх, олон нийтийн итгэлийг хүлээсэн албыг бэхжүүлэх үүднээс авлигын эрсдэлийг бууруулах тусгайлсан төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ. | үйл ажиллагааны зардал | 2025 оны шударга байдлын үнэлгээний дундаж оноо | -2023 оны шударга байдлын үнэлгээг ээр яамдаас хамгийн бага үнэлгээ 74.8 оноо авсан.<br>-2024 оны шударга байдлын үнэлгээн | 80 onooноос доошгүй | АТГ-аас 2025 оны 02 дугаар сарын 04-ны өдөр зохион байгуулсан “Шударга байдлын үнэлгээ ба авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө” 2024 оны үр дүн танилцуулах хэлэлцүүлэгт Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Мөнгөнтуул, шинжээч Г.Боргил нар оролцсон. Манай яамны хувьд 2023 оны шударга байдлын үнэлгээгээр яамдаас хамгийн бага үнэлгээ 69.8 оноо авч байсан бол тус үнэлгээг сайжруулах зорилгоор авлигын эрсдэлийг бууруулах тусгайлсан төлөвлөгөө гарган хэрэгжүүлсний үр дүнд 2024 оны шударга байдлын үнэлгээ нь (11.2↑) өсөж үнэлэгдэж 79.3 оноо авч хамгийн их өсөлттэй яам буюу 16 яамнаас эхний 5 дугаар байранд эрэмблэгдсэн амжилт гаргасан.<br>Мөн салбарын хэмжээнд авлига, ашиг сонирхлоос ангид байх, эрсдэлийг бууруулах, | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | ий дүн албан ёсоор хараахан гараагүй байна. Урьдчилсан дүнгээр 79 оноо | | салбарын шударга байдлын үнэлгээг дээшлүүлэх талаар Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар Х.Ихмөрөн нарын албаны хүмүүстэй 2025 оны 01-р сарын 10-ны өдөр уулзалт хийж зөвлөлдөх уулзалт, санал солилцсон.<br><br>АТГ-ын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран “Авлига, ашиг сонирхлоос сэргийлэх нь” сургалтыг 2025 оны 10 дугаар сарын 03-ны өдөр, харьяа 4 агентлаг, 8 төвийн дарга, нэгжийн дарга, төсөв санхүү хариуцсан мэргэжилтнүүдэд, 2025 оны 11 дугаар сарын 07-ны өдөр яамны нийт албан хаагчдад 2 удаа зохион байгуулсан. Тус сургалтад 196 албан хаагчдыг хамруулсан. Тус сургалтаар Төрийн нарийн бичгийн дарга яамны газар, хэлтсийн дарга, харьяа агентлаг, байгууллага, төвийн дарга нарт дараах 4 үүрэг даалгавар өгч биелтэд хяналт тавьж байна.<br><br>Авлигатай тэмцье” уриалсан Нэгдье”, “Авлигад үгүй гэж хэлье”, “Авлигын эсрэг нэгдье” зурагт хуудас, постер хийж гомдол, мэдээлэл хүлээж авах “Авлигыг мэдээлэх 110” тусгай дугаарын хамт яам, харьяа агентлаг, байгууллагуудын фейсбүүк болон цахим хуудасны нүүрэнд харагдахуйц хэсэгт байршуулсан. Яамны Авлигын эсрэг үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан авлигын эрсдлээс ангид байх, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий 3 видео контент бүтээж, яам, харьяа агентлаг, байгууллагуудын фейсбүүк болон цахим хуудсаар олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулсан. Түүнчлэн Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А/174, А/175 дүгээр тушаалын дагуу нийгмийн даатгалын | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллаж байна.<br>•Нийгмийн даатгалын салбарын чиглэлээр хууль тогтоомж, дүрэм, журам, заавар болон статистик мэдээллийг ГБХНХЯ-ны www.mlsp.gov.mn хуудас болон Нийгмийн даатгалын ерөнхий газрын www.ndaatgal.mn цахим хуудаст тухай бүр байршуулж ажил олгогч, иргэд, олон нийтэд хүргэж байна. https://mlsp.gov.mn/content/detail/3137<br>• Түүнчлэн, тайлант хугацаанд нийгмийн даатгалын хууль тогтоомжийг шинэчлэх хүрээнд олон нийтээс санал авахаар “Малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нэг удаа нөхөн төлүүлэх журам батлах тухай” Засгийн газрын тогтоолын төсөл, “Засгийн газрын болон Монголбанкны үнэт цаас худалдан авах хөрөнгийн хэмжээг батлах тухай” Засгийн газрын тогтоолын төсөл, Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл, Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг тус тус яамны вэбсайтын “Хууль эрх зүй” хэсэгт байршуулан олон нийтээс санал авч хэлэлцүүлсэн. https://mlsp.gov.mn/content?c=5 | |
| 81. | 4.2.3.2. Төрийн албаны цалин хөлс, нийгмийн баталгааны ялгамжтай байдлыг арилгах, ил тод байдлыг нэмэгдүүлэх эрх зүйн | үйл ажиллагааны зардал | Цалин хөлс, нийгмийн баталгааны боловсруулсан хуулийн төсөл /тоо/ | 0 | 1 | Төрийн албан хаагчийн эрх зүйн байдал, цалин хөлс, нийгмийн баталгааг тогтоохтой холбогдсон харилцааг Төрийн албаны тухай хуулиар зохицуулж байгаа боловч 35 хуулиар тухайн салбарын төрийн албан хаагчийн нийгмийн баталгаатай холбоотой асуудлыг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | орчныг боловсронгуй болгох, судалгаа, хууль тогтоомжийн төсөл боловсруулна. | | Төрийн албаны цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон Засгийн газрын тогтоолын төсөл /тоо/ | 1 | 1 | ялгаатай байдлаар зохицуулж байна. Дээрх нөхцөл байдлаас шалтгаалан цалин хөлсний нэгдсэн бодлого, адил албан тушаалд ижил цалин хөлс олгох суурь зарчим алдагдаж, салбар хоорондын ажиллах хүчний шилжилт хөдөлгөөн нэмэгдэж, зарим салбарт хүний нөөцийн дутагдалд орох зэрэг сөрөг үр дагавар бий болсон тул Төрийн нарийн бичгийн даргаар ахлуулсан дэд ажлын хэсэг Төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгааны тухай хуулийн төслийг боловсруулж бэлэн болголоо. Монгол Улсын 2023 оны төсвийн тодотголын хүрээнд төрийн албан хаагчдын цалин хөлсийг 2023 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс дунджаар 40 хувиар нэмэгдүүлэн тогтоосон. Үүний дотор цагдаа, дотоодын цэргийн болон бусад төрийн тусгай албан хаагчийн цалингийн хэмжээг ялгаатай тогтоож байсныг нэгтгэн тогтоосноор адил зэрэглэлд хамаарах албан хаагчдын цалингийн зөрүүтэй байдал арилж, албан тушаалын цалин дунджаар 26-50 хувиар нэмэгдсэн.<br><br>Улмаар 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс төрийн тусгай албан хаагчдын цалинг 10 хувь, 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 хувь нэмэгдүүлэн тогтоосон. Эдгээр арга хэмжээний үр дүнд төрийн тусгай албан хаагчдын үндсэн цалингийн доод хэмжээ 1.166.000 төгрөг болсон .<br><br>Түүнчлэн төрийн тусгай чиг үүргийн байгууллагуудын албан хаагчдын ижил төрлийн нэмэгдлийн хэмжээг ялгаатай тогтоож байсныг адилтгах арга хэмжээг 2023 оноос хэрэгжүүлэн 10 орчим журамд нэмэлт, өөрчлөлт оруулан, шинэчлэн батлаад байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 82. | 4.2.3.3. Нийгмийн даатгалын сангийн төсөв, хөрөнгийн удирдлага ил тод, хараат бус, олон нийтийн хяналтад байх тогтолцоог бүрдүүлж хэрэгжилтэд нь хяналт тавина. | үйл ажиллагааны зардал | Тухайн онд хийсэн хяналт, шинжилгээ, үнэлгээний тайлан /тоо/ | 0 | 1 | Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А/174, А/175 дугээр тушаалын дагуу нийгмийн даатгалын мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллаж байна. Хуримтлалын сангийн мэдээллийн нэгдсэн систем бий болгоход шаардагдах ажлын даалгаврыг боловсруулах хүрээнд холбогдох уулзалтыг 2025 оны 01, 02, 03 сард 4 удаа зохион байгуулж ажилласан. Энэхүү мэдээллийн санд тавигдах системийн шаардлага, программ хөгжүүлэлтэд тавигдах шалгуурын талаар санал солилцон, хамтран ажиллаж байна.<br><br>Нийгмийн даатгалын сангийн мэдээллийн олон нийтэд нээлттэй байршуулах, сангийн ил тод байдлыг хангах хүрээнд нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийн 2008-2024 оны мэдээллийг https://shilen.gov.mn/ цахим хуудасны Засгийн газрын тусгай сангийн нээлттэй мэдээлэл хэсэгт 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдөр байршуулсан. Энэхүү нээлттэй мэдээлэлд тэтгэврийн даатгалын сан, тэтгэмжийн даатгалын сан, ажилгүйдлийн даатгалын сан, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн 16 жилийн орлого, зарлагын мэдээллийг аймаг, дүүргээр болон нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийг байршуулсан банкны мэдээллийг агуулсан.<br><br>Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан бөгөөд уг хуулийн 13 дугаар зүйлд Нийгмийн даатгалын сангийн хөрөнгө оруулалтын удирдлагын асуудлыг тусгасан. | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Тухайлбал, 13.1 дэх хэсэгт нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг найдвартай, үр өгөөжтэй, хариуцлагатай, ил тод, хараат бус байх зарчмыг баримтлан Засгийн газрын үнэт цаас, Монголбанкны үнэт цаас, Төрийн сангийн нэгдсэн дансанд байршуулах мөнгөн хадгаламж, Банкны системд нөлөө бүхий банканд байршуулах мөнгөн хадгаламж гэсэн санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулж болно гэж, 13.3 дахь хэсэгт хөрөнгө оруулах үйл ажиллагаанд хяналт тавих, мэргэжил, арга зүйгээр хангах чиг үүрэг бүхий орон тооны бус олон нийтийн хяналтын зөвлөлтэй байх, 35.17-д нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах шийдвэр гаргахад шаардлагатай судалгаа, эрсдэлийг үнэлэх, санал, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий эрсдэлийн удирдлага, актуар тооцоолол хийх, хөрөнгө оруулалт, аудитын орон тооны бус мэргэжлийн хороог Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дэргэд ажиллуулна гэж тус тус заасан.<br><br>Энэ хүрээнд Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны 03 дугаар тогтоолоор “Орон тооны бус олон нийтийн хяналтын зөвлөлийн дүрэм”, 2024 оны 04 дүгээр тогтоолоор “Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дэргэдэх орон тооны бус мэргэжлийн хорооны ажиллах журам”, 2024 оны 10 дугаар тогтоолоор мэргэжлийн хорооны болон олон нийтийн хяналтын зөвлөлийн гишүүдийг тус тус баталсан.<br><br>Ингэснээр нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн удирдлагыг сайжруулах, хөрөнгийг зүй зохистой удирдах хууль эрх зүйн орчин бүрдсэн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2024 оны 14 дүгээр тогтоолоор нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээс Засгийн газрын урт хугацаат бонд, Монголбанкны үнэт цаас худалдан авахад 2024 онд зарцуулах хөрөнгийн хэмжээг 300.0 тэрбум төгрөгөөр баталсан.<br><br>Энэ хүрээнд нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг Засгийн газрын бондод оруулж, сангийн хөрөнгийг 55.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн.<br><br>Түүнчлэн, Засгийн газрын 2025 оны 192 дугаар тогтоолоор нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээс Засгийн газрын урт хугацаат бонд, Монголбанкны үнэт цаас худалдан авахад зарцуулах хөрөнгийн хэмжээг 2025 онд 300.0 тэрбум хүртэлх төгрөгөөр баталсан. Мөн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны 07 дугаар, 08 дугаар тогтоолоор нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээс банкны системд нөлөө бүхий арилжааны банканд 2025 онд хадгаламж хэлбэрээр байршуулах мөнгөн хөрөнгийн дээд хэмжээг 700.0 тэрбум төгрөгөөр, мөнгөн хадгаламжийн хүүгийн доод хэмжээг жилийн 14.20 хувиар шинэчлэн баталснаар арилжааны 4 банканд нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээс 700.0 тэрбум төгрөгийг байршуулах зэргээр эрсдэл багатай, тогтмол өгөөжтэй санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулж сангийн хөрөнгийг өсгөж байна.<br><br>Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-аас дэлхийн томоохон тэтгэврийн сан болон улсын тэтгэврийн нөөц сангуудын хөрөнгө оруулалт-2023 судалгаа, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мөн “Thinking Ahead Institute” болон “Pensions & Investments” байгууллагаас 2024 онд хийсэн дэлхийн тэргүүлэх 300 тэтгэврийн сангийн хөрөнгийн удирдлагын судалгаанаас үзвэл улс орнууд өөрийн орны санхүүгийн зах зээл, улсын төсвийн бодлого, дотоодын зэх зээлийг дэмжих зэрэг бодлоготой уялдуулан тэтгэврийн сангийн хөрөнгийг Засгийн газрын бонд, Төв банкны үнэт цаас, банкны хадгаламж зэрэг тогтмол орлого бүхий санхүүгийн хэрэгсэл (fixed income securities)-д түлхүү оруулж байна. | |
| 83. | 4.2.3.4. Хүүхдийн шударга байдалд сөргөөр нөлөөлж байгаа хүчин зүйлсийг бууруулах арга хэмжээг АТГ-тай хамтран хэрэгжүүлнэ. | үйл ажиллагааны зардал | Тухайн онд сургалтад хамрагдсан зорилтот гэр бүл /тоо/ | 0 | 30 | АТГ-аас 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр зохион байгуулсан "Хүүхдийн шударга байдал"-2024 оны судалгааны үр дүнгийн танилцуулга, хүүхдийн шударга байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ хэлэлцүүлэгт ГБХНХЯ-аас ТЗУГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн шинжээч /ЭБАТ/ Г.Боргил, Гэр бүлийн бодлогын газрын Эмэгтэйчүүдийн хөгжил, хамгааллын бодлого, төлөвлөлт хариуцсан ахлах шинжээч М.Одонцэцэг, Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын ерөнхий газрын Сургалт судалгаа мэдээллийн төвийн захирал Г.Ариунчимэг, ахлах ажилтан Ц.Одонтунгалаг нарын бүрэлдэхүүнтэй оролцсон.<br><br>Хүүхдийн шударга байдалд сөргөөр нөлөөлж байгаа хүчин зүйлсийг нарийвчлан тодорхойлох, ёс зүй, ёс суртахуун, төлөвшил, авлигыг үл тэвчих үзэлд ямар хүчин зүйлс сөргөөр нөлөөлж байгааг тогтоох, цаашид хүүхдийн насан туршийн боловсролд хөрөнгө оруулах, тэдгээрийг хүмүүжүүлэх, төлөвшүүлэхийн тулд авч хэрэгжүүлбэл зохих урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын чиглэлийг тогтоох, хэрэгжүүлэхэд зорилготой юм. | 70 |
| | | | Хүүхдийн шударга байдлын үнэлгээний өссөн хувь /улсын хэмжээнд/ | 2024 онд 4.08 хувь | 4.1-ээс доошгүй | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Авлигатай тэмцэх газар нь 2010 оноос хойш “Хүүхдийн шударга байдлын судалгаа”-г жил бүр тасралтгүй хийж байна  Тус судалгаанд хүүхдийн шударга байдалд нөлөөлж буй хүчин зүйлсийг ерөнхий байдлаар тодорхойлсон байдаг бөгөөд ерөнхий боловсролын сургуулийн 7-12 ангийн сурагч, эцэг эхийг хамруулдаг.<br>“Хүүхдийн шударга байдал”-2025 оны суадлгааны үр дүн тайлан 2026 оны 01 дүгээр гарч танилцуулагдах хугацаатай.<br>Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний "4.Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ"-ны Хүүхдийн шударга байдалд сөргөөр нөлөөлж байгаа хүчин зүйлсийг бууруулах арга хэмжээг АТГ-тай хамтран хэрэгжүүлнэ." арга хэмжээг төлөвлөн батлуулж хэрэгжилтийг хангаж ажилласан. Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын ерөнхий газар, аймаг, дүүргийн ХГБХХ-ын газар, хэлтсүүд аймаг, дүүргийн ИТХ, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтай хамтран<br>- Хүүхдийн шударга байдлыг төлөвшүүлэх, дэмжих,<br>- Ёс суртахуун, үнэнч байдал, хариуцлагыг төлөвшүүлэх,<br>- Шударга байдлын талаарх ойлголт, хандлагыг дээшлүүлэх,<br>-  Авлигыг үл тэвчих соёлыг төлөвшүүлэх,<br>-Ирээдүйн шударга, хариуцлагатай иргэнийг төлөвшүүлэх зорилгоор “Шударга ёсны утга учир” сургалтыг  улсын хэмжээнд зохион | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгуулсан. Тухайлбал Баян-Өлгий аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газраас 2025 оны 10-р сарын 29–31-ний өдрүүдэд “Шударга ёсны утга учир” сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Тус сургалтад Өлгий сумын Ерөнхий боловсролын 1, 3, 4-р сургуулийн ахлах ангийн сурагчид, Мэргэжлийн Боловсролын Сургуулийн 1, 2-р дамжааны оюутанууд, Бугат сумын Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчид нийт 500 гаруй сурагч, оюутнууд сургалтад хамрагдан, шударга иргэний төлөвшил, ёс зүй, үнэнч байдлыг төлөвшүүлэхэд чиглэсэн хэлэлцүүлэг, кейс судалгаа, интерактив арга хэмжээг зохион байгуулсан.<br><br>Тус “Шударга ёсны утга учир” сургалт, хэлэлцүүлгийг 2026 онд үргэлжлүүлэн бүх аймаг, дүүрэгт зохион байгуулахаар төлөвлөөд байна.<br><br>Мөн авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр Авлигатай тэмцэх газартай хамтран “Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ба Авлига үүсэхэд нөлөөлдөг хүчин зүйл, шалтгаан нөхцөл” сэдэвт сургалтыг ХГБХХЕГ-ын албан хаагчид болон 21 аймаг, нийслэл, харьяа байгууллагын 522 мэргэжилтнийг хамруулсан ба тодруулбал танхимаар-22, цахимаар-500 албан хаагч байна. энэ нийт албан хаагчийн 67.8 хувийг эзэлж байна.“<br><br>Авилгын эсрэг бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилт, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа” сэдэвт танхим, цахим хосолсон сургалтыг 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулж нийт 226 албан хаагч оролцсон. Албан хаагч нарт авилгын эсрэг | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бодлого, хууль тогтоомж, түүний хэрэгжилт, албан тушаалтны хүлээх үүрэг, хэрэгжүүлэх арга хэмжээг ойлгон таниулах, авилга, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд анхаарч ажиллах талаарх мэдээлэл арга зүйг өгсөн. | |
| 4.3.ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЗӨВ, ОНОВЧТОЙ БОДЛОГО БОЛОВСРУУЛЖ, ГЭР БҮЛД ЭЭЛТЭЙ, ЗОХИСТОЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ, ХӨДӨЛМӨРИЙН ХАРИЛЦААГ ТӨЛӨВШҮҮЛЭХ, ХӨДӨЛМӨРИЙН ХУУЛЬ ТОГТООМЖ, ЦАЛИН ХӨЛСНИЙ БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ТҮНШЛЭЛИЙН ГУРВАН ТАЛТ БОЛОН БУСАД ХАМТЫН АЖИЛЛАГААГ ХАНГАХ, САЛБАРЫН ХУУЛЬ ТОГТООМЖ, НОРМ, СТАНДАРТЫН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ, ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙД ХЯНАЛТ ТАВИХ СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 2.5.3-ИЙН ХҮРЭЭНД: | | | | | | | |
| 4.3.1. | Зорилт 1. Салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах | Улсын төсөв | Хууль сахин мөрдөлт /хувь/ | 65.5 | 70.0 | I-IV улирал | |
| 84. | 4.3.1.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар болон Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн Төрийн бус байгууллагатай хамтран Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн хэрэгжилтийн улсын үзлэг зохион байгуулна. | Улсын төсөв | Үзлэгт хамрагдсан 25 -аас дээш ажилтантай ААНБ /тоо/ | 0 | 700 | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн А/102 дугаар тушаалаар баталсан Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн хэрэгжилтэд улсын үзлэг зохион байгуулах удирдамжийн хүрээнд аймаг, дүүрэг дэх газар, хэлтсүүдийн хөдөлмөрийн хяналтын улсын (ахлах) байцаагчид 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй 25, түүнээс дээш ажилтантай төрийн, хувийн болон гадаадын хөрөнгө оруулалттай **1018** аж ахуйн нэгж, байгууллагыг үзлэгт хамруулсан байна. Үзлэгт хамрагдсан 25, түүнээс дээш ажилтантай нийт байгууллагын **63,6** хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг зохих орон тоонд ажиллуулаагүй, ажиллуулбал зохих орон тоо тутамд ногдох төлбөрийг хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд санд төвлөрүүлээгүй буюу хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг хэрэгжүүлээгүй байна. Нийгмийн даатгалын | 100 |
| | | | Арилгасан зөрчлийн хувь | 0 | 80% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шимтгэл төлөгч 25, түүнээс дээш ажилтантай 6885 байгууллага (төр, хувийн хэвшлийн)-ын 1884 нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулбал зохих орон тоо тутамд ногдох төлбөрийг төлдөг, бусад 5041 байгууллага нь зохих төлбөрийг төлдөггүй, ажиллуулбал зохих орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулдаггүй байна. Улсын үзлэгт эдгээр байгууллагын 20,2 хувь хамрагдсан байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг зохих орон тоонд ажиллуулаагүй зөрчилтэй 154 аж ахуйн нэгж, байгууллагад 1,4 тэрбум төгрөгийг хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд санд төвлөрүүлэх хөдөлмөрийн хяналтын улсын /ахлах/ байцаагчийн нөхөн төлбөрийн акт тавьсан байна. Өнөөдрийн байдлаар актын биелэлт 67.5 хувь буюу 939,587.7 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна. Мөн Зөрчлийн тухай хуулийн 10.16 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан буюу Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн 144.2 дах хэсгийг зөрчсөн 58 аж ахуйн нэгж, байгууллагад 84.0 сая төгрөгийн шийтгэл ногдуулж (Улсын төсвийн хяналт шалгалтын орлогын дансанд), 494 албан шаардлага, 353 зөвлөмжийг хүргүүлсэн байна. Үзлэгт хамрагдсан нийт байгууллагын 48,5 хувьд нь зөрчил дутагдлыг арилгуулах хугацаатай үүрэг даалгавар өгч, биелэлт 82 хувьтай хэрэгжсэн байна. | |
| 85. | 4.3.1.2.Гадаад ажилтны хөдөлмөр эрхлэлтэд Гадаадын иргэн харьяатын газартай хамтран хяналт шалгалт хийнэ. | Улсын төсөв | Хамрагдсан обьектын тоо | 0 | 200 | Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2025 оны 08-07/16 дугаартай Гадаад ажилтны хөдөлмөр эрхлэлтэд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай удирдамжтай шалгалтад нийт 16 аймаг, 8 дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхлэж буй гадаадаас ажилтан авч ажиллуулдаг **241** аж ахуйн нэгж байгууллага хамрагдсан байна. Шалгалтад | 100 |
| | | | Зөрчил барагдуулалт /хувь/ | 0 | 80% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хамрагдсан аж ахуйн нэгж байгууллагуудад нийт 23843 иргэн ажиллаж байгаагаас нийслэл болон тухайн орон нутгаас ажиллаж буй иргэн 15307, гадаад улсын иргэн 6141 ажилтан хөдөлмөр эрхлэж байна. Хөдөлмөр эрхлэж буй гадаад ажилтны 3254 нь гүйцэтгэх албан тушаалд, 2555 нь туслах ажитнаар, 162 нь удирдах албан тушаалд, 207 нь хөрөнгө оруулагчаар, 58 нь хувийн зорилгоор, 2 нь түр ирэгчээр ирсэн иргэд байна. Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулахаар 60 аж ахуйн нэгж байгууллагад 466 заалттай улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлэн, Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтаар нийт **36** ААНБ-д нийт 213,0 сая төгрөгийн торгууль ногдуулж, торгуулийг бүрэн барагдуулсан (**100%**) байна. Мөн Монгол Улсад аяллын визээр орж ирсэн гадаад иргэдээр ажил хөдөлмөр эрхлүүлсэн, нийт монгол ажилтны 10 хувиас илүү хэмжээгээр гадаад иргэдийг авч ажиллуулсан ажлын байр тутамд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төлбөрийг төлөөгүй зөрчлийг үйлдсэн 21 ААНБ-д нийт 5,355,696.0 (таван тэрбум гурван зуун тавин таван сая зургаан зуун ерэн зургаан мянга) төгрөгийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд болон орон нутгийн нэмэлт санхүүжилтийн дансанд нөхөн төлүүлэхээр улсын ахлах байцаагчийн актыг хүргүүлсэн байна. Тайлант хугацаанд 12 акт биелэгдсэн буюу зөрчил барагдуулалт 58 хувьтай байна. | |
| 86. | 4.3.1.3.Онцгой байдлын ерөнхий газартай хамтран аймаг, нийслэл, дүүргийн онцгой байдлын | Улсын төсөв | Үзлэг хийсэн объект /хувь/ | 0 | 100 хувь | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга болон Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр хамтран баталсан удирдамжийн хүрээнд Онцгой байдлын ерөнхий газрын харьяа 152 газар, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байгууллагуудад Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтэд улсын үзлэг зохион байгуулж, үр дүнг танилцуулах | | | | | хэлтэс, анги, салбаруудад Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийн улсын үзлэгийг 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрөөс 02 дугаар сарын 27-ны өдрүүдэд хийж гүйцэтгэв. Үзлэгийн дүнгээр Онцгой байдлын ерөнхий газар болон түүний харьяа нэгжүүдэд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилт дунджаар 54 хувьтай үнэлэгдэв.<br><br>Улсын үзлэгийн дүнг ГБХНХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга болон ОБЕГ-ын удирдлагуудад танилцуулах хурлыг 2025.05.19-ны өдөр зохион байгуулж, үзлэгээр илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор ОБЕГ-т Салбарын улсын ерөнхий байцаагчийн 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 07/00-00/001-01 тоот албан даалгаврыг хүргүүлсэн байна. | |
| 4.3.2 | Зорилт 2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн эрх зүйн актыг боловсронгуй болгох | Улсын төсөв | Эрх зүйн акт /тоо/ | 1 | 1 | I-IV улирал | |
| 87. | 4.3.2.1.Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрмийг шинэчлэн боловсруулна. | ҮОМШӨДСан | Шинэчлэн боловсруулсан дүрмийн төсөл /тоо/ | 1 | 1 | Засгийн газрын 2015 оны 269 дүгээр тогтоолоор баталсан “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм”-ийг шинэчлэх ажлын хэсгийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/170 дугаартай тушаалаар байгуулсан бөгөөд уг ажлын хэсэг дүрмийн төслийг боловсруулж, 2023-2024 онд 4 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулж, холбогдох талуудаас санал авч, дүрмийн төсөлд тусгасан. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажилтай | 50 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | холбогдуулан үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрмийн төслийг эцэслэн боловсруулах ажил хүлээгдэж байна. | |
| 4.4. САЛБАРЫН ХУУЛЬ ТОГТООМЖ, БОДЛОГО, ХӨТӨЛБӨР, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦАД ШИНЖИЛГЭЭ ХИЙХ, ҮР ДҮНД ҮНЭЛГЭЭ ӨГӨХ, ДОТООД АУДИТ ХИЙХ, ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ, САЛБАРЫН ЦАХИМ, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР УРТ, ДУНД, ХУГАЦААНЫ БОДЛОГО, ТӨЛӨВЛӨГӨӨ, ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛАХ, БАТЛУУЛАХ АШИГЛАХ, ИХ ӨГӨГДӨЛД СУУРИЛСАН БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖӨӨР ХАНГАХ, СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛАХ СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 2.5.7-ИЙН ХҮРЭЭНД: | | | | | | | |
| 4.4.1. | Зорилт 1: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр үр дүнтэй хэрэгжсэн эсэхэд үнэлгээ хийнэ. | үйл ажиллагааны зардал | - Бодлогын баримт бичиг;<br><br>- ХШҮ-ний тайлан;<br><br>- Төлөвлөгөө; | | 22 | I-IV улирал | |
| 88. | 4.4.1.1.Бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | үйл ажиллагааны зардал | Тухайн онд үнэлгээ хийх бодлогын баримт бичиг /тоо/ | 0 | 5 | Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Засгийн газрын 43 дугаар тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ЗГХЭГ, ЭЗХЯ-нд хүргүүлэн цахим мэдээллийн санд оруулсан. | 100 |
| 89. | 4.4.1.2.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | үйл ажиллагааны зардал | Тухайн онд хийсэн ХШҮ-ний тайлан /тоо/ | 0 | 4 | Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын албан даалгаврын Гэр бүл, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын 2025 оны жилийн ажлын хэрэгжилтэд Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээг тогтоосон хуваарийн дагуу хийхээр бэлтгэл ажил хангагдаж байна. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээнд системд шинэчлэгдсэн хувилбараар 303 шийдвэр, 638 заалтын хүрээнд үүрэг даалгавар өгсөн байна. Эхний хагас жилийн байдлаар яамны эрхлэх асуудлын хүрээнд 213 шийдвэрийн 393 заалтын хүрээнд тайлагнасан бөгөөд хэрэгжсэн 194, хэрэгжээгүй 95 хугацаа болоогүй 71 заалт байгаагаар үнэлгээ хийгдсэн. | |
| 90. | 4.4.1.3.Салбарын стратеги төлөвлөгөө болон байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | үйл ажиллагааны зардал | Боловсруулсан стратеги төлөвлөгөө /тоо/ | 0 | 1 | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/205 дугаар тушаалаар баталсан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг баримтлан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөнд нийт 5 зорилтын 46 арга хэмжээ туссан байна. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөний биелэлт 82.0 хувьтай үнэлэгдлээ.<br>ГБХНХЯамны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд | 100 |
| | | | Гүйцэтгэлийн төлөвлөгөө /тоо/ | 0 | 8 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам", 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн биелэлтэд Засгийн газрын 43 дугаар тогтоолоор баталсан "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам"-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.<br>Яамны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд бодлогын баримт бичигт тусгагдсан, хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах 3 зорилтын нийт 155 арга хэмжээ туссан байна.<br>Үүнээс:<br>- Бүрэн хэрэгжсэн 100 хувьтай - 117 арга хэмжээ,<br>- 90 хувьтай 24 арга хэмжээ,<br>- 70 хувьтай 9 арга хэмжээ,<br>- 50 хувьтай 1 арга хэмжээ,<br>- 30 хувьтай 3 арга хэмжээ,<br>-УИХ-ын ээлжилт сонгуультай холбоотойгоор 1 арга хэмжээний хэрэгжих хугацаа хойшлогдсон байна.<br>Үнэлгээний дундаж хувийг тооцохдоо хойшлогдсон арга хэмжээг оруулан тооцоогүй болно. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 95.0 хувьтай үнэлэгдлээ.<br>ГБХНХЯамны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд бодлогын баримт бичигт тусгагдсан, хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах 3 хэсэг зорилт, арга хэмжээний нийт 128 арга хэмжээ туссан байна. Үүнээс 78 арга хэмжээ бүрэн хэрэгжсэн, 90 хувьтай 15 арга хэмжээ, 70 хувьтай 12 арга хэмжээ, 50 хувьтай 1 арга хэмжээ, 30 хувьтай 2 арга хэмжээ, хугацаа болоогүй 20 арга хэмжээ байна.<br>Үнэлгээний дундаж хувийг тооцохдоо хугацаа болоогүй арга хэмжээг оруулан тооцоогүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | болно. Яамны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн биелэлт 93.5 хувь “бүрэн хангалттай” буюу зорилтот түвшиндээ хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарч эхэлсэн байна.<br>ГБХНХЯ-ны харьяа 4 агентлаг, 2 төвийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн биелэлтэд Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.<br>Үнэлгээний дүн<br>1. Нийгмийн даатгалын ерөнхий газар 91.4<br>2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар 81.5<br>3. Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар 70.0<br>4. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар 68.8<br>5. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв 80.5<br>6. Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, судалгааны хүрээлэн 82.7<br>ГБХНХЯ-ны харьяа 4 агентлаг, 2 төвийн 2025 оны хэрэгжилтийн тайланд ЗГ-ын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж байна. | |
| 91. | 4.4.1.4. Улсын төсөв болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төслүүдийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | үйл ажиллагааны зардал | Тухайн онд хийсэн ХШҮ-ний тайлан /тоо/ | 0 | 3 | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт ГБХНХЯ үндсэн хэрэгжүүлэгчээр ажиллаж байгаа дараах 3 төслийн 2024 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үнэлгээний тайлан, танилцуулгыг ГБХНХ-ын сайдын 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 01/677 дугаар албан бичгээр Сангийн сайдад, цахимаар холбогдох газарт тус тус хүргүүлсэн. Үүнд: | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 1.Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл – 2,<br>2.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл,<br>3.Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл<br>ХШҮ-ний тайлан, нэгдсэн дүгнэлт, танилцуулгыг Сайд, Төрийн нарийн бичгийн дарга, 3 төслийн захиралд “Танилцуулах хуудас”-аар 2025.02.20-27-ний өдөр танилцуулан ажилласан. | |
| 92. | 4.4.1.5. Яамны үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн тайлан хүргүүлнэ. | үйл ажиллагааны зардал | Тухайн онд хийсэн ХШҮ-ний тайлан /тоо/ | 0 | 1 | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт хамаарах бодлогын баримт бичиг, холбогдох эрх зүйн акт болон яамны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, байгууллагын ил тод байдал, Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг баримтлан хян Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2024 оны үйл ажиллагааг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6 дугаар хавсралтын дагуу дүгнэхэд ерөнхий үнэлгээ 94.0 хувь буюу 4.70 оноотой байна. | 100 |
| 4.4.2. | Зорилт 2: ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, эрсдэлийг тодорхойлж, | үйл ажиллагааны зардал | Акт, албан шаардлага, зөвлөмж /тоо/ | 450 | 405 | I-IV улирал | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | санхүүгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх. | | | | | | |
| 93. | 4.4.2.1.Төсөвт байгууллага, тусгай сангуудын үйл ажиллагаа, төсвийн хөрөнгийн зарцуулалт, холбогдох хууль журмын хэрэгжилтэд дотоод аудит хийнэ. | үйл ажиллагааны зардал | Аудитын төлөвлөгөөний хэрэгжилт /хувь/ | 0 | 80 хувь | 1. ГБХНХ-ын сайдын дэргэдэх дотоод аудитын хорооны 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж, хорооны 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн №02 дугаар тогтоолоор “Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний төсөвт байгууллага, тусгай сангийн үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалт хийх 2025 оны ажлын төлөвлөгөө”-г батлуулан графикт хугацааг мөрдөн ажиллаж байна.<br>2. ГБХНХ сайдын 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн А/77 тушаалаар батлагдсан Удирдамжийн дагуу АНҮТ-ийн 2023-2024 оны санхүүгийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийсэн. Шалгалтаар нийт 806,877.2 мянган төгрөгийн зөрчил илэрсэнтэй холбогдуулан 1,003.9 мянган төгрөгийг нөхөн төлүүлэхээр 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 12/04-01 дугаартай улсын байцаагчийн акт, 805,873.3 мянган төгрөгийн зөрчлийг арилгуулахаар улсын байцаагчийн 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 12/03-01, 12/03-02, 12/03-03 дугаартай 18 заалт бүхий 3 албан шаардлагаар хугацаатай үүрэг өгч ажилласан.<br>3. ГБХНХ сайдын 2025 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн А/66 дугаар тушаалаар батлагдсан удирдамжийн дагуу ХХҮЕГ-ын 2024-2025 оны эхний хагас жилийн төсвийн үйл ажиллагаа, ХЭДС-ийн гүйцэтгэлд дотоод аудит хийж тайланг нэгтгэн, шийдвэрийн хамт агентлагт хүргүүлж баталгаажуулсан. Аудитаар нийт 252.6 сая төгрөгийн асуудал илэрсэн, илэрсэн зөрчлийн 47.7 сая төгрөгийг тусгай санд төвлөрүүлэхээр улсын ахлах байцаагчийн 4 акт, 204.9 сая төгрөгийн зөрчлийг | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | арилгуулахаар зөвлөмж, танилцуулгыг тус тус хүргүүлсэн.<br>4. ГБХНХ сайдын 2025 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн А/65 дугаар тушаалаар батлагдсан удирдамжийн дагуу ХБХХЕГ-ын ХЭДС-ийн 2022, 2023, 2024 он, 2025 оны эхний хагас жил, Төсвийн үйл ажиллагааны 2024 он, 2025 оны эхний хагас жилийн гүйцэтгэлд дотоод аудит, хяналт шалгалт хийж тайланг нэгтгэсэн /баталгаажуулах шатандаа байгаа/. Шалгалтаар ХЭДсантай холбоотой 5,625.9 мянган төгрөгийн, төсвийн үйл ажиллагаатай холбоотой 264.5 мянган төгрөгийн нийт 5,890.4 мянган төгрөгийн зөрчил илэрснийг асуудлын бүртгэлийн жагсаалтаар гаргаж ХБХХЕГ-т хүргүүлж нэмэлт тайлбар, тодруулга авахаар хүргүүлсэн болно.<br>5. ХГБХХЕГ болон ХАБЭМТ-ийн төсвийн үйл ажиллагаанд хийх дотоод аудитын ажлын удирдамжийг батлуулах, дотоод аудит хяналт шалгалтын ажлыг эхлүүлэх зэрэг бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.<br>6. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн “Төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай” А/252 дугаар тушаалаар баталсан удирдамжийн дагуу Хүүхдийн улсын төрөлжсөн асрамжийн үйлчилгээ, сургалт хүмүүжлийн үйл ажиллаагаа явуулдаг “Өнөр бүл хүүхдийн төв”-/регистрийн дугаар-9077529/-ийн 2024 он, 2025 оны эхний хагас жилд гадаад, дотоодын иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас хандив, тусламжийн шугамаар хүлээлгэн өгсөн бараа материал, эд хөрөнгийн орлого, зарцуулалт, үр дүн, дотоод хяналтын үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг 2025 оны 09 дүгээр сарын 15-аас 19-ний өдрүүдэд хийж дүнг нэгтгэн 2025 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | оны 09 дүгээр сарын 30-ны өдөр АТГ-т 02/3104 дугаар албан бичгээр хүргүүлсэн.<br>Шалгалтын дүнг үндэслэн Өнөр бүл төвд “Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах тухай” 12/03-06 дугаартай 4 заалт бүхий улсын байцаагчийн хамтарсан албан шаардлага хүргүүлж биелэлтийн хангуулж ажилласан.<br>7. ГБХНХ-ын сайдын "Дотоод аудит хийх тухай" А/210 дугаар тушаалын дагуу ГБХНХ-ын салбарын улсын төсвийн хөрөнгөөр 2025 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд дотоод аудитын ажлаар Өвөрхангай аймгийн Хархорин сум, Завхан аймгийн Тосонцэнгэл сум, Хөвсгөл, Говьсүмбэр, Сүхбаатар аймгууд, Багахангай, Налайх дүүргүүдэд ажилласан, ажлын тайланг нэгтгэж байна. | |
| 94. | 4.4.2.2.Үндэсний аудитын газар, Сангийн яам, дотоод аудит, хяналт шалгалтаар харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавина. | үйл ажиллагааны зардал | Зөвлөмжийн хэрэгжилт /хувь/ | 0 | 90 хувь | 1.Үндэсний аудитын газраас Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, зөвлөмжид дурдсан зөрчлийн нөхцөл шалтгааныг тогтоож, хяналт-шинжилгээ хийж зөрчлийг давтан гаргахгүй ажиллах талаар онцгой анхаарч, төсвийн сахилга хариуцлагыг нэмэгдүүлэн дотоод аудитын хорооны тогтоолыг бүрэн хэрэгжүүлж ажиллах тухай Дотоод аудитын хорооны № 01 дүгээр тогтоолыг 2025 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 09/883 албан бичгээр хүргүүлж хэрэгжилтэд fas.audit.mn системээр 19 байгууллагын гүйцэтгэлд хяналт тавьж, явцын үнэлгээ хийж ажиллаж байна.<br>2.Үндэсний аудитын газраас 2024 оны Санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт, зөвлөмжийн талаарх мэдээлэл, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг харьяа газруудаас ирүүлэх тухай 2025.03.17-ны өдрийн 09/801 албан бичгийг | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүргүүлж мэдээллийг авч салбарын хэмжээнд нэгтгэн шинжилгээ хийсэн.<br>3. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Эдийн засаг, санхүү, төсөв, хөрөнгө оруулалтын газраас Үндэсний аудитын газартай хамтран салбарын харьяа байгууллагуудын 2024 оны санхүүгийн тайлангийн аудит, аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг арилгах, давтахгүй байх сургалтыг 2025 оны 05 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулсан.<br>Сургалтад салбарын хэмжээний агентлаг, байгууллагын удирдлага, санхүүгийн ажилтнууд оролцож Үндэсний аудитын газар, ГБХНХ яамны Эдийн засаг, санхүү, төсөь, хөрөнгө оруулалтын газар, ХШҮДАГ-ын удирдлага, ажил хариуцсан албан тушаалтнууд мэдээлэл хийж хэлэлцүүлэг зохион байгуулан Төсвийн тухай хуулийн 16.5.5 хэсэгт заасны дагуу "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" талаар мэдээлэл, тусгайлсан үүрэг чиглэл өгч ажилласан.<br>4. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний төсөвт байгууллагуудад 2022-2024 онд захиргааны хууль бус шийдвэрийн улмаас ажлаас үндэслэлгүй халагдсаны улмаас шүүхийн шийдвэрээр тогтоогдсон, төрд учирсан хохирлын мэдээ, судалгааг нэгтгэж Төрийн албаны зөвлөлд 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 01/1804 дугаар албан бичгээр холбогдох хуулийн дагуу төрд учирсан барагдуулах талаар хүсэлт хүргүүлж хэрэгжилтийг хангуулан ажилласан.<br>5. ҮАГ-аас ирүүлсэн 2025.03.10-ны өдрийн “Судалгаа ирүүлэх тухай” 09/907 дугаар албан бичгийн дагуу Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн судалгаа авах тухай | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2025.03.21-ний өдрийн 09/875 дугаар албан бичгийг харьяа агентлаг, төв, газруудад, дотоод албан бичгийг яамны ЭЗСТХО-ын газарт тус тус хүргүүлсэн.<br>ГБХНХЯ болон харьяа агентлаг, төв, газар зэрэг нийт 21 байгууллагын 2023-2024 оны Төрийн хэмнэлтийн тухай хуулийн судалгааг гаргаж нэгтгэн 2025.06.10-ны өдрийн 09/1931 дүгээр албан бичгээр хариуг хүргүүлж, 2 хавсралтыг ҮАГ-ын аудитор П.Норпилийн norpilp@audit.gov.mn цахим хаягаар хүргүүлсэн.<br>6. ҮАГ-аас ирүүлсэн “Аудитын шийдвэрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” 2025-08-27-ны өдрийн 2535 дугаар албан бичгийн дагуу ГБХНХЯ, НДЕГ, ХХҮЕГ, ХБХХЕГ, ХГБХХЕГ, ХНХСҮСХ болон эрхлэх асуудлын хүрээний харьяа 7 байгууллага, төслийн нэгж зэрэг 14 байгууллагын 2018-2023 оны онд санхүү, гүйцэтгэлийн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг авч нэгтгэн, хавсралт хүснэгтийн хамт УАГ-т 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 01/2964 дүгээр албан бичгээр хүргүүлсэн.<br>7. ҮАГ-аас 2024 онд хийсэн "Нийгмийн даатгалын тогтолцоо, түүний үр нөлөө" сэдэвт гүйцэтгэлийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг гаргаж, 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 01/3305 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт хүргүүлсэн.<br>8. ҮАГ-аас ирүүлсэн “Аудитын шийдвэрийг биелүүлэх тухай” 2025-11-12-ны өдрийн 10/3172 дугаар албан бичгийн дагуу ГБХНХЯ болон салбарын хэмжээнд хэрэгжих хугацаа хэтэрсэн зөрчилтэй акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг холбогдох газар хэлтсүүдээс авч нэгтгэн, удирдлагаар | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хянуулан, 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 02/3907 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт хүргүүлсэн. | |
| 95. | 4.4.2.3.Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулж ажиллана. | үйл ажиллагааны зардал | Хуулийн хэрэгжилт /хувь/ | 0 | 90 хувь | 1. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны хүрээлэн, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв болон харьяа газар, хэлтсүүд, мөн “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл”, “Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл”, “Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл”-ийн нэгжийн нийт 214 шилэн дансны 2024 оны жилийн эцсийн болон 2025 оны 1-3 дугаар улирлын /www.shilendans.gov.mn/ цахим хуудасны хөтлөлт, нэгдсэн системд мэдээлэл байршуулсан байдал, тайлагналт зэрэгт 2025 онд 4 удаа дотоод хяналт хийж гүйцэтгэсэн.<br>2. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын 2024 оны Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн тайланг нэгтгэн, хавсралт хүснэгтийн хамт 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 09/264 дүгээр, 2025 оны 1 дүгээр улирлын тайланг нэгтгэн, хавсралт хүснэгтийн хамт 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 09/1326 дугаар, 2 дугаар улирлын тайланг нэгтгэн, хавсралт хүснэгтийн хамт 2025 оны 07 дугаар сарын 23-ний өдрийн 09/2433 дугаар,<br>2025 оны 3 дугаар улирлын тайланг нэгтгэн, хавсралт хүснэгтийн хамт 2025 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 09/3349 дүгээр албан | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бичгээр тус тус Сангийн яаманд хүргүүлж, хууль, журмын хэрэгжилтийг ханган ажилласан. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах, зөрчил дутагдлыг бууруулах, таслан зогсоох ажлын хүрээнд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн “Шилэн дансны тухай хууль болон холбогдох журмыг хэрэгжүүлж ажиллах тухай” 03 дугаар албан даалгаврыг харьяа байгууллагуудад 2025.02.27-ны өдрийн 09/676 дугаар албан бичгээр, яамны Төрийн захиргааны удирдлагын газар, Эдийн засаг, санхүү, төсөв, хөрөнгө оруулалтын газарт 2025.02.27-ны өдөр “Дотоод албан бичиг”-ээр тус тус хүргүүлсэн.<br>Мөн ГБХНХЯ, ҮАГ-ын газартай хамтран 2025.05.13-ны өдөр яамны 10 давхрын хурдын зааланд зохион байгуулсан “ГБХНХ-ын салбарын байгууллагууд, төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудит, цаашид анхаарах асуудал” сэдэвт сургалтад оролцож “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, цаашид анхаарах асуудал” сэдвээр сургалт зохион байгуулсан. Сургалтад танхимаар 19 байгууллагын 71, цахимаар 97 байгууллагын 442, нийт 116 байгууллагын 513 удирдах болон санхүүгийн ажилтнууд хамрагдсан.<br>www.shilendans.gov.mn/ цахим хуудасны Нээлттэй өгөгдлийн сангийн Статик тайлангийн цэсээс Төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланг 2025-12-08-ны өдрөөр тасалбар болгон шүүлт хийж үзэхэд ГБХНХС-ын эрхлэх асуудлын байгууллагуудын шилэн дансны хуулийн хэрэгжилт 91.00 хувь байна.<br>https://shilendans.gov.mn/openData/getRepFormsByRefTypeTTZ | |

| 5. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 5.1.5. | Зорилт 1: Салбарын цахим үйлчилгээг хөгжүүлэх, их өгөгдлийг бий болгох, ашиглах чиглэлээр хөтөлбөр батлуулна. | үйл ажиллагааны зардал | Батлагдсан хөтөлбөр /тоо/ | 0 | 1 | IV улирал | |
| 96. | 5.1.5.1. Салбарын их өгөгдлийг бий болгох, ашиглах нөхцлийг бүрдүүлнэ. | үйл ажиллагааны зардал 1,385,10 | Мэдээллийн нэгдсэн сан /тоо/ | 0 | 1 | Эрх зүйн орчин: Мэдээллийн нууцлалыг хангах, мэдээллийн эзнийг тодорхойлох боломжгүй болгох аргачлалыг ГБХНХ-ын сайдын 2025 оны А/08 тоот тушаалаар батлууллаа.<br>Техникийн дэд бүтэц: Дэлхийн банкны төслийн санхүүжилтээр нийт 5,3 тэрбум төгрөгийн өртөг бүхий 9 төрлийн 59ш тоног төхөөрөмжийг программ хангамжийн хамт ҮДТ-д суурилуулж техникийн орчинг бэлэн болгосон. Ингэснээр салбарын их өгөгдөл болон системүүдийг байршуулах, хэвийн найдвартай ажиллагааг хангахад серверийн хүчин чадал CPU:352 core, RAM:37 TB, Storage:387 TB-аар тус тус нэмэгдсэн.<br>Систем хөгжүүлэлт: Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан ажилласны үр дүнд харьяа агентлагуудын 4 мэдээллийн санг нэгтгэсэн "Салбарын их өгөгдлийн сан"-г үүсгэлээ.<br>Үр дүн (Дашбоард): Бодлогын дүн шинжилгээ хийх зориулалттай дараах 5 төрлийн дашбоард хөгжүүлж, ашиглахад бэлэн болоод байна. Үүнд:<br>• Яам 360 KPI<br>• Нийгмийн даатгал (Sigo 360)<br>• Нийгмийн халамж 360<br>• Хөдөлмөр 360<br>• Өрхийн мэдээллийн сан 360 | 90 |
| | | | Анализ, дүгнэлт, дашбордын тоо | 0 | 5 | | |
| | | | Хийгдсэн бодлогын дүн, шинжилгээний тоо | 0 | 1 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Дээрх нэгдсэн дашбоардуудыг ашиглан нийгмийн даатгал, халамж, хөдөлмөр эрхлэлт, хүн амын чиглэлээр бодлогын дүн шинжилгээ хийх нөхцөл бүрдсэн. Орон сууцны хөнгөлөлттэй зээлийн (ипотекийн санхүүжилт) нөхцлийг зорилтот бүлэгт тодорхойлох дүн шинжилгээг энэхүү их өгөгдлийн мэдээлэл дээр үндэслэн ашиглаж байна. | |
| 97. | 5.1.5.2. Салбарын цахим үйлчилгээг сайжруулах, хиймэл оюунд суурилсан үйлчилгээг нэвтрүүлэх, тэдгээрийг дэмжин ажиллах системийг сайжруулах, шинээр нэвтрүүлэх ажлыг үе шаттай авч хэрэгжүүлнэ. | үйл ажиллагааны зардал 1,074.8 | Суурь судалгаа /тоо/ | 0 | 1 | Судалгаа ба Төлөвлөлт: Салбарын цахим шилжилтийн өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, дараах системийн хөгжүүлэлтийн Ажлын даалгавар (ToR)-ыг боловсруулан батлууллаа:<br>- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (ХАБЭА)-н дэд систем;<br>- eJob системийн сайжруулалт<br>- eFamily үйлчилгээний систем;<br>- Хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээллийн сан;<br>- Хуримтлалын нэгдсэн сангийн систем;<br>- Мэдээллийн аюулгүй байдлын техникийн шинэчлэл.<br>Систем хөгжүүлэлт ба сайжруулалт:<br>- eJob систем: "Дижиталворкс" ХХК-тай гэрээ байгуулан хөгжүүлэлтийг эхлүүлэв. Системийг төрийн үйлчилгээний нэгдсэн системтэй холбож, хэрэглэгчийн интерфейс (UI/UX) болон нэмэлт модулиудыг сайжруулах ажил хийгдэж байна.<br>- Хуримтлалын нэгдсэн сан: Системийн хөгжүүлэлтийг хийж, иргэд Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (e-Mongolia)-ээс хуримтлалын мэдээллээ шууд харах боломжийг бүрдүүллээ.<br>Үйлчилгээний процессын инженеринг:<br>- Протез, ортопедийн үйлчилгээ: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тусламж үзүүлэх процессыг хялбаршуулж зураглав. Шинэ | 100 |
| | | | Боловсруулсан ажлын даалгавар /тоо/ | 0 | 4 | | |
| | | | Сайжруулалтын хийгдсэн системийн тоо; | 0 | 1 | | |
| | | | Шинээр нэвтрүүлсэн цахим үйлчилгээний тоо | 0 | 2 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шийдлээр ehalamj.mn системд эмч нарын хандах эрхийг үүсгэснээр иргэн үйлчилгээ авах эрхтэй эсэхийг үйлдвэр дээрээс шууд шалгах боломжтой болсон. Ингэснээр зөвшөөрөл авах шат дамжлага, хугацааг эрс бууруулав.<br>Цаашдын зорилт: eBarimt системийн шийдэлд тулгуурлан иргэнээс шаарддаг цаасан баримтын тоог бууруулахаар ажиллаж байна. | |
| 98. | 5.1.5.3. Салбарын мэдээллийн аюулгүй байдлыг сайжруулах чиглэлээр арга хэмжээ авч хэрэгжүүлнэ. | үйл ажиллагааны зардал 150.0 | Кибер аюулгүй байдлын эрсдлийн үнэлгээ хийлгэсэн байгууллага /тоо/ | 0 | 2 | Кибер эрсдэлийн үнэлгээ: Мэдээллийн аюулгүй байдлын газар (МАБГ)-аас Яам, ХХҮЕГ, НДЕГ-т тус тус кибер аюулгүй байдлын иж бүрэн эрсдэлийн үнэлгээг хийж гүйцэтгэсэн. Үнэлгээ нь бодлого, дүрэм, систем, сүлжээ, серверийн өрөөний аюулгүй байдлын хүрээнд хийгдсэн.<br>Эрсдэл бууруулах ажил: Үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийн дагуу Эрсдэл бууруулах төлөвлөгөөг боловсруулан, илэрсэн зөрчлүүдийг арилгах арга хэмжээг бүрэн авч хэрэгжүүлсэн.<br>Тайлагнал: Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх тайланг Мэдээллийн аюулгүй байдлын газарт цаг тухайд нь хүргүүлсэн.<br>Техникийн тодорхойлолт: МАБ-ыг сайжруулах хүрээнд сургалт болон нэг системд аудит хийх техникийн тодорхойлолтыг боловсруулан батлуулсан байсан боловч 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдөр батлагдсан Төсвийн тухай хуулийн өөрчлөлтөөр тухайн арга хэмжээний санхүүжилт хасагдсан тул Мэдээллийн аюулгүй байдлын сургалт болон системийн аудит хийгдээгүй, хэрэгжих боломжгүй болсон. | 100 |
| 99. | 5.1.5.4. Салбарын статистикийн эмхэтгэл 2020-2024 гаргана. | УАЗ 50.0 | Эмхэтгэл хэвлэж тархаасан эсэх | 0 | 1 | “Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын статистик эмхэтгэл-2024”-ийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн даатгал, нийгмийн халамж 4 бүлэг сэдэв, 2020-2024 он буюу сүүлийн таван жилийн статистик тоон мэдээллийн хүрээнд нэгтгэн боловсруулж, эмхэтгэлийг хэвлэж, тархаасан. Эмхэтгэлийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | цахим хувилбарыг https://mlsp.gov.mn/content?c=103 харах боломжтойгоор яамны веб-д байршуулсан. | |
| 100. | 5.1.5.5. Салбарын зарим маягт шинэчлэх, шинээр батлуулна. | үйл ажиллагааны зардал | Шинэчлэгдэн батлагдсан маягтын тоо | 1 | 1 | Үндсэн зорилго: Хөгжлийн бэрхшээлтэй хүний нэгдсэн мэдээллийн санг байгуулах ажлын хүрээнд анхан шатны бүртгэл болон мэдээллийн нэгтгэл тайлан гаргах захиргааны маягтуудыг шинээр батлуулахаар бэлтгэсэн.<br>Үйл явц: Маягтын үзүүлэлт, эх сурвалж, мэдээллийн урсгал зэрэгт дүн шинжилгээ, судалгааг хийж, бүртгэл болон захиргааны маягтын төслийг Үндэсний Статистикийн Хороо (ҮСХ)-той хамтран боловсруулж, зөвшилцөн баталгаажуулсан.<br>Дараагийн алхам: Шинэ маягтын төслийг 2026 оны I улиралд багтаан ҮСХ-ны дарга болон Арга зүйн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, эцэслэн батлуулах бэлтгэл ажлыг бүрэн хангаад байна. | 50 |
| | | | Шинээр батлагдсан маягтын тоо | 0 | 1 | | |
| 101. | 5.1.5.6. Салбарын судалгаа, шинжилгээний ажлын хэрэгцээ шаардлагыг тодорхойлж холбогдох байгууллагад хүргүүлнэ. | үйл ажиллагааны зардал | Хэрэгцээ шаардлага тодорхойлсон судалгаа, шинжилгээний ажлын тоо | 0 | 5 | Яамны газар, нэгжээс 2025 онд хариуцах асуудлын хүрээнд хийлгэх судалгаа, шинжилгээний ажлын саналыг авч ХАХНХССХ-нд хүргүүлсэн.<br>Энэ ажлын хүрээнд гэр бүл, хүн амын зорилтот бүлэг, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын чиглэлээр дараах судалгаа, шинжилгээний ажлууд хийгдсэн байна. Үүнд:<br>-Залуучуудын нийгмийн хамгааллын талаарх ойлголт, хандлага судалгаа /судалгааны үр дүнг 2025.12.09-нд тайлагнасан ажлын явц:100%/<br>- ХБХ-ий цахимаар, зайнаас цагаар болон богино хугацааны хөдөлмөр эрхлэх боломж” судалгаа /судалгааны тайлан боловсруулалт хийгдэж байгаа 2025.12.25-нд дуусах, ажлын явц:90% /<br>-Өсвөр үеийнхний хүмүүжил төлөвшилд гэр бүлийн орчин хүмүүжлийн арга нөлөөлөх нь” | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | судалгаа судалгааны тайлан боловсруулалт хийгдэж байгаа 2025.12.25-нд дуусах, ажлын явц:90% /<br>-ХНХ-ын салбарын албан хаагчдын бүтээмжийн судалгаа судалгааны тайлан боловсруулалт хийгдэж байгаа 2025.12.19-нд дуусах, ажлын явц:90% /<br>-Ажлын байрны тоо хэмжээ, хүн амын шилжилт хөдөлгөөнд үзүүлэх нөлөөллийн шинжилгээ /судалгааны дата мэдээллийг боловсруулж, дүн шинжилгээ хийж байна. 90% /<br>- Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлснээр нийгэм, эдийн засагт үзүүлэх үр нөлөөний шинжилгээ<br>/судалгааны тайлан боловсруулалт хийгдэж байгаа 2025.12.19-нд дуусах, ажлын явц:90% /<br>- Халамжийн сангийн зарцуулалтад хийх хүчин зүйлийн шинжилгээ /судалгааны тайлан боловсруулалт хийгдэж байгаа 2025.12.19-нд дуусах ажлын явц:90% / | |
| 102. | 5.1.5.7. Төрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, цахим шилжилтийг нэвтрүүлэх, цаасгүй засаг концепц хэрэгжүүлэх хүрээнд ГБХНХЯ нь дотоод үйл ажиллагаандаа ABLE цахим системийг ашиглалтыг сайжруулна. | үйл ажиллагааны зардал | Ашиглаж байгаа модуль /тоо/ | 5 | 8 | Цахим архивын модуль нэвтрүүлэлт:<br>- Байгууллагын дотоод удирдлагын системд Цахим Архивын модулийг ABLE ХХК-тай хамтран бүрэн нэвтрүүллээ.<br>- Техникийн бэлтгэл (домэйн үүсгэх, серверийн хандалт)-ийг хангаж, системийн "Архив" хэсэгт холбон ашиглалтад оруулав.<br>- Бичиг хэрэг, архивын ажилтнуудад шинэ модулийн талаар 3 удаагийн сургалтыг зохион байгуулж, хэрэглээнд нэвтрүүллээ.<br>Системийн хэрэглээний тоон үзүүлэлт (Тайлант хугацаанд) Үүнд:<br>• Албан бичиг<br>o Ирсэн бичиг – 6844<br>• Цахимаар - 3051<br>• Цаасаар - 3793<br>o Явсан бичиг – 3993<br>• Цахимаар - 2294 | 70 |
| | | | Тухайн жилд Бусад яамд, дээд газар, харьяа агентлаг, байгууллага руу илгээсэн бичигт цахимаар илгээсэн бичгийн эзлэх хувь | 0 | 80% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | • Цаасаар - 1699<br>o Цахимаар төлөвлөсөн бичиг – 3412<br>Удирдлагын баримт бичиг: Нийт 468 тушаал (91 цахимаар төлөвлөсөн, 212 дээд газраас ирсэн, 165 дотоод тушаал) бүртгэж хэрэгжүүлсэн.<br>Дотоод үйл ажиллагаа: Хурлын заалны захиалга 862, Зар мэдээ 311 удаа, Файлын сан 16 файл хуулагдсан байна.<br>Явсан бичгийн цахимжилт 57.5%д хүрсэн нь цаасгүй засаг концепцын хэрэгжилт ахицтай байгааг харуулж байна.<br>Зарим иргэд, төрийн бус байгууллага, албан байгууллага нь цахимаар бичиг солилцох боломжгүй тул бүх бичиг цахимаар харилцах боломж хязгаарлагдмал нөхцөлд байна. | |
| 4.5. САЛБАРЫН САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН БОЛОН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН УРТ, ДУНД ХУГАЦААНЫ БОДЛОГО, ТӨЛӨВЛӨГӨӨ, ХУУЛИЙН ТӨСӨЛ, ТӨСӨВ БОЛОВСРУУЛАХ, БАТЛУУЛАХ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ТӨСВИЙН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ, САЛБАР ХООРОНДЫН УЯЛДАА, БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ, БАТЛАГДСАН ТӨСВИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ, ТӨРИЙН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЭРХЛЭХ СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 2.5.6-ЫН ХҮРЭЭНД: | | | | | | | |
| 103. | 4.5.1.Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд суурилсан 2026 оны төсвийн хязгаарын саналыг нэгтгэн боловсруулж хуулийн хугацаанд Сангийн яаманд хүргүүлнэ. | үйл ажиллагааны зардал | Төсвийн хязгаарын санал /тоо/ | 1 | 1 | - Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын нийт урсгал болон хөрөнгө оруулалтын зардал, нийгмийн даатгалын сангийн орлого, зардлын 2026-2028 оны дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд тусгагдах саналыг нэгтгэн, салбарын бодлого, зорилттой уялдуулан боловсруулж 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 01/998 дугаар албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн. Монгол Улсын Их хурлын 2025 оны 05 дугаар арын 30-ны өдөр баталсан Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс хуваарилах зардлын дээд хэмжээ 2,664.3 тэрбум төгрөгөөр тусгагдсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын урсгал болон хөрөнгө оруулалтын зардал, нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн хязгаарын саналыг дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд суурилан нэгтгэн боловсруулж, нэгдсэн танилцуулга, тайлбар танилцуулгын хамт Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1 дэх хэсэгт заасны дагуу 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 01/1902 дугаар албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. | |
| 104. | 4.5.2.Салбарын бодлого, зорилтыг хэрэгжүүлэх санхүүгийн хэрэгцээг тодорхойлсон төсвийн төсөл боловсруулан хуулийн хугацаанд холбогдох байгууллагад хүргүүлнэ. | үйл ажиллагааны зардал | Төсвийн төслийн санал /тоо/ | 1 | 1 | - Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын 2026 оны төсвийн төсөл, 2027-2028 оны төсвийн төсөөллийг Монгол Улсын Их Хурлаас баталсан дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, Засгийн газрын 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 01 дугаар тогтоолоор баталсан Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2026 оны төсвийн хязгаар болон 2024 оны төсвийн гүйцэтгэл, 2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэл, харьяа төсвийн төвлөрүүлэн болон төсвийн шууд захирагч нараас ирүүлсэн саналд үндэслэн нэгтгэн боловсруулж Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын 2026 оны төсвийн урсгал зарлагыг 5,462.7 тэрбум төгрөг, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны зарлагыг 6,539.1 тэрбум төгрөгөөр тус тус тусгуулах төсвийн саналыг нэгтгэн боловсруулж тайлбар үндэслэл, шалтгаан, дүн шинжилгээ бүхий нэгдсэн танилцуулгын хамт 2025 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 01/2465, 2025 оны 07 дугаар сарын 29-ны өдрийн 01/2505 дугаар албан бичгээр Сангийн яам, Улсын Их Хурлын тамгын газар, Үндэсний аудитын газарт тус тус хүргүүлсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын 2026 оны төсвийн олон нийтийн хэлэлцүүлгийг 2025.07.04-08.10-ны өдрүүдэд яамны цахим хаягт байршуулан цахимаар, 2025.08.08-ны өдөр Төсвийн тухай хуульд заасан оролцогч талуудын төлөөлөл 94 хүнийг хамруулан танхимаар тус тус зохион байгуулж гарсан санал, дүгнэлтийг нэгтгэн дүгнэж 2025.08.15-ны өдрийн 0/2633 дугаар албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. | |
| 105. | 4.5.3.Улсын төсөв, Нийгмийн даатгалын сангийн жилийн төсвийн сар, улирлын хуваарийн саналыг нэгтгэн боловсруулж Сангийн яаманд хуулийн хугацаанд хүргүүлж харьяа байгууллага, тусгай сангуудын дараа жилийн төсвийн орлого, зарлагын гүйлгээ хийх нөхцөлөөр хангасан байна. | үйл ажиллагааны зардал | Батлагдсан сар улирлын хуваарь /тийм-1, үгүй-0/ | 1 | 1 | - Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулиар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын урсгал төсвийн зарлага 4,795.7 тэрбум төгрөг, Нийгмийн даатгалын сангийн зарлага 6,517.5 тэрбум төгрөг, нийт Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багцын төсвийн зарлага 11,313.2 тэрбум төгрөгөөр батлагдсан.<br>-Салбарын харьяа төсөвт байгууллага, тусгай сангуудын 2026 оны төсвийн сар, улирлын хуваарийг бэлтгэн, төсвийн төлөвлөлтийн Fiscal программд байгууллага, хөтөлбөр, арга хэмжээ тус бүрээр шивж оруулан Сангийн яаманд хүргүүлж харьяа байгууллага, тусгай сангуудын 2026 оны төсвийн орлого, зарлагын гүйлгээ хийх нөхцөлөөр ханган харьяа агентлаг, төсөвт байгууллагад хүргүүлэхээр ажиллаж байна. | 100 |
| 106. | 4.5.4.Төсөв захирагч нараас ирүүлсэн хүсэлтийг үндэслэн 2025 оны батлагдсан төсвийн сар, улирлын хуваарьт зохицуулалт хийж, хүсэлтийг зохих түвшинд шийдвэрлэн | үйл ажиллагааны зардал | Хуваарийн өөрчлөлт хийсэн тоо | 12 | 8 | - Засгийн газрын тусгай сангууд болон харьяа төсөвт байгууллагуудын 2025 оны батлагдсан төсөв, төсвийн сар, улирлын хуваарийг бэлтгэн төсвийн төлөвлөлтийн fiscal программд шивж оруулан Сангийн яаманд хүргүүлж, харьяа агентлаг, төсөвт байгууллагуудад Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 01/52 дугаар | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг хангасан байна. | | | | | албан бичгээр харьяа төсвийн төвлөрүүлэн болон шууд захирагч нарт хүргүүлж, хуваарийн дагуу санхүүжүүлэн салбарын үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлөөр ханган ажилласан.<br><br>- Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" хуулийн төсөлд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын урсгал болон хөрөнгө оруулалтын зардалд тусгах санал, тооцоолол, судалгаа болон салбарын бүтцийн өөрчлөлтөөр хасагдах орон тоо, цалингийн сангийн тооцоолол хийж Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын Сайдын 01/1993, 01/2039 дугаар албан бичггээр Сангийн яаманд хүргүүлж, холбогдох албан тушаалтнуудтай уулзан тайлбар, мэдээлэл хүргүүлсэн.<br><br>- Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар батлагдсан Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын харьяа агентлаг, байгууллагуудын төсвийн сар, улирлын хуваарь болон төсвийн хэрэгжилтийг ханган ажиллах тухай чиглэлийг Сайдын 01/2369 дугаар албан бичгээр хүргүүлэн ажилласан.<br><br>- Төсвийн төвлөрүүлэн болон шууд захирагч нараас ирүүлсэн төсвийн сар, улирлын хуваарьт өөрчлөлт оруулах саналыг хянан Төсвийн тухай хуулийн 42.2 дахь хэсэгт заасны дагуу Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөвт зохицуулалт хийх хүсэлтийг 01/342, 01/701, 01/1018, 01/1423, 01/1777, 01/1601, 01/2733, 01/2794, 01/3408, 01/3457, 01/3476, 01/3636, 01/3711, 01/3875 дугаар албан бичгээр Сангийн яаманд тус тус хүргүүлэн шийдвэрлүүлж харьяа төсөвт байгууллагуудын хэвийн үйл ажиллагааг хангах, Засгийн газрын тусгай | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сангаас иргэд, аж ахуйн нэгж байгууллага, ТББ-д олгох тэтгэвэр, тэтгэмж, тусламж хөнгөлөлтийг цаг хугацаанд олгох нөхцөл боломжоор ханган ажиллаж байна. | |
| 107. | 4.5.5.Батлагдсан төсөвт багтаан төлбөр тооцоог гүйцэтгэх, төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг хянаж нэгтгэн хуулийн хугацаанд холбогдох байгууллагад хүргүүлж, удирдлагыг мэдээллээр ханган ажилласан байна | үйл ажиллагааны зардал | Төсвийн орлого, зарлагын өдөр тутмын гүйлгээг хянаж, цахимаар хурдан шуурхай хийж гүйцэтгэх | 12 | 12 | - Сайдын багцад хамаарах төсөвт байгууллагуудын төсвийн зарцуулалтад сар улирлын хуваарийн дагуу сар бүр батлагдсан төсвийн хүрээнд хяналт тавьж ажилласан. Тайлант хугацаанд харьяа төсөвт байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаа тасралтгүй, хэвийн явагдаж салбарын хэмжээнд төсвийн хэтрэлтгүй, хэмнэлттэй ажилласан байна.<br><br>- Гэр бүл, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багцад хамаарах 18 байгууллагын 79 данснаас тайлант хугацаанд 16367 удаагийн төлбөрийн хүсэлтээр 8,493.1 тэрбум төгрөгийн зарцуулалтын гүйлгээ шивэгдсэнийг хянан, баталгаажуулж ажилласан. /2025 оны 12 дугаар сарын 08-ны байдлаар /<br><br>- БНСУ дахь нэг цэгийн үйлчилгээний төвийн 2025 оны урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн гүйлгээг сар бүр зарцуулалтын эрхийн хүрээнд төрийн сангийн удирдлагын цахим систем болон гадаад гүйлгээний программаар хийж гүйцэтгэснийг тухай бүр баталгаажуулж ажиллаласан. Энэ ажлын хүрээнд 13 удаагийн 2.9 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдсэн байна.<br><br>- Төсвийн тухай хууль, НББ-н тухай хууль, “Төрийн сангийн үйл ажиллагааны журам” ЗГСУМ-ын системд мөрдөх журамыг үндэслэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа 18 байгууллага, 21 аймаг 9 дүүргийн ХХҮХ, 21 аймаг 9 дүүргийн ХЭДС, 21 аймаг 9 дүүргийн НДХ, 21 аймаг 9 дүүргийн ГБХЗГ, 6 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | аймгийн хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг хүлээн авч, зардлын гүйцэтгэлийг тулган шалгаж, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогын залруулгыг сар бүр байгууллага тус бүрээр ЗГСУМС-д хийж ажилласан.<br><br>- Мөн дээрхи байгууллагуудын өр авлагын мэдээг нэгтгэж системд бүртгэн, сайдын багцын төсвийн гүйцэтгэлийн мэдээний хамт хуулийн хугацаанд Сангийн яаманд хүргүүлж ажилласан.<br><br>2025 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар Төсвийн тухай хуулиар зарцуулагдах 3,947.3 тэрбум төгрөгнөөс 3,902.3 тэрбум төгрөг зарцуулсан буюу 98.8 хувийн гүйцэтгэлтэй байна. | |
| 108. | 4.5.6.Төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайланг хууль, журмын хүрээнд нэгтгэн боловсруулж, аудитын дүгнэлт гаргуулан хуулийн хугацаанд холбогдох байгууллагад хүргүүлнэ. | үйл ажиллагааны зардал | Санхүүгийн нэгтгэсэн тайлан /тоо/ | 0 | 2 | - Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг хуулийн хугацаанд нэгтгэн гаргаж, нэгтгэсэн тайланд аудит хийлгүүлэхээр 2025 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн 01/1049 албан бичгээр Үндэсний Аудитын газарт хүргүүлсэн.<br><br>- Үндэсний Аудитын газар ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр “Хязгаарлалттай дүгнэлт” өгсөн. Сангийн яаманд 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 1/1319 албан бичгээр ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайланг хүргүүлсэн.<br><br>- ГБХНХЯ-ны аппаратын хэмжээнд Үндэсний аудитын газраас 2024 оны төсөв, санхүү, үйл ажиллагаанд хийсэн аудитын шалгалтаар нийт 5 зөвлөмж, 12 албан шаардлага, 1 хариуцлага | 100 |
| | | | Аудитын дүгнэлт /тоо/ | 0 | 1 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тооцуулах албан шаардлага авсан. Энэхүү 18 зөвлөмж, албан шаардлагын дагуу хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан, батлуулж ҮАГ-т 2025.03.20-ны өдөр хүргүүлсэн. Төлөвлөгөөний дагуу хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.<br><br>- Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг хуулийн хугацаанд нэгтгэн гаргаж, нэгтгэсэн тайланг 2025 оны 8 дугаар сарын 15-ний өдрийн 01/2635 албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн хүргүүлсэн. | |
| 109. | 4.5.7.Шилэн дансны хууль, журмын хэрэгжилтийг хангаж ажиллана. | үйл ажиллагааны зардал | Байршуулсан мэдээлэл /хувь/ | 0 | 100% | - ТЕЗ-ийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн аудитлагдсан тайлан, төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, 2024 оны 12-р сар, 2025 оны 01-11 саруудын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, концессын зүйлийн жагсаалт зэрэг хууль, журамд заасан мэдээллийг хуулийн хугацаан shilendans.gov.mn сайтад байршуулан ажилласан. | 100 |
| 110. | 4.5.8.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хэрэгжих хөрөнгө оруулалтын ажилд явцын хяналт тавьж, гүйцэтгэлд суурилан санхүүжүүлж, мэдээ, тайланг хуулийн хугацаанд хүргүүлнэ. | 52.2 тэрбум төгрөг | Олгосон санхүүжилт /хувь/ | 73% | 85% | - Монгол Улсын 2025 төсвийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн 2 дугаар хавсралтад ГБХНХСайдын багцад шилжих 20 төсөл, арга хэмжээ, шинээр хэрэгжүүлэх 4 төсөл, арга хэмжээ батлагдсан. Үүнээс шинээр батлагдсан тоног төхөөрөмжийн 2 төсөл, арга хэмжээ нь багц ажлууд бөгөөд ГБХНХСайдын 2025 оны А-144, А-145 дугаар тушаалуудаар багц ажлыг хуваарилж нийт 23 төсөл, арга хэмжээ болгон хэрэгжүүлсэн. Төсвийн жилд | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нийт 45 төсөл, арга хэмжээнд 48.7 тэрбум төгрөгийн санхүүжилт батлагдсан. ГБХНХСайдын багцад батлагдсан 48.7 тэрбум төгрөгөөс 2025 оны 12-р сарын 08-ны өдрийн байдлаар улсын төсвийн хөрөнгө оруулалтын 27.9 тэрбум төгрөг, Засгийн газрын 2024 оны 249 дүгээр тогтоолын дагуу барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан 3 төсөл, арга хэмжээний 2.2 тэрбум төгрөгийн гүйцэтгэл, чанарын баталгааны хугацаа нь дууссан 10 ТАХ-нд барьцаа хөрөнгийн данснаас 0.8 тэрбум баталгааны санхүүжилт, нийт 30.9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тус тус олгосон байна.<br>- Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтад ГБХНХСайдын багцад батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдэд Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу шилжих болон шинэ ажилд хяналт тавьж, тус журмын холбогдох тайлан мэдээг сар бүр санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төв байгууллагад хүргүүлэн ажиллаж байна.<br>- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хэрэгжих хөрөнгө оруулалтын мэдээг сар тутам Сангийн яаманд хүргүүлж, "pimis" цахим системд байршуулж байна. | |
| 111. | 4.5.9.Салбарын худалдан авах ажиллагааны хэрэгжилтийг зохион байгуулна. | үйл ажиллагааны зардал | ХАА-ны төлөвлөгөө /тоо/ | 0 | 1 | - Салбарын хэмжээнд Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр дамжуулан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын дагуу харьяа байгууллагуудаас ирүүлсэн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, өөрчлөлтийг тухай бүр цахим системд хянан баталгаажуулж ажиллаж байна. | 90 |
| | | | Тайлан /тоо/ | 0 | 1 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - 2025 оны төсвийн тухай хуулиар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт нийт шинээр 4 төсөл арга хэмжээ батлагдсан бөгөөд Засгийн газрын 2024 оны 233 дугаар тогтоолоор худалдан авах ажиллагааны зохион байгуулах эрхийг ТХААГ-т шилжүүлж нийт 28 багц болгон зохион байгуулах санал хүргүүлж хэрэгжүүлсэн. Шинээр хэрэгжүүлэх 4 төсөл арга хэмжээний хүрээнд 24 багц арга хэмжээг хэрэгжүүлэхээр гэрээ байгуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Холбогдох материалуудыг “pimis” цахим системд байршуулсан.<br><br>- Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн хуралдаанаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг эрт оношлох, эмчлэх тоног төхөөрөмж, эмчилгээ, оношилгооны дэвшилтэт технологийг бүрдүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг Хүүхдийн төлөө сангийн хөрөнгөөс шийдвэрлэсний дагуу тус тоног төхөөрөмж хүлээн авах эмнэлгүүдээс тоног төхөөрөмжийн үнийн мэдээлэл, техникийн үзүүлэлтийн мэдээллийг хүлээн авч нэгтгэн 2025.09.26-ны өдрийн 02/3061 тоот албан бичиг, 2025.10.21-ний өдрийн 02/3348 тоот албан бичгээр Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газарт, хүүхдийн төлөө сангийн хөрөнгөөр худалдан авах тоног төхөөрөмжийн мэдээлэл, үндэсний зөвлөлийн тогтоолыг 2025.10.23-ны өдрийн 01/3386 тоот албан бичгээр Сангийн яаманд тус тус хүргүүлсэн. | |
| 112. | 4.5.10.Гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төслүүдийн төсөл, арга хэмжээний | үйл ажиллагааны зардал | Төлөвлөгөө /тоо/ | 0 | 1 | - Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт гадаад зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төслүүдийн төсөл, арга хэмжээнд Монгол Улсын Сангийн сайдаас ирүүлсэн 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 01/10803 | 100 |
| | | | Хэрэгжилтийн тайлан /тоо/ | 0 | 1 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжилтийг зохион байгуулна. | | | | | дугаартай “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр Монгол улсын 2025 оны төсвийн тухай хуулиар гадаадын зээлийн хөрөнгөөр санхүүжих төслүүдийн ашиглалтад нийт 1,542.5 тэрбум төгрөг батлагдсантай холбогдуулан салбарт хэрэгжүүлж буй гадаад зээлийн төслүүдийн 2025 онд санхүүжих дээд хязгаар болон санхүүжилтийг түр хойшлуулах ажлын жагсаалтыг ирүүлсэн.<br><br>- Үүнтэй холбоотойгоор салбарт хэрэгжүүлж буй төслүүдийг санхүүжилтүүдийг нэмэгдүүлэх зорилгоор ГБХНХСайдын 2025.01.22-ны өдрийн 01/213 дугаартай албан бичгээр төслүүдийн санхүүжих дүнг нэмүүлэх хүсэлтийг Сангийн сайдад хүргүүлж холбогдох арга хэмжээг авч ажилласан.<br><br>- Гадаад зээл, тусламжийн эх үүсвэрээр салбарт хэрэгжиж буй 3 төслийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдийг эрэмбэлэх, зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай төсөл, арга хэмжээнүүдэд санхүүжилтийн хуваарь гарган мэдээг нэгтгэн боловсруулж Сангийн яаманд хүргүүлсэн. Мөн Гадаад зээл, тусламжийн эх үүсвэрээр салбарт хэрэгжиж буй 3 төслөөс 1 төслийн хэрэгжих хугацаа 2025.08.31-нээр дуусгавар болсон бөгөөд тус төслийн хаалтын баланс тайланг баталгаажуулан ажилласан. | |
| **5. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ** | | | | | | | |
| 5.1.1. | Зорилт 1: Хүүхдийн хөгжил, хамгаалал, хүн амын бүлгүүдийн цогц хөгжил, оролцоог | Улсын төсөв | Хэрэгжүүлсэн арга хэмжээ /тоо/ | 0 | 6 | I-IV улирал | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хангах, эрх ашгийг хамгаалах | | | | | | |
| 113. | 5.1.1.1.Сум, хороо бүрд хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан шинээр ажиллуулж, чиглүүлэх, мэргэшүүлэх сургалтыг үе шаттай зохион байгуулна. */ЗГҮАХ 2024-2028 - 2.1.1.7/* | Улсын төсөв 138.4 сая.төг | Сум, хороо бүрд ажиллах нийт нийгмийн ажилтан /тоо/ | 0 | 534 | МУ-ын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.1.7-д "Сум, хороо бүрд нийгмийн ажилтан ажиллуулуулна" гэсэн зорилт дэвшүүлсэн. 2024 онд Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдаж, уг хуулийн 58 дугаар зүйлд 2025 оны 01-р сараас эхлэн сум, хороодод хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан ажиллахаар заасан. Дээрх үндэслэлээр Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 237 дугаар тогтоол гарч, тогтоолын 1 дүгээр хавсралтаар “Сум, хороонд ажиллах хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтны орон тоог тогтоох шалгуур үзүүлэлт, аргачлал”, 2 дугаар хавсралтаар “Сум, хороонд ажиллах хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтны орон тоо”-г нийслэлд 268, орон нутагт 565, нийт 833 албан хаагч ажиллахаар тогтоосон. 2025 оны 12-р сарын 05-ны өдрийн байдлаар **773** хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтныг сонгон шалгаруулж, ажилд томилон, мэргэжлийн удирдлагаар ханган, ажиллаж байна. | 100 |
| | | | Зохион байгуулсан Мэргэшүүлэх сургалт /тоо/ | 0 | 2 | МУ-ын Засгийн газрын 2024 оны 218 дугаар тогтоолоор МУЗГ-ын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталсан. Энэ төлөвлөгөөний 2.1.1.7 дахь зорилтыг хэрэгжүүлэхдээ Сум, хороо бүрд нийгмийн ажилтан шинээр ажиллуулж, мэргэшүүлэх, чадавхжуулах сургалтыг үе шаттай зохион байгуулах бөгөөд 2025 оны зорилтыг нийт шинээр томилогдсон нийгмийн ажилтны 50 хувь нь хамрагдсан байхаар тусгасан. Засгийн газрын тогтоолоор батлагдсан уг арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор нэгдүгээр, 2025 оны 1-р сард ХГБХХЕГ-ын даргын А/242 дугаар | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тушаалаар "Нийгмийн ажилтныг мэргэшүүлэх, давтан сургах хөтөлбөр, журам"-ыг батласан. Хоёрдугаарт, 2025 оны 2 дугаар сард “Нийгмийн ажлын кэйс менежмент”-ийн сургалтын хөтөлбөр, гарын авлага, хүүхэд хамгааллын үйлчилгээний маягт, аргачлал, зааврыг боловсруулж, хэвлүүлсэн. Гуравдугаарт 2025 оны 2-р сарын 1-нээс 05-ны өдүүрдэд Үндэсний сургагч багшийн сургалт хийж, 40 сургагч багш бэлтгэсэн. Сургагч багшийг бэлтгэх сургалтыг Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газартай хамтран Их, дээд сургууль, мэргэжлийн холбоод, нийслэл, дүүргийн Нийгмийн ажилтны төлөөллөөс бүрдсэн баг 5 хоногийн хугацаанд хамтран зохион байгуулж, шаардлага хангасан 40 оролцогчид “Чадавхжуулах, мэргэшүүлэх сургалтын сургагч багш”-ийн гэрчилгээ олгосон. Дөрөвдүгээрт, 2025 оны 02 дугаар сарын 10-наас 28-ны өдрүүдэд шинээр томилогдсон нийт 458 албан хаагчид "Чадавхжуулах, мэргэшүүлэх 40кр цагийн сургалт"-ыг МУ-д үндэсний хэмжээнд 7 бүсэд зохион байгуулсан. Эдгээр шинэ томилогдсон нийгмийн ажилтнуудаас гадна нийт 650 хүн өргөн бүрэлдэхүүнээр оролцсон. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн А/211 дүгээр тушаал батлагдаж, Нийслэлийн хороодод ажиллаж буй шинээр томилогдон ажиллаж байгаа, мэргэшүүлэх сургалтад хамрагдаагүй, гэрчилгээ аваагүй 90 хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтныг болон орон нутагт ажиллаж байгаа 150 орчим НА-д сургалт зохион байгуулж, гэрчилгээ олгож, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах чиглэлийг ХГБХХЕГ-т хүргүүлсэн. Уг арга | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэмжээг ХГБХХЕГ, Сургалт судалгаа, мэдээллийн төв, Нийгмийн ажлын мэргэжлийн холбоод, Багш, мэргэшсэн зөвлөх, сургач багш нартай хамтран 2025 оны 12 дугаар сарын 15-наас 20-ны өдрүүдэд танхим болон цахим хэлбэрээр зохион байгуулж байна. Хүүхэд хамгааллын тухай хуулийг даган батлагдсан журам, стандартыг хэрэгжүүлж, мөрдөх арга зүйн сургалт зохион байгуулж, аймаг, нийслэл, дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар/хэлтсийн 120 албан хаагч, сум, хорооны 623 нийгмийн ажилтныг чадавхжуулсан. ХГБХХЕГ-ын даргын А/45 дугаартай тушаалаар батлагдсан Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх Нийгмийн ажилтныг давтан сургах журмын дагуу мэргэжүүлэх сургалтад хамрагдан гэрчилгээ авч ажиллаж байгаа нийгмийн ажлын мэргэжилтэй нийслэлийн хороодын 155 нийгмийн ажилтанд "Давтан сургах" сургалтыг 2025 оны 12 дугаар сарын 8-9 өдрүүдэд ХГБХХЕГ, ССМТ, МУБИС болон Сургагч багш нартай хамтран зохион байгуулав. | |
| 114. | 5.1.1.2.Хүүхэд хамгааллын тухай хууль, холбогдох дүрэм, журам, стандартыг сурталчлан таниулна. | Улсын төсөв 90.0 сая | Сургалтад хамрагдсан хүн /тоо/ | 7100 | 7300 | 1. Хүүхэд хамгааллын тухай хууль, холбогдох дүрэм, журам, стандартыг сурталчлан таниулах ажлыг яамны Гадаад хамтын ажиллагаа, олон нийттэй харилцах хэлтэстэй хамтран зохион байгуулж, 18 зурагт постор, 9 видеог олон нийтэд түгээсэн.<br>2/Хэвлэл мэдээллийн ярилцлага 13, подкаст Хууль зүйн үндэсний хүрээлэн, Цагдаагийн ерөнхий газартай хамтран бүтээсэн.<br>3/Батлагдсан дүрэм, журам, стандартыг хэрэгжүүлж мөрдөх чиг үүрэг бүхий төрийн байгууллагын албан хаагч 798 хүнд сургалт орж, Орхон, Хөвсгөл, Өмнөговь, Төв аймагт томилолтоор ажилласан.<br>4/ Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ерөнхий газраас 2025 оны 1, 2 дугаар улиралд зохион байгуулсан салбарын албан хаагчдыг чадавхжуулах сургалтад “Хүүхэд, гэр бүлийн талаар төрөөс баримтлах бодлого, чиглэл, салбар дундын хамтын ажиллагаа”, “Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, хүүхэд хамгааллын үйлчилгээний нэг хүүхдэд ногдох дундаж зардлын нормативыг хэрэгжүүлж, мөрдөх нь” сэдвээр сургалт орж, аймаг, дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар/хэлтсийн 120 албан хаагч, сум, хорооны 623 нийгмийн ажилтан хамрагдсан. Мөн аймаг, дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар хэлтсээр дамжуулан Хамтарсан багийн гишүүд, боловсролын, халамжийн, хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтнуудад хүүхэд хамгааллын кейс менежментийн арга зүйг түгээх сургалтыг сум, хорооны Засаг дарга, Хамтарсан багтай хамтран зохион байгуулж, 9 дүүргийн 225 хороо, 17 аймгийн 122 сумын 602 хамтарсан багийн 2882 гишүүдэд хүргэсэн. 5/ Цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах, үе тэнгийн дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 49 сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулж, 50953 хүүхэд, 27610 эцэг, эх асран хамгаалагчийг хамруулсан. 6/Гэр бүлийн боловсрол олгох, хүмүүжлийн эерэг аргын сургалтад нийт 376453 мянган иргэнийг хамруулж, нийт гэр бүлийн 37,7 хувийг хамруулж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад хамрагдсан гэр бүлийг 26,2 хувиар нэмэгдүүлсэн.<br>- Гэр бүлийн боловсрол олгох 671, хүүхэд хүмүүжлийн эерэг арга түгээх чиглэлээр 41, нийт 819 сургагч багшийг бэлтгэсэн. Арга зүйн сургалтад 601 байгууллагын 4789 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | “Эцэг эхийн зөвлөл”-ийн дарга, нарийн бичиг, гишүүдийг хамруулсан. | |
| 115. | 5.1.1.3.Хүүхэд хамгааллын кейс менежмент, нийгмийн ажлын мэргэжлийн удирдлагыг хөгжүүлж, хүүхэд хамгааллын үйлчилгээ шаардлагатай хүүхэд бүрд хүргэнэ.<br><br>*/ЗГҮАХ 2024-2028 - 2.1.1.5/* | Улсын төсөв 10.6 тэрбум | Хүүхэд хамгааллын кейс шийдвэрлэлт /хувь/ | 69.3 хувь | 75 хувь | 2025 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар давхардсан тоогоор 124.488, давхардаагүй тоогоор 21,000 хүүхдэд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлсэн байна.<br>· Үзүүлсэн үйлчилгээгээр нь авч үзвэл:<br>- шуурхай тусламжийн үйлчилгээнд 28.504, - Хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээнд 13.066<br>- хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх үйлчилгээнд - 82,918 хүүхдийг тус тус хамруулсан байна.<br>Хүүхдийн хүчирхийлэд өртсөн төрлөөр нь авч үзвэл:<br>- Үл хайхрах - 8327<br>- Сэтгэл санааны - 3011<br>- Бие махбодын - 2712<br>- Бэлгийн хүчирхийлэл - 312 хүүхэд байна.<br>Үзүүлсэн үйлчилгээгээр нь авч үзвэл:<br>- Иргэний бүртгэлийн үйлчилгээнд - 1205<br>- Сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээнд - 3358<br>- Хууль зүйн туслалцаа үзүүлэх үйлчилгээнд - 1766<br>- Боловсролын үйлчилгээнд - 1580<br>- Эрүүл мэндийн үйлчилгээнд - 2296<br>- Нийгмийн халамжийн үйлчилгээнд - 2296<br>- Бусад үйлчилгээнд 1537 хүүхдийг тус тус хамруулсан байна. /Жилийн эцсийн үр дүнг агентлагаас авч сайжруулна.<br>2025 оны байдлаар эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа 36504 хүүхдэд хүүхэд хамгааллын кейс менежментийн төлөвлөлт гарган хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээг бүрэн хүргэж, үр дүн гарсан 27082 хүүхдийн кейсийг хааж, шийдвэрлэлт 74.1 хувьтай байна. Хүүхэд хамгааллын кейс менежментийн төлөвлөлтийн дагуу хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үргэлжлүүлэн үзүүлж байгаа 9422 хүүхэд байна. | |
| 116. | 5.1.1.4.Төрийн байгууллага, аж ахуйн нэгжид “Хүүхэд хамгааллын бодлого” мөрдүүлнэ.<br><br>*/ЗГҮАХ 2024-2028 - 2.1.1.5/* | Улсын төсөв 80.0 сая | Хүүхэд хамгааллын бодлого мөрдсөн байгууллагын эзлэх хувь | 3.7 хувь | 25 хувь | 1. Төсвийн Ерөнхийлөн захирагчийн аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргатай байгуулсан 2025 оны гэрээнд төр, хувийн хэвшлийн байгууллагад Хүүхэд хамгааллын бодлого мөрдүүлж, хяналт тавьж ажиллах арга хэмжээг тусгасан.<br>2. Улсын хэмжээнд 2025 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар 16585 байгууллага хүүхэд хамгаалын бодлого мөрдөн ажиллаж байна. Үүнээс,<br>- Хүүхэд хамгааллын бодлогоо шинээр баталсан байгууллага өссөн дүнгээр 5416, эцэг, эхийн зөвлөл байгуулсан байгууллага өссөн дүнгээр 9828, хүүхдийн өрөө тохижуулсан байгууллага өссөн дүнгээр 1224, хүүхдийн цэцэрлэг байгуулсан байгууллага өссөн дүнгээр 117 байна. | 70 |
| | | | Баталсан акт /тоо/ | 0 | 1 | Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан Хүүхэд хамгааллын бодлогыг Хүүхэд хамгааллын тухай хууль /Шинэчилсэн найруулга/, Хүүхдийн эрхийн тухай хуультай нийцүүлэн шинэчлэн боловсруулж байна. | |
| | | | Сургагч багш /тоо/ | 0 | 100 | 1/Хүүхэд хамгааллын бодлогыг түгээн дэлгэрүүлэх сургагч багш бэлтгэх сургалтыг 2025 оны 9 дүгээр сард Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газраас зохион байгуулж, 35 албан хаагчийг сургагч багш болгосон.<br>2/ Байгууллага, аж ахуйн нэгжийн дэргэдэх “Эцэг эхийн зөвлөл”-ийг арга зүйн удирдлагаар хангах, эцэг эхийн зөвлөлийн гишүүдээр дамжуулан гэр бүл, хүүхдэд чиглэсэн сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулж,601 байгууллагын 4789 “Эцэг эхийн зөвлөл”-ийн дарга, нарийн бичиг, гишүүдийг оролцсон. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх арга зүйн сургалтыг 31987 албан хаагчдад зохион байгуулж, 7102 албан хаагчийг хүүхэд хүмүүжлийн эерэг арга зүй, хөгжлийн үйл ажиллагаанд хамруулснаас 97,1 хувь 21 аймаг, 2,9 хувь нийслэлийн албан хаагч байна. | |
| 117. | 5.1.1.5.Хүүхэд хамгааллын тухай хууль, холбогдох дүрэм, журам, стандартыг таниулахаар ерөнхий боловсролын дунд сургуулийн сурагчдад шүүх хуралдааны танхимд сургалтыг сар бүр явуулна. | үйл ажиллагааны зардал | Сургалтад хамрагдсан хүүхэд /тоо/ | 0 | 180 | 1/Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны тойргийн шүүхийн Тамгын газартай хамтран 2025 оны 4 дүгээр сард Баянзүрх дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 30 сурагчид хүүхдийн эрхийн талаарх хууль эрх зүйн танилцуулга сургалт зохион байгуулсан. 2/Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 01/3327 дугаар албан бичгээр Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар, 9 дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтэс, Боловсролын ерөнхий газар, Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны тойргийн шүүх, Багахангай, Налайх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны тойргийн шүүхэд Ерөнхий боловсролын ахлах ангийн сурагчдад хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүүхдээс үйлдэх гэмт хэрэг, зөрчлийг бууруулах ажлыг салбар дундын хамтын ажиллагаа, оролцоотойгоор зохион байгуулж ажиллах чиглэлийг хүргүүлсэн.<br>3/ 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх, Чингэлтэй дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтэстэй хамтран “Үе тэнгийн дээрэлхэлтийн эсрэг хамтдаа” сургалт өдөрлөгийг зохион байгуулж, 80 сурагч хамрагдсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 118. | 5.1.1.6.Хиймэл оюун ухааныг ашиглан иргэн бүрийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн нийгмийн үйлчилгээг нэвтрүүлэх хүрээнд E-family платформын хөгжүүлэлтийг эхлүүлнэ.<br><br>*/ЗГҮАХ 2024-2028 - 2.1.1.3/* | Улсын төсөв 13.0 сая.төг | -Суурь судалгаа /тоо/<br>-Эхний загвар төсөл /тоо/ | 0 | 1 | 2025.04.15-ны өдөр үйлчилгээний загвар жагсаалтыг боловсруулан batzul@emg.gov.mn хаягаар хүргүүлэв. Efamily платформ- имонголиад орох эхний 200 мэдээлэл лавлагааг нягталж, дахин багасган хүлээлгэж өгөхөөр бэлтгэсэн. E-mongolia-д https://e-mongolia.mn/guide?id=68ccd29ade8eec38c0e7e7a1 E-family хөтөч орсон. Дотор нь орох агуулга файл бэлэн болоогүй байна. | 70 |
| | | | Системийн агуулга, бүтцийг тодоройлсон эсэх | 0 | 1 | | |
| 5.1.2. | Зорилт 2: Эрүүл насжилтыг дэмжих | Төсөл | Хэрэгжүүлсэн арга хэмжээ /тоо/ | 0 | 1 | I-IV улирал | |
| 119. | 5.1.2.1.Ахмадын хөгжлийн 3 төвөөр дамжуулан идэвхтэй насжилтыг дэмжих загварыг нэвтрүүлнэ. */Алсын хараа 2050- 3.1.13, ЗГҮАХ 2.1.1.18/* | АХБ –ны төсөл 3.0 сая ам доллар | Үйлчилгээний загвар төв /тоо/ | 0 | 3 | Азийн хөгжлийн банкнаас хэрэгжүүлсэн “Олон нийтийн оролцоонд түшиглэсэн ахмад настанд үзүүлэх Урт хугацааны тусламж үйлчилгээний шинэлэг тогтолцоо, үйлчилгээг хөгжүүлэх-ТА 9928 туршилтын төсөл”-ийн хүрээнд ахмад настны Идэвхтэй насжилтыг дэмжих төвийн загварыг 3 байршилд буюу Дархан-уул аймгийн Ахмадын хөгжлийн төв, Сэлэнгэ аймгийн Мандал сумын Эрүүл мэндийн төв, Ачлалт хүүхдүүд ТББ-ын асрамжийн газарт туршин нэвтрүүлж эхэлсэн. 2025 оны жилийн эцсийн тайлангаар Дархан-Уул аймгийн Ахмадын хөгжлийн төв, Сэлэнгэ аймгийн Мандал сумын эрүүл мэндийн төв нь нь кейс менежмент, хөгжил, нийгмийн оролцоо, эрүүл мэндийн үйлчилгээ, ахмадыг хөгжүүлэх сургалт, олон мэргэжлийн багийн үйлчилгээ зэргийг төвдөө суурилан үзүүлж давхардсан тоогоор нийт 18376 ахмад настанг үйлчилгээнд хамруулсан Харин хувийн хэвшлийн Ачлалт хүүхдүүд ТББ нь 2025 оны I улирлын дараагаас үйл ажиллагааны чиглэлээ өөрчилснөөр идэвхтэй | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | насжилтыг дэмжих үйлчилгээг 2025 онд явуулаагүй байна.<br><br>Ахмад настны тухай хуульд заасны дагуу 2025 оноос журмыг баталж, 37 байгууллага идэвхтэй насжилтийг дэмжих үйлчилгээг 15548 хүнд 2025 оны 11 сарын байдлаар үзүүлсэн байна. УИХ-аас 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр баталсан Ахмад настны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулж төслийн үр дүн, сайн туршлагад үндэслэн ахмад настны цогц үнэлгээ хийж, үнэлгээнд суурилан ахмад настны идэвхтэй насжилтыг дэмжих болон асаргааны хувилбарт үйлчилгээг иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх зохицуулалтыг хуульд шинээр тусгасан.<br><br>Хуулийг хэрэгжүүлэх зорилгоор Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/76,515 тоот хамтарсан тушаалаар “Ахмад настанд цогц үнэлгээ хийх, тусламж, үйлчилгээ үзүүлэх журам”, А/75,514 тоот хамтарсан тушаалаар “Ахмад настанд үйлчилгээ үзүүлэх иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагыг сонгон шалгаруулах журам”-ыг батлан 2025 оноос эхлэн мөрдөж байна.<br><br>Үүний дагуу аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсээс ахмад настны идэвхтэй насжилтыг төвийн үйлчилгээ үзүүлэх байгууллагын сонгон шалгаруулалтыг 2025 оны 04 дүгээр сараас эхлэн зохион байгуулсан бөгөөд улсын хэмжээнд Идэвхтэй насжилтыг дэмжих төвийн үйлчилгээг 37 аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагатай гэрээ байгуулан ажиллаж байна. Идэвхтэй насжилтыг дэмжих төвөөр | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ахмадуудад лавлагаа, мэдээллийн үйлчилгээ, ахмад настны хөгжлийг дэмжих үйлчилгээ, ахмад настны зөв хооллолт, дасгал, хөдөлгөөн, эрүүл мэндийг дэмжих үйлчилгээ, зөвлөгөө өгөх үйлчилгээ, сайн дурын үйлчилгээ, гэр бүлийн хүчирхийллээс хамгаалагдах үйлчилгээг үзүүлж байна. 2025 оны 11 дүгээр сарын тайлангаар Идэвхтэй насжилтыг дэмжих 37 төвийн үйлчилгээнд нийт 19,992 ахмад настан хамрагдсан байна. | |
| 5.1.3. | Зорилт 2: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийг хангах, оролцоо, хүртээмжийг сайжруулах | Улсын төсөв | Холбогдох үйлчилгээнд хамрагдсан хөгжлийн бэрхшээлт /хувь/ | 0 | 1 | I-IV улирал | |
| 120. | 5.1.3.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийг аймаг, дүүрэгт байгуулна. */ЗГҮАХ 2024-2028 - 2.1.1.26/* | Улсын төсөв 6.000.0 | Хөгжлийн төвтэй болсон аймаг, дүүрэг /тоо/ | 6 | 8 | АХБ-ны санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах” төслийн хүрээнд тус яамнаас Баянзүрх дүүрэг, Завхан аймагт Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийг барьж, 2026 оны 09 дүгээр сард ашиглалтад оруулахаар төлөвлөсөн. 1.Завхан аймагт баригдах Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийг барих гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг нийт 3 удаа зарлаж, хамгийн сайн тендерээр үнэлэгдсэн “Морин сувд” ХХК-тай гэрээ байгуулсан.<br>2.Баянзүрх дүүрэгт баригдах Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийг барих гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн А/209 тоот тушаалаар батлуулж, тендерийг зарлаж, хамгийн сайн тендерээр үнэлэгдсэн “Хөххайрхан трейд” ХХК-тай 2025 оны 10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дугаар сарын 29-ний өдөр 02/156 тоот гэрээ байгуулсан.<br>3. “Хөгжлийн бэрхшээлтэй хүний талаар авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 164 дүгээр тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тогтоолын төслийг Засгийн газрын 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 212 дугаар тогтоолоор Өмнөговь аймаг дахь хөгжлийн төвийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын харьяанд ажиллуулах Засгийн газрын тогтоолыг батлуулсан. | |
| 121. | 5.1.3.2.Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих төвийг төв, орон нутагт ажиллуулна. | үйл ажиллагааны зардал | Үйл ажиллагаа явуулах төв /тоо/ | 4 | 10 | Улсын хэмжээнд байнгын асаргаа шаардлагатай, боловсролын үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаа хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг дэмжих төвөөр дамжуулан хөгжүүлэх, үйлчилгээнд хамруулах зорилгоор 2025 оны төсөвт 7 тэрбум төгрөг тусгасан байна. 2025 оны байдлаар Улаанбаатар хотод 11, орон нутагт 1 буюу нийт 12 төв ажиллаж, 4.6 тэрбум төгрөгийн гэрээний санхүүжилтээр 635 хүүхдэд үйлчилгээ үзүүлсэн байна. Дэмжих төвд хамрагдсан хүүхдэд хувь хүний үнэлгээ, хэрэгцээнд нь үндэслэн эрүүл мэндийн тусламж, боловсролын дэмжлэг, асаргаа сувилгаа болон хөгжлийн цогц үйлчилгээ хүргэж байгаа юм. Тус үйлчилгээгээр дамжуулан хүүхдийн хөгжлийн ахиц, нийгмийн оролцоо нэмэгдэх төдийгүй асран хамгаалагчдын хөдөлмөр эрхлэх боломж сайжирч, гэр бүлийн амьдралын чанарт эерэг нөлөө үзүүлж байна. Дэмжих төвийн орон нутагт ажиллуулах талаар орон нутгийн Хүүхэд, гэр бүл, хөгжил хамгааллын газрын удирдлага болон Аймгийн Засаг дарга, нийгмийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бодлогын хэлтсийн дарга нарт мэдээлэл өгч ажилласан. | |
| 122. | 5.1.3.3.Хөгжлийн бэрхшээлийн талаарх олон нийтийн ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх багц сургалтын хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж, хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллана<br><br>*/ЗГҮАХ 2024-2028 - 2.1.1.24/* | Улсын төсөв 100 | Төлөвлөгөө /тоо/ | 0 | 1 | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны А/229 тушаалаар "Хөгжлийн бэрхшээлийн талаарх олон нийтийн ойлголт, хандлагыг сайжруулах үйл ажиллагааны зохион байгуулалт, үйл ажиллагааны заавар"-ыг батлуулсан. Уг ойлголт, хандлагыг сайжруулах үйл ажиллагааны зохион байгуулалт нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн өдрийг уялдуулан сар бүр төрийн бүх шатны байгууллага хэрэгжүүлэн ажиллах төлөвлөгөө бөгөөд нийгмийн хариуцлагын хүрээнд хувийн хэвшлийн байгууллага хэрэгжүүлж ажиллахаар батлагдсан болно. Мөн уг тушаалаар батлагдсан зааварт хөгжлийн бэрхшээлийн талаарх олон нийтийн ойлголт, хандлагыг нэмэгдүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүнд ээлтэй, хүртээмжтэй орчны дэд бүтцийн тохируулгын талаар мэдлэг олгох, хүний эрхийг хүндэтгэсэн эерэг хандлагыг төлөвшүүлэхэд чиглэсэн мэдээлэл, сургалт, сурталчилгаа, нөлөөлөл болон олон нийттэй харилцах үйл ажиллагааг нэгдсэн зохицуулалттайгаар, үр дүнтэй хэрэгжүүлэх зааварчилгаа багтсан болно. Тайлант хугацаанд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль тогтоомжийг сурталчлах, хөгжлийн бэрхшээлийн талаар зөв ойлголт, хандлагыг нэмэгдүүлэх мөн Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жил болгон зарласантай холбогдуулан хэвлэл мэдээллийн 12 байгууллагатай хамтран ажиллаж, тус яамнаас зохион байгуулсан өдөрлөг арга хэмжээ, хэлэлцүүлгийг тухай бүр олон нийтэд түгээж ажилласан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Сургалт /тоо/ | 0 | 40 | Хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт, хандлагыг нэмэгдүүлэх сургалтыг 209 удаа зохион байгуулж, 10,124 иргэнийг хамруулсан. Мөн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жилийн хүрээнд салбар дундын уялдааг сайжруулах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хөдөлмөр эрхлэлтийн цогц үйлчилгээг хүргэх, иргэд, ажил олгогчдын ойлголт, хандлагыг сайжруулах, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээг Хөвсгөл аймагт 2025 оны 04 дүгээр сарын 15-17, Дундговь аймагт 2025 оны 05 дугаар сарын 15-16-ны өдрүүдэд, “Баян-Өлгий, Ховд аймагт 2025 оны 10 дугаар сарын 6-9-ний өдрүүдэд зохион байгуулав. Тус арга хэмжээнд нийт 4,172 иргэн тус тус хамрагдсан байна.<br><br>Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын гишүүдийг чадавхжуулах сургалтыг бүсчлэн зохион байгуулж нийт 20 аймаг, дүүргийн салбар комиссын 132 гишүүнийг сургалтанд бүрэн хамруулсан. | |
| | | | Контент /тоо/ | 0 | 100 | "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль тогтоомжийг сурталчлах, хөгжлийн бэрхшээлийн талаар зөв ойлголт, хандлагыг нэмэгдүүлэх мөн Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жил болгон зарласантай холбогдуулан аяны хүрээнд 143 постер, видео контентийг олон нийтэд түгээж, хэвлэл мэдээллийн 12 байгууллагатай хамтран ажиллаж байна. | |
| 123. | 5.1.3.4.Хөгжлийн бэрхшээлтэй хүний бие даан амьдрах эрхийг хангаж, мэдээллийн болон дэд бүтцийн | Улсын төсөв 250 | Үнэлгээний тоо | 0 | 20 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан саадгүй байдал, тэгш, хүртээмжтэй орчныг бүрдүүлэх чиглэлд Төр болон хувийн хэвшлийн 34 байгууллагатай хамтран 62 арга хэмжээг хэрэгжүүлсэн. Тухайлбал Нийтийн тээврийн | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хүртээмжийг нэмэгдүүлнэ.<br><br>*/ЗГҮАХ 2024-2028 - 2.1.1.24/* | | | | | бодлогын газар, “Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо”-той хамтран 2025 оны 05 дугаар сард нийтийн тээврийн үйлчилгээнд явж байгаа зарим автобусны хүртээмжийн байдалд үнэлгээ хийсэн. Тус үнэлгээг “Нийтийн тээврийн үйлчилгээ. Ангилал ба үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага” MNS 5012:2021, “Нийтийн тээврийн үйлчилгээ, тээврийн хэрэгсэлд тавих ерөнхий шаардлага UCS 1603B:2022 стандартыг баримтлан 15 шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн. Үнэлгээнээс гарсан тайлан, санал зөвлөмжийг албан бичгээр Нийтийн тээврийн бодлогын газарт хүргүүлсэн. 421 дүгээр нээлттэй хорих анги, 407-р нээлттэй, хаалттай хорих ангийн объект болон барилга байгууламжид Түгээмэл хөгжил ТББ-тай хамтран дэд бүтцийн хүртээмжийн үнэлгээг хийж, зөвлөмжийг хүргүүлсэн. “Түгээмэл хөгжил” ТББ-тай хамтран “MONGOLIA TRY - 2025” нөлөөллийн арга хэмжээг 06 дугаар сарын 13-ны өдрөөс 24-нд зохион байгуулсан. Тус ажлын хүрээнд ТНБД-ийн “Нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах тухай” тушаалын төслийг батлуулсан ба удирдамж, хөдөө орон нутагт ажиллах төсвийн тооцоо болон хөтөлбөр, ажил гүйцэтгэх гэрээг тус тус гарган баталгаажууллаа. Мөн аймаг болон НЗДТГ-т хамтран ажиллах албан бичгийг хүргүүлсэн. Мөн “Түгээмэл хөгжил” ТББ-тай хамтран ГБХНХЯ-ны барилгын гадна болон дотор орчны байдалд хүртээмжийн үнэлгээг хийсэн. Нийт 135 асуумжийн хүрээнд үнэлэхэд 42.2% нь хүртээмжгүй үнэлэгдсэн байна. Иймд үнэлгээнээс гарсан тайлан, зөвлөмжийн дагуу сайжруулах арга хэмжээг төлөвлөж байна.<br><br>Мэдээллийн хүртээмжийг сайжруулах ажлын | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүрээнд “Зайнаас зөвлөн туслах төв”-ийн 1800-0724 тусгай дугаараар дамжуулан иргэдэд мэдээлэл хүргэх, яам, салбарын үйл ажиллагааг сонсголын бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй хүргэх зорилгоор дохионы хэлмэрч орчуулагч нартай гэрээ байгуулан ажиллаж байна. Эхний хагас жилийн байдлаар дохионы хэлмэрч орчуулагчид дараах үйлчилгээг үзүүлсэн байна. Үүнд:<br>-Зайнаас зөвлөн туслах төвд хандсан нийт 1202 хөгжлийн бэрхшээлтэй хүнд үйлчилгээ үзүүлсэн;<br>-Шүүхийн шийдвэр болон цагдаагийн газраас ирүүлсэн албан бичгийн хүрээнд 8 удаагийн дохионы хэлмэрчийн үйлчилгээ үзүүлсэн;<br>-14 удаагийн сургалт зөвлөгөөнд дохионы хэлмэрч орчуулагч;<br>-Дохионы хэлний анхан шатны сургалт 2 удаа зохион байгуулсан байна." | |
| | | | Зөвлөмж /тоо/ | 0 | 2 | Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай НҮБ-ын конвенцын 9 дүгээр зүйлд хүртээмж, Нийтийн тээврийн үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ шаардлагад нийцүүлэх орчныг бүрдүүлэх чиглэлээр 2025 оны 5 дугаар сард нийтийн тээврийн 6 төрлийн автобусад хшртээмжийн үнэлгээ хийж, үнэлгээнд үндэслэн 2025 оны 6 дугаар сард Нийтийн тээврийн бодлогын газарт автобусны хүртээмжийн үнэлгээ, тайлан, санал зөвлөмжийг ХБХХЕГ-тай хам тран хүргүүлж ажилласан. Хүртээмжийн анхан шатны үнэлгээг 53 байгууллагад хийсэн. Үүнээс 48 байгууллагад зөвлөмж өгч, зөвлөмжийн хэрэгжилтийг хангах төлөвлөгөөг 5 байгууллага ирүүлсэн. Мөн “Хүртээмж ба стандарт” сургалтыг зохион байгуулж, сургалтад нийт 416 иргэн хамрагдсан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 5.1.4. | Зорилт 1: Нийгмийн даатгалын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх | үйл ажиллагааны зардал | Сэтгэл ханамжийн үнэлгээ дээшилсэн хувь | 0 | 10-аас доошгүй | I-IV улирал | |
| 124. | 5.1.4.1. Нийгмийн даатгалын үйлчилгээ, үйл ажиллагааны цахимжилтыг эрчимжүүлнэ.<br><br>*/Алсын хараа-2050 3.1.5, МУЗГҮАХ 2024-2028 2.1.3.2/* | үйл ажиллагааны зардал | Шинээр цахимжуулсан үйлчилгээ /тоо/ | 0 | 1 | • Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны А/101 тушаалаар нийгмийн даатгалын үйлчилгээг их өгөгдөлд үндэслэн иргэдэд цахимаар үзүүлэх бэлтгэл ажлыг хангах Ажлын хэсгийг Хууль зүй, дотоод хэргийн яам, Батлан хамгаалах яам, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар, “Үндэсний дата төв” УТҮГ, “И-Монгол академи” УТҮГ, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын төлөөллийг оролцуулан байгуулан ажилласан.<br>Түүнчлэн, нийгмийн даатгалын SICOS мэдээллийн системийн хөгжүүлэлт хийгдсэнээр хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгох хүсэлтийг 2025 оны 10 дугаар сарын 01-нээс эхлэн цахимаар авч эхэлсэн.<br><br>• Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа шийдвэрлэх үйл ажиллагааг нийгмийн даатгалын SICOS программд холбож, иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг магадалсан шийдвэрийг цахимжуулсан. Ингэснээр эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагаанд даатгуулагч, хүнийг ирүүлэхгүйгээр хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоох, сунгах, цуцлах, хөдөлмөрийн нөхцөл солих асуудлыг цахимаар бүрэн шийдвэрлэх нөхцөл бүрдсэн.<br><br>• Даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалт тогтоох, сунгах, цуцлах, ажлын цагийг | 100 |
| | | | Үйлчлүүлэгч /ажил олгогч, даатгуулагч/-ийн сэтгэл ханамжийн үнэлгээ | 0 | 1 | | |
| | | | МАБ-ын аудит хийлгэсэн байгуулага /тоо/ | 0 | 1 | | |
| | | | Тухайн жилд Бусад яамд, дээд газар, харьяа агентлаг, байгууллага руу илгээсэн бичигт цахимаар илгээсэн бичгийн эзлэх хувь | 0 | 80% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | богиносгох, хөдөлмөрийн нөхцөл солих, хөгжлийн бэрхшээлтэй хүний байнгын асаргааг тодорхойлох, сэргээн засах, сувилал, эмнэлгийн хуудас олгох, хяналт хийхэд шаардлагатай мэдээллийг санамсаргүй түүврийн аргад үндэслэн бүс хооронд цахимаар солилцох, шийдвэрлэх боломжийг бүрдүүлэх ажлыг Эрүүл мэндийн яам, Нийгмийн даатгалын ерөнхий газартай хамтран зохион байгуулж байна. Энэ хүрээнд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн А125/А/212 дугаар “Мэдээлэл солилцох тухай” хамтарсан тушаалыг баталсан. Энэхүү тушаалын хэрэгжилтийг хангах хүрээнд эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын байгууллага хооронд мэдээллийг цахимаар солилцох боломжийг бүрдүүлэх зорилгоор Эрүүл мэндийн яам, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, И-монгол академитай хамтран Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас “WS300187_HealthInsuranceServiceLookup- Эрүүл мэндийн даатгалаар авсан тусламж, үйлчилгээний лавлах сервис”-ийг авч, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Мэдээлэл технологийн төвд хүргүүлсэн бөгөөд тус Төвөөс сервисийг хүлээн авч, нэвтрүүлэх хөгжүүлэлтийг хийж байна.<br>Нийгмийн даатгалын цахим үйлчилгээ авах явцад иргэд, даатгуулагч, ажил олгогчдод тулгамдаж буй асуудлыг илрүүлэх, сайжруулж, гарч буй асуудал, хүндрэлийг шийдвэрлэх арга замыг тодорхойлох зорилгоор SICOS систем https://portal.ndaatgal.mn/ цахим хуудсаар дамжуулан цахим судалгааг 2025 онд зохион байгуулсан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Судалгааг иргэд, даатгуулагчаас нийгмийн даатгалын үйлчилгээг цахимаар авах боломж, тэтгэмжийн цахим үйлчилгээ, цахим системийн ашиглалт талаар 4 асуулт, мөн ажил олгогчдоос цахим системээр тайлан илгээх, мэдээлэл оруулах, системийн ашиглалт сайжруулалтын талаар нийт 9 асуултын хүрээнд авсан бөгөөд 3,201 иргэн, 1,718 ажил олгогч хамрагдсан байна.<br>Судалгаанд оролцсон иргэд, даатгуулагчдын тухайд нийгмийн даатгалын цахим үйлчилгээний талаарх сэтгэл ханамж, үйлчилгээ авах, хэрэглэх явцад хүндрэл, тулгамдаж буй байгаа талаар илэрхийлсэн. Тухайлбал:<br>“Даатгуулагч та нийгмийн даатгалын үйлчилгээг цахимаар бүрэн авч чадаж байна уу?” гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 73% нь тийм гэж хариулсан бол 27% нь үгүй гэж хариулсан байна.<br>“Нийгмийн даатгалын тэтгэмжийн үйлчилгээ авахад ямар нэг бэрхшээл гардаг уу?” гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 63% нь үгүй, 37% нь тийм гэж хариулсан байна.<br>Ажил олгогчдын тухайд шимтгэлийн тайлан илгээх, мэдээлэл оруулах, цахим системийн ашиглалтын талаар дийлэнх нь хангалттай сайн гэж үнэлсэн байна. Тухайлбал:<br>“Нийгмийн даатгалын тайлангаа боловсруулж илгээхэд хялбар ойлгомжтой байна уу?” гэсэн асуултад нийт 1,718 оролцогчдын 89% нь тийм, 11% нь үгүй гэж, мөн 70% нь шимтгэл төлөгчөөр бүртгүүлэхэд хүндрэлгүй, 79% нь цахим системд ажилтан шинээр нэмэхэд хялбар ойлгомжтой, 21% нь бэрхшээлтэй гэж хариулжээ.<br>Мөн цаашид цахим системийн гацалт, ачаалал даах чадвар, хурдыг сайжруулах, хэрэглэгчийн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэрэглэх зааврыг хялбаршуулан тайлбарыг системд байршуулах, өмнөх мэдээллийг харах боломжийг бүрдүүлэх, тайланг Excel форматаар боловсруулах боломжийг бүрдүүлэх зэрэг асуудлыг анхаарах шаардлагатай гэжээ.<br>Нийгмийн даатгалын ерөнхий газар нь 2025 оны А/130 дугаар тушаалаар Ажлын хэсгийг байгуулан тус судалгааны үр дүн болон аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газартай хамтран нийгмийн даатгалын мэдээллийн шинэ системийг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэнтэй холбогдуулан програм хангамжид гарч байгаа алдааг засах, хөгжүүлэлт, сайжруулалт хийх тогтворжуулах, бодлогын даалгавар боловсруулах, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, SICOS системийг сайжруулж ажилласан. | |
| 125. | 5.1.4.2.Өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хуулийн хугацаанд судалж, шийдвэрлүүлнэ.<br><br>-Мэдээ, тайланг хуулийн хугацаанд холбогдох газруудад хүргүүлнэ. | үйл ажиллагааны зардал | Тухай жилд хуулийн хугацаанд судалж шийдвэрлүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн нийт өргөдөл, гомдол, санал хүсэлтэд эзлэх хувь | 0 | 85 хувь | **ГБХНХЯ-нд** иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас 2025 оны 12 дугаар сарын 05-ны байдлаар 2483 өргөдөл, гомдол, санал хүсэлт, мэдээлэл, талархал ирүүлсэнээс 668 бичгээр, цахимаар, иргэд олон нийттэй харилцах төвөөс 1792, утсаар хандсан болон биечлэн уулзсан 19 байна. Үүнээс 2383 нь шийдвэрлэж, 100 нь шийдвэрлэх шатандаа, хугацаа болоогүй байна. Шийдвэрлэлт 96 хувьтай байна.<br>Тус яаманд ирүүлсэн өргөдөл хүсэлтийг авч үзвэл:<br>Хүсэлт: 1074<br>Гомдол: 643<br>Мэдээлэл: 4<br>Санал: 754<br>Талархал: 2<br>Шаардлага 6 байна. | 90 |
| | | | ЗГХЭГ-т хүргүүлсэн | 0 | 4 | ЗГХЭГ-т хүргүүлсэн тайлан 1:<br>**ГБХНХ-ын салбарын хэмжээнд** иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас 2025 оны 3 дугаар | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | улирлын тайлан /тоо/ | | | улирлын байдлаар 14022 өргөдөл, гомдол, санал хүсэлт, мэдээлэл ирүүлсэнээс 3559 бичгээр, иргэд олон нийттэй харилцах төвд 5384, цахимаар 1281, утсаар хандсан 819, биечлэн уулзсан 2979 байна. Үүнээс 13377 өргөдөл шийдвэрлэж, уламжлагдаж ирсэн 98 өргөдөл, 130 өргөдөл бусад байгууллагад шилжүүлж, 515 өргөдөл шийдвэрлэх шатандаа байна. Шийдвэрлэлт 94% байна. Ирсэн нийт өргөдөл, хүсэлтийн 40% нь Нийгмийн даатгалын тэтгэвэртэй холбоотой байна. | |
| | | | Тус яамны СХШҮДАГ-т хүргүүлсэн хагас, бүтэн жилийн тайлан /тоо/ | 0 | 2 | Тайланг эхний хагас жилээр гарган, СХШҮДАГ-т хүргүүлсэн. | |
| | | | Сар бүр гаргадаг мэдээ /тоо/ | 0 | 12 | ГБХНХЯ-ны сар бүрийн үйл ажиллагааны нэгдсэн тайланд 12 удаа холбогдох мэдээ тайланг хүргүүлсэн. | |
| | | | СХШҮДАГ-аас гаргасан маягтын дагуу Төрийн нарийн бичгийн даргын шуурхай хуралдаанд удирдлагуудад танилцуулсан 7 хоног бүрийн мэдээ /тоо/ | 0 | 44 | Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн 7 хоног бүрийн тайланг баасан гаригт бүр Төрийн захиргааны удирдлагын газрын даргад танилцуулж байна. Нийт 44 удаа тайлан гаргасан байна. | |
| | | | | | | | **91.5** |

*Төлөвлөгөөг хянасан:* ***Төсвийн Ерөнхийлөн захирагч***

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД ......................... /Т.АУБАКИР/

*Тэмдэг* ............................

*(огноо)*

*Төлөвлөгөө тайлагнасан:* ***Төсвийн Шууд захирагч***

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА ......................... /Л.МӨНХЗУЛ/

*Тэмдэг* ............................

*(огноо)*

----oOo---